

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-53

1. Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцэх 4-39

2. “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсох 39-53

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 30-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 32 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Жаргалсайхан, Б.Тулга, Б.Уянга, Д.Үүрийнтуяа;
Чөлөөтэй: Д.Батлут, Ц.Даваасүрэн, С.Лүндэг, Д.Энхтуяа, Д.Энхтүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Пунсалмаа.

Хэлэлцэх асуудалтай Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, С.Ганбаатар нар үг хэлэв.

Нэг.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн компанийн Технологийн албаны дарга Б.Мөнх-Эрдэнэ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын референт Р.Дүүрэнбаяр нар байлцав.

Асуулгын хариуг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуултын хариуг хаалттай горимоор хэлэлцэх горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан үг хэлэв.

С.Ганбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.00 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга, Г.Лувсанжамц, Ж.Золжаргал, П.Ганзориг, Г.Очирбат, М.Бадамсүрэн, Х.Жангабыл, Л.Мөнхбаясгалан нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат 16 цаг 37 минутаас 16 цаг 39 минутад хуралдааныг удирдав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан үг хэлэв.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуултын хариуг сонслоо.

Уг асуудлыг 17 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Лхагвасүрэн, мөн компанийн Ерөнхий инженер Ц.Алтансүх, Ерөнхий технологич Д.Өлзийбат, Санхүүгийн газрын дарга А.Батзориг, “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын референт Р.Дүүрэнбаяр **нар байлцав.**

“Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг “Тавантолгой түлш” ХХК-ийн Ерөнхий инженер Ц.Алтансүх танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, Г.Лувсанжамц, М.Бадамсүрэн, Л.Мөнхбаясгалан, Г.Очирбат, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Лхагвасүрэн, мөн компанийн Ерөнхий инженер Ц.Алтансүх, Ерөнхий технологич Д.Өлзийбат, Санхүүгийн газрын дарга А.Батзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаарх “Тавантолгой түлш” ХХК-ийн Ерөнхий инженер Ц.Алтансүхийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 18 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 03 минут үргэлжилж, ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн *ирцтэйгээр* 18 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон Их засаг” танхим
15 цаг 32 минут.

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаан ирц бүрдэж эхэлж байна.

Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

М.Бадамсүрэн гишүүн 6 дугаар тойрог, ирсэн байна. Далайн Батбаяр гишүүн 5 дугаар тойрог, ирсэн байна. С.Ганбаатар 1 дүгээр тойрог, ирсэн байна. П.Ганзориг гишүүн ирсэн байна. Жангабыл гишүүн ирсэн байна, 3 дугаар тойргоос. Ж.Золжаргал гишүүн ирсэн байна, 9 дүгээр тойрог. Лувсанжамц гишүүн ирсэн байна. Л.Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, 7 дугаар тойрог. П.Мөнхтулга гишүүн ирсэн байна, 1 дүгээр тойрог. Г.Очирбат гишүүн ирсэн байна. Д.Пүрэвдаваа гишүүн ирсэн байна. М.Энхцэцэг гишүүн ирсэн байна. Ингээд ирц бүрдсэн учраас өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ингээд Байнгын хорооны хуралдаанд өнөөдөр хэлэлцэх асуудлаа би бас танилцуулъя. Хэлэлцэх асуудлын

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Монголын газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар тавьсан асуултын хариуг сонсоно. Байнгын хороогоор сонсоно.

Дээр нь нэмээд энэ асуудал дээр Монголын ард түмэнд бас мэдээлэл өгөх, санал, бодлыг нь хүргэх Их Хурлын гишүүний үндсэн үүргээ бас биелүүлж, Байнгын хороодын гишүүнд бас идэвхтэй ирцээ бүрдүүлээд ирсэн байна. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал. “Тавантолгой түши” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсоно.

Энэ талаар ийм хоёр асуудлаар өнөөдөр мэдээлэл хийж сонсоно. Монголын ард түмний асуух гэж байгаа асуултуудыг та нар асууна. Хэлэлцэх асуудал дээр саналтай, өөр саналтай гишүүд байна уу?

Далайн Батбаяр гишүүний микрофоныг нээе.

Д.Батбаяр: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр Аж үйлдвэржилтийн байнгын хорооны өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудалд энэ “Эрдэнэс Тавантолгой”, Тавантолгой нүүрсийг чинь аль нь гаргаж байгаа билээ? Айн? Биш Эрдэнэс Тавантолгойн үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаатай танилцах

боломжтой бол энэ асуудлыг хэлэлцүүлж өгөөч гэж яримаар байна. Энэ бол төрийн өмчит үйлдвэрийн газар. Монгол Улсын төсвийн ихэнх хувийг бүрдүүлж байгаа газар учраас тэгээд тэр тусмаа Эрдэнэс Тавантолгойн барьсан нүүрс угаах үйлдвэр гэж маш том байгууламж байгаа шүү дээ. Энэ байгууламж маань ашиглалтад орсон ч хэдий гэсэн үйл ажиллагаагаа эхлээгүй удаж байгаа. Бид нар очиж танилцаж байсан. Тийм учраас энэ асуудлыг энэ байгууллагын үйл ажиллагаатай танилцах ажлыг оруулах саналтай байна.

С.Ганбаатар: Батбаяр гишүүний саналыг ойлголоо. Энэ дээр Батбаяр гишүүн, ингэвэл болох уу? Эрдэнэс Тавантолгой, тэгээд тэн дотор угаах үйлдвэр болон маш олон зүйлүүд байгаа. Дэд бүтцүүд байгаа дээр нь нэмээд биржийн, нүүрсийг биржээр зарж байгаа явдал өнөөдөр гацаанд орчихсон хүнд байдалтай байгаа бас. Ингээд энэ хоёр байгууллага дээр дараалж бэлтгэл ажлыг хангаад Батбаяр гишүүнээр ахлуулж, бусад гишүүд оролцож ирэх долоо хоногт бүх холбогдох байгууллага, шинжээчдийн дүгнэлтүүд, аудитын дүгнэлтүүдийг нь сонсчихоод тэрний дараагийн долоо хоногт би сонсгол, мэдээлэл хийвэл болох уу? Одоо яг бэлтгэл ажил хангалттай биш байна гэж би ойлгож байна. Батбаяр гишүүн микрофонд.

Д.Батбаяр: Би бас нэлээн хэдэн ажлын хэсэгт байгаад байгаа. Ахиад өөрийн намын дүрмийн ажлын хэсэг энэ тэр гээд ажлын хэсэгт байгаад байгаа учраас яг ахлах тал дээр бас цаг зав жоохон асуудалтай байна л даа. Тийм учраас та тийм, бодож үзээрэй.

С.Ганбаатар: Хугацааны хувьд болж байна.

Д.Батбаяр: Тийм.

С.Ганбаатар: Батбаяр гишүүний саналыг хэдүүлээ ярилцаад өнөөдөр хэлэлцэхэд бас бэлтгэл ажлаа хангах үүднээсээ дараагийн удаа биржийг би бас нэмж байна. Энэ уул уурхайн бирж, тэгээд Эрдэнэс Тавантолгойн үйл ажиллагаа холбогдох бусад тэр угаах үйлдвэр болон дэд бүтэц, тэр олон асуудлууд бас яригдаж байгаа асуудлуудаар мэдээлэл аваад, нарийвчилсан судалгаатай мэдээлэлтэйгээр дараагийн удаа сонсголд оролцуулахаар ийм санал хэлж байна гэж би ойлголоо. Энийг би хүлээж авлаа. Тэгээд бэлтгэл ажлыг хангаад ярья.

Хэлэлцэх асуудлыг Монголын газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар тавьсан асуулгын хариуг сонсох, Тавантолгой түши компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсоно гэсэн хоёр асуудал хэлэлцэх асуудлыг батлах уу?

Өөр санал байхгүй учраас баталъя. Хэлэлцэх асуудалдаа орё.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалангийн Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Монголын газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар тавьсан асуултын хариуг сонсьё.

Одоо та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг урьж оролцуулъя. Албан тушаалтнуудын нэрсийг надад өгөх үү, өгсөн үү? Энэ дотор байна уу? Энд байна. Суудал, байрлалаа эзэлсэн бол та бүхэнд Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайд хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцэх үед оролцох албаны төлөөллүүдийг та бүхэнд танилцуулъя. Албан тушаалтнуудыг танилцуулъя.

С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. *Жавхланбаатар* байна уу? Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороог та нар хүндэтгэх ёстой шүү. Өнөөдөр Уул уурхайн яам, хүнд үйлдвэрийн яам асуудлыг чинь ярьж зовлон, жаргалыг чинь сонсож, асуудлыг шийдэх гэж өнөөдөр хуралдаж байгаа болохоос биш, ямар өнөөдөр ингэж хуралдаад өгөөч, мэдээлэл сонсгоод өгөөч, бидний асуудлыг шийдэж өгөөч гэж ярих ёстой байтал чинь бид өөрсдөө, гишүүн өөрсдөө санаачлаад явж байгаа шүү дээ.

Жавхланбаатар хэзээ орж ирэх юм? Хурлаа тэр хүртэл хойшлуулах юм уу, яах юм? Танилцуулга дуусах хооронд ирэх ёстой шүү. Бид асуулга байгаа шүү. *С.Жавхланбаатар* Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргыг яаралтай дуудаарай. *Б.Анхбаяр* Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, *Ч.Хишигдалай* Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга, *Түвшинжаргал* “Эрдэнэс Тавантолгой” компанийн Дотоод хяналт, эрдсийн удирдлагын газрын захирал? Ирсэн байна. *Гантулга* “Эрдэнэс Тавантолгой” компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга сая үнэхээр гачигдал гараад явсан. Тэгэхдээ орлож байгаа хүнээ заавал байлгаарай гэсэн. Орлож байгаа хүн нь ирсэн үү, байгаа юу? Өөрөөр хэлбэл бид энэ санхүү, хөрөнгө оруулалттай асуултауд их байгаа шүү дээ. Тийм учраас хариулах хүн нь байна гэж ойлголоо шүү. *Ц.Анх-Од* “Эрдэнэс Тавантолгой” компанийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга байна, *Д.Алтанцэцэг* “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, *Б.Мөнх-Эрдэнэ* “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХК-ийн технологийн албаны дарга? Байна, ирчихсэн байна. Ингээд албаны хүмүүсээ би танилцууллаа.

Та бүхэнд мэдээллээ хийхийг хүсэж байна.

Д.Алтанцэцэг: Сайн байцгаана уу?

С.Ганбаатар: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон дээр нээгээд сонсгоё.

Д.Алтанцэцэг: Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд, Үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүд та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Миний нэр *Алтанцэцэг* “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. Та бүхэнд газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаар ер нь үүх түүхтэй нь ингээд товчхон танилцуулчихъя гэж бодож байна. Хурдан ярихыг хичээнэ. Араас нь асуулт их байгаа учраас.

Юуны өмнө та бүхэндээ хэлэхэд “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” гэдэг компани анхандаа Монгол Улсад газрын тосны үйлдвэр барихаар байгуулагдсан боловч бид нар шаардлагаар ингээд дагалдах төслүүд хэрэгжүүлдэг. Манай гол төсөл мэдээж газрын тосны үйлдвэр. *Дорноговь* аймгийн *Алтаниширээ* сумын нутагт баригдаж байгаа.

Хоёр дахь төсөл маань болохоор энэ үйлдвэрийн түүхий эдийг тээвэрлэх газрын тосны *Давст*, уучлаарай газрын тосны *Тосон* уул-19 талбайгаас үйлдвэрийн талбай хүртэл 530км түүхий тос дамжуулах хоолой. Энэ бас Монгол Улсдаа анхны газрын тос, байгалийн хий дамжуулах анхны том дэд бүтэц болж байгаа юм.

Мөн газрын тосны үйлдвэрийн хотхон. Энэ бол бас нийгмийн шаардлагаар урган гарч ирсэн. *Дорноговь* аймагт манай үйлдвэрийн 500, 600 ажилчид нэн түрүүнд доод тал

нь ажиллана. Тэгэхээр энэ ихэнх нь залуучууд байдаг. Залуу гэр бүлийг орон сууцтай болгох, нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор энэ юутай.

Хоёрдугаар гол зорилго бол энэ хотхонд бол үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцох гадаадын бас, гадаад, дотоодын гэрээлэгчдийг оролцуулснаар бид нар хөрөнгө оруулалтын зардлыг нэлээд хэмжээгээр ингээд бууруулах ийм арга хэмжээ авч байгаа юм.

Энэ дэд бүтцийн төсөл бол манай хамгийн хурдан явагдсан Монголын Засгийн газрын шийдвэрээр Хөгжлийн банкны санхүүжилтээр явагдсан төсөл байгаа. 2018 оны, онд Засгийн газрын тогтоол шийдвэр гарчхаад, 2 жилийн дотор ингээд баригдаад 19 оны 10 дугаар сард хүлээлгэж өгсөн, Сайншандыг газрын тосны үйлдвэртэй холбосон төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугам, мөн Барилга, хот байгуулалтын яамны хариуцаж хийсэн үйлдвэрийн талбай, тэгшилгээ, хашаа барих энэ Энэтхэгийн Засгийн газар 17 онд ирж зээлийн шугам дагаж мөрдөх журмыг танилцуулахдаа энэ Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээл бол зөвхөн үйлдвэрийг барихад зарцуулагдана шүү. Тэгэхээр энэ улс оронд цоо шинээр салбар бий болж байгаа учраас дагалдаж гарах наад зах нь дэд бүтэц, энэ эрчим хүчтэй холбоотой энэ асуудлуудыгаа танай Засгийн газар өөрсдөө шийдээрэй гэсэн ийм бас танилцуулга явсны дагуу ингээд төр засгаас түргэн шуурхай шийдвэр гаргаад, ингээд энэ дэд бүтцийг барьж байгуулсан.

Мөн дээрээс нь аль ч улс орны газрын тосны бас ийм интегрэйтэд ийм компани болгохын тулд газрын тосныхоо нөөц, баялгийг бас мэдэх ёстой байдаг юм байна. Тэгэхгүй бол бид яах вэ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 3 сарын 17-нд гарсан зөвлөмжөөр Монгол Улс газрын тосны үйлдвэр баривал өөрийнхөө тосыг боловсруулна гэсэн ийм зөвлөмж байдаг.

Тэгтэл бидний, бид бас газар доорх тосоо Монголчууд өөрсдөө бас сайн мэдэхгүй байгаа. Хайсан, олборлодог хоёр компани Хятадынх. Сая сүүлд энэ Америк, энэ Их Британийн хөрөнгө оруулалттай Петро мат-д Монгол хүний нээсэн цооног дээр бас тос олборлолт ингээд эхэлж байна. Энэ бол манай компанийн хэрэгжүүлж буй төслүүд.

Ингээд та бүхэн мэдэж байгаа энд би энэ зургийг яах гэж харуулсан юм гэхээр манай газрын тосны үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зардлын тухай та бүхэн асуух байх. Тэгэхээр хамгийн гол юм нь юу ойлгох ёстой юм гэхээр анхан энэ үйлдвэр 1 тэрбум долларын өртөгтэй байгаагүй юм шүү. Энэ 1 тэрбум доллар гэдэг бол 2015 онд Энэтхэгийн Ерөнхий сайд манай Ерөнхийлөгчтэй уулзахдаа Энэтхэгийн Засгийн газраас 1.75 хувийн хүүтэй Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээлийг танай улсын хөгжлийн төсөлд зориулж ингэж олгох боломж байна. Энийг Монголын Засгийн газар 2017 оны 2 сард шийдэхдээ ямар ч байсан энэ хөрөнгөөр газрын тосны үйлдвэр барья гэж шийдээд ТЭЗҮ-г нь хийлгээд үзсэн.

Ингээд ТЭЗҮ-г нь хийлгээд үзэхэд 17, 18 онд хийсэн ТЭЗҮ-гээр үйлдвэрийн бүтээн байгуулалтын зардал бол хамгийн доод тал нь тэрбум 236 болох юм байна. Тэрбум 480 гэсэн тоотой байсан анхан.

Тэгэхээр бид нар энэ 1 тэрбумаас хол давж байгаа учраас техникийн хувьд олон буултууд хийсэн. Жишээ нь, уурын турбиныг, бид газрын турбиныг нь уурын турбин болох жишээтэй гэх мэтчилэн бид нар техникийн хувьд буултууд хийж байгаад тэрбум 236 гэдэг тоог Эрдэс, уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулсан юм.

Энэ Монгол Улсад газрын тосны үйлдвэр барьж байсан түүх бол бараг 60 жилийн өмнө Оросууд барьж өгч байсан Зүүнбаянд. Тэгэхээр бид Монгол Улсад мэдлэг туршилагатай хүн байхгүй, техник технологи нь байхгүй учраас ТЭЗҮ-д хөндлөнгийн хяналт хийх шаардлага гарсан. ТЭЗҮ-ийг Энэтхэгийн төрийн өмчит газрын тосны, зөвхөн Энэтхэгтэй биш олон улсад маш нэр хүндтэй “Инженерс Индиа” гэж компанид боловсруулсан. Тэгэхээр бид бас өөрсдөө хөндлөнгийн хяналт тавиулах ёстой учраас олон улсад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас нээлттэй тендер зарлаж байгаад Италийн Инетикс, Техноложипромет гэж хоёр компанийн түншлэлээр энэ ТЭЗҮ-д 10, жил хагасын турш хяналт тавиулсан.

Ингээд Италийн компаниуд бид нарт бол маш их тусалсан. Бид нар асар их мэдэхгүй юмаа мэдэж авсан, техникийн олон сайжруулалт хийсэн энэ хооронд. Энэ ингээд газрын тос боловсруулах үйлдвэрийн тэр ТЭЗҮ гэдэг бол энэ үйлдвэрийг Монгол Улс барьж чадах юм уу, чадахгүй юм уу, хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу гэдэг асуултад хариулт өгдөг судалгааны баримт бичиг тийм үү, ингээд 19 оны эхээр эцэслээд, энийг барих нь хэрэгтэй юм байна. Монгол Улсын эрчим хүчний бие даасан байдал, цаашилбал улс үндэстний тусгаар тогтнолтой холбоотой бас энийг ер нь ямар ч байсан гэсэн барья гэсэн шийдвэр гараад, 2019 онд инженерчлэл гэдэг ажлаар бол үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил эхэлж байгаа юм.

Ингэхээр инженерчлэл хийхийн өмнө олон улсын томоохон аж үйлдвэрийн төслийн жишгээр төслийн менежментийн зөвлөх гэдэг компани авдаг. Энэ бол бид нар Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа учраас тэр улс өөрийнхөө бүх улсад хэрэгжүүлж байгаа төсөлтэй ижил төсөлд дагаж мөрддөг журмыг бид нарт танилцуулсан. Тэр дээр зөвлөх болоод гүйцэтгэгч бүх компани Энэтхэгийн компани байна гэсэн ийм үг, үсгээр эхэлдэг.

Ингээд Энэтхэгийн “Engineers India” компани бол ингээд үргэлжлүүлээд манай үйлдвэрийн төслийн менежментийн зөвлөхөөр ажилласан. Энэ компанийн онцлог бол зөвхөн менежмент хийгээгүй. Энэ компани бол үйлдвэрийн зураг, төсөл, худалдан авалт, барилга угсралт бүх үе шат, улсын комисс хүлээлгээж өгөх хүртэл энд бол манай Монголын Засгийн газрын Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн өмнөөс хяналт тавьдаг ийм компани юм байгаа юм.

Дээрээс нь энэ компани инженерчлэлийн 5 үе шатын зарим лицензгүй технологийн байгууламж болоод дагалдах туслах бүх байгууламжуудын ерөнхий зураг, төслийг хийсэн компани.

Ингээд үйлдвэрийн бүтээн байгуулалт 4 багц ажлын хүрээнд хэрэгждэг эхнийх нь бол технологийн бус барилга, байгууламж буюу бусад барилга, байгууламжуудыг барих суурийг тавьж байгаа юм. Манай үйлдвэр бол онцлог нь юу вэ гэхээр бүх зүйлийг эхнээс нь барьж байгаа. Бид нар сая хэллээ зам харгуйгаасаа эхлээд л. Ингэхээр энэ технологийн барилга, байгууламжуудын ажил бол 2021 онд яг ид КОВИД-ын үед эхэлсэн. Бид нар ямар ч байсан гэсэн гэрээ байгуулсан үнийн дүнгээрээ хичээсээр байгаад ингээд бариулж дуусгалаа. Энэ хооронд бол энэ компани тэр чартер, хамаг юмны үнэ өссөн, олон шалтгаанаар Монголын талаас нэхэмжлэл гаргасан. Энэ бол бид нар гэрээнийхээ хүрээнд яриад энэ дээр өөрийнхөө би компанийн Гэрээ, эрх зүйн газар, манай санхүү, эдийн засаг, манай компанийн мэргэжилтнүүд үнэхээр хичээж ажилладаг. Ингээд гэрээний дүнг өөрчлөхгүйгээр сая ажлыг дуусгаад улсын комисст хүлээлгээж өглөө.

Хоёр, гуравт, хоёрдугаар багц ажлаар үндсэн технологийн байгууламж эхэлж байгаа.../минут дуусав./

С.Ганбаатар: Алтанцэцэг дарга микрофон нэмж өгье. Нэмж өгье.

Д.Алтанцэцэг: Товчхон ярья. Энэ та бүхэн харж байна. Саяын ногоон буюу эхний технологийн бүс, барилга, байгууламжийн ажлын хүрээнд бид нар 89.9км урт шугам хоолой, цахилгаан дамжуулах шугам, тэгээд үйлдвэрийн талбайд 11 эрэл, иргэний байгууламж, усны нөөцийн сав гэх мэтчилэн ингээд бүх юмыг бариад бэлэн болгоод ингээд дуусгалаа.

Үүнтэй холбогдуулаад энэ объект ч, төр шинээр өмчтэй болчихлоо. Энийг чинь арчлах, хамгаалах зардал гарч ирнэ. Энийг бид нар өнгөрсөн жилээс эхэлж л, өнгөрсөн оны сүүлээс л Засгийн газарт тавиад байгаа. Харуул, хамгаалалт, хулгай зэлгий их байна. Ингээд л эрчим хүч гэж ашиглаад л эхэлнэ. Улсын комисст хүлээлгэж өгөөд л маргаашаас нь энэ захиран зарцуулах асуудлаа та нарын хэн чинь шийдэх юм бэ, хэн хариуцах юм гэдэг. Тэгэхдээ энэ дээр Засгийн газар ажиллаад ерөнхийдөө шийдлүүд олоод явж байгаа.

Хоёрдугаар багц ажил бол үндсэн технологийн байгууламжууд. Энэ дээр бол асар их шугам хоолой баригдана. Шугам хоолойн тулгуур баригдана. Нийтдээ 500км шугам хоолой, атмосферийн нэрлэгийн, вакум нэрлэгийн байгууламж, ... хий ялгах байгууламж гээд. Дээрээс нь энэ 40 орчим энэ газрын тос завсрын бүтээгдэхүүн болон бэлэн бүтээгдэхүүний агуулах сав, парк баригдана. Бүтээгдэхүүний ачих, буулгах байгууламж баригдана. Энэ ажил бол эхэлсэн. Энэ ажил 2022 оны 10 сарын 28-нд гэрээгээ байгуулсан. “ЕСР” гэрээ. Энэ бүх ажлууд “ЕСР” гийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралт буюу түлхүүр гардуулах нөхцөлтэй ийм олон улсын FIDIC гэрээний мөнгөн номыг дагаж мөрдөж байгаа ийм гэрээ байгаа юм.

Одоо ЕСР-2 дугаар ажлын зургийг, ажлын зургийг нь Intecsa Испанид хийдэг. Тоног төхөөрөмжийн захиалгууд бол эхнээсээ хийгдээд эхэлчихсэн, үйлдвэрлэл эхэлсэн. Тухайлбал, тэр технологийн зуухыг Францын Axens-ын охин компани Ардэй, давсгүйжүүлэх байгууламжийн Intecsa, АНУ-ын Forum energy гэх мэтчилэн бас ингээд энэ газрын тосны үйлдвэр, нефть, химийн үйлдвэрийн чинь салбар чинь дэлхий дээр ингээд бүр дотор нь удаан ажиллаад байхаар ойлгомжтой байдаг юм байна. Тэр юмыг нь тэр л компани хийдэг, тийм 3 газар л үйлдвэрлэдэг, зургийг нь тэр л хийдэг гээд.

Ингээд та бүхэн ажлын явцыг харж байна. Манай үйлдвэрийн талбай дээр бас Үйлдвэржилтийн байнгын хорооныхон, энэ жилдээ ингээд өвөл рүү шилжиж байна. Хавар дулаарангуут бас очиж үзээсэй гэж бодож байна.

Шугам хоолойн тулгуур гэдэг ажлууд хамгийн түрүүнд хийгдэх ёстой. Тэр олон зуун км шугам хоолой хамгийн түрүүнд тавигдах ёстой.

Ингээд энэ жил хамгийн гол нь суурийн бетон цутгалтын ажлыг 40 мянган м3-ийг хийж чадах уу, үгүй юү гэдэг дээр байсан. Одоо бид нар яг 39 мянган м3 дээр өнөөдөр явж байна. Ингээд төлөвлөгөөгөө биелүүлж байна. Стокадын ган хийцүүд байна. Ган хийцүүд бол хагас, бэлэн бүтээгдэхүүн гэсэн учраас Энэтхэгийн тэр зээлийн юуныхаа юугаар өөр орноос бас авч болдог юм байна. Энийг бол Хятадын Хайнанд хийж байгаа. Тэгээд деталь ярихгүй жоохон.

Энэ жил үйлдвэрийн талбайд ингээд энэ энэ “ЕСР” гэрээлэгчийн 1500 гадаад ажилчин үйлдвэрийн талбайд ажиллалаа.

Хоёрдугаар багц ажлын бас гол ажил бол үйлдвэрийн энэ хянах байрууд байгаа. Мониторинг төвүүд байж байгаа.

Гуравдугаар багц ажил болохоор үйлдвэрийн цахилгаан станц байж байгаа. Би түрүүн тэр агуулах сав энэ тэрийг ингээд ярихад бас манай Монголд одоогоор манайх үйлдвэр газрын тосны бүтээгдэхүүний л агуулах сав байдаг. Хамгийн том нь 8 мянган буюу 10 мянга, 8 мянга билүү, 10 мянган м3 байдаг. Манай түүхий тосны агуулах сав бол хамгийн том нь 40 мянган м3, 45 мянган м3. Өөрөөр хэлбэл, диаметрээрээ бол Бөхийн өргөө энэ тэр шиг ийм том овор ихтэй байгууламжууд баригдаж байгаа.

Үйлдвэрийн Дулааны цахилгаан станцын уурын турбинийг Сименс/ Siemens/-ийн захиалгаар хийгдэж байгаа. Германы.

Бойлерыг Foster wheeler Их Британийнх байсан. Сүүлд Wood-эд орчихсон байна лээ. Испанийн Foster wheeler-ийн захиалгаар үйлдвэрлэгдэж байна. Энэ үйлдвэрийн цахилгаан станцын үндсэн өгөгдөл бол 265 тонн.цаг хурц уур үйлдвэрлэнэ. 35мвт хүчин чадалтай. Ингээд ажлын явцыг та бүхэн ингээд бас харж байна.

Нийт зураг, төслийн ажил өнөөг хүртэл зохиогдсон, батлагдсан зураг бол 100-аад мянган зураг, төслөөр яригдаж байна.

Хамгийн бид нарын эмзэг цэг энэ 4 дүгээр багц ажил буюу олон улсын нефть химийн салбарын технологи хөгжүүлэгч, энэ газрын тосны салбарын энэ магнайтуудын зохиосон технологийн патенттай байгууламжууд байж байна. Заавал эдгээрийн байгууламжийг патентаар нь хийдэг. Энэ лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулах асуудал бол 20 онд эхэлсэн. Энийг 19 онд сүүлээр эхэлсэн.

Тэгээд манай үйлдвэрийг бас тэр болгон сонирхохгүй тэд нар чинь. Яагаад гэвэл овор нь хэтэрхий бага. Жишээ нь, бензин боловсруулах үйлдвэрийн изомержуулалт гэдэг байгууламж бол жилийн урсгал нь 88 мянган тонн гэхээр энэ UOP Honeywell, Shell Шеврон, тэр Хайлер ... энэ тэр чинь манайх ийм жижигхэн урсгалтай ийм юу хийдэггүй энэ тэр гэх жишээтэй. Энийг тэгэхдээ Engineers india байгаа тулдаа бид нарт энийг бас нээлттэй зарладаг дэлхийд. Тэгээд энэ технологийн лиценз эзэмшигчдийн энэ юуг бол бас маш хүндрэлтэй үе шат байсан. Энийг даван туулаад, энэ концернүүд өөрсдийнхөө тухайлсан тухайлсан байгууламжийнхаа ерөнхий зураг, төслийг нь 22 оны сүүлчээр манайд ингэж нийлүүлсэн.

Ингээд гэрээ байгуулж байгаа үе бас ингээд хүнд үе таарсан. КОВИД, цар тахал. Аялж, явж болдоггүй.

Ингээд та бүхний хамгийн сонирхож байгаа хэсгийг одоо ярья.

ЕСР-4 багц ажлыг ингэсэн юм хүмүүс ээ. Ер нь бол үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын зардал юугаар тооцогдож байна вэ гэхээр тендерт ирүүлж байгаа үнээр тооцогдож байгаа юм. Тендерт, бид нар яагаад гэвэл хар аа өнөөдөр бас Засгийн газрын гишүүдээс ингээд бид нарт тавьж байгаа асуулт юу вэ гэхээр бид нар өөрсдөө ингээд төсвөө зохиож байгаа юм шиг юм ярьж байгаа юм.

Тэгэхээр ЕСР гэрээ гэхээр бид нар олон улсад тендер, олон улсад байснаа Энэтхэгт тийм үү тендер нээлттэй шалгаруулаад түүнээс ирсэн дүнгээр нь үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын зардал тодорхойлогдож байгаа юм.

Ингээд бид нар ямартай ч байсан гэсэн энэ үйлдвэрийн бүтээн байгуулалтад ингээд дутахаар юм байна, тэрбум 236-аас давахаар юм байна. Тэгэхээр ингээд ямар ч байсан батлагдсан үнийн дүндээ багтаагаад 4 дүгээр багц ажлынхаа эхний хэсгийг байгуулж байя гэдэг шийдвэр Засгийн газар өнгөрсөн жилийн 9 сард гаргаад байгуулсан боловчиг Энэтхэгийн Экзим банк нийт хөрөнгө оруулалтын зардал шийдэгдсэн тохиолдолд энийг зээлийн шугамд оруулна гээд энийг зээлийн шугамд оруулаагүй.

Тэгэхээр би гишүүд та бүхэндээ зээлийн энэ тодотголын талаар нэг юм хэлж өгье.

Хөрөнгө оруулалтын зардал бол тэрбум 236 байж байгаад тэрбум 658 буюу 34 хувиар өссөн. Энэ хөрөнгө оруулалтын зардал өссөн энэ шалтгаан бол бид бүгдээрээ мэдэж байгаа. Дэлхийн зах зээл дээр бараа материал, техник, тоног төхөөрөмж, ажил үйлчилгээний зардал өссөн үү гэвэл өссөн.

Хоёрдугаарт, бид нар тэр ТЭЗҮ гэдгийн дараа инженерчлэл эхлэхэд маш олон төрлийн оновчлолууд хийх шаардлагатай болсон. Одоо би дараа нь ямар ямар оновчлол хийгдсэн гэдгээ ярьж өгнө. Тэгэхээр ингээд яг барихдаа тулаад л ингэхэд бид нарт тэнд ч нэг ийм юм, юу энэ ч ийм шаардлагыг сайжруулах шаардлагатай, лиценз эзэмшигч заавал энэ тоноглол шаарддаг гээд ийм маш нарийн олон мянган юм гарч ирдэг.

Тэгэхээр ингээд бид нарын хамгийн гол нь оновчлолын гол зорилго бол юу байсан гэхээр техник, технологийн эдэлгээг уртасгана, түвэгшилтийг бууруулах, дээрээс нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх алсдаа, байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах гэх мэтчилэн эдгээр зүйлүүдээс болж үнэ өссөн юм. Ингээд үүнийг одоо, манай өнгөрсөн манай Засгийн газраас өнгөрсөн жилээс хойш Энэтхэгийн Засгийн газарт 7 удаа ингээд албан ёсоор зээлийн дүнг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын зардлыг бүрэн шийдэж өгөхийг хүссэн ийм албан бичгүүд явж байна.

Ингээд төсөл хэрэгжих хугацаа хойшлох, зардал өсөхөд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг би та бүхэнд хэлье. Тэгээд яах вэ манай Аж үйлдвэржилтийн байнгын хорооныхонд нийтэд нь би ерөнхийдөө манай Монголд томоохон төсөл, хөтөлбөр гадаад улсуудтай хамтарч хэрэгжүүлэхэд хүндрэлтэй юм юу байна, бид нарын ажиглалтаар дотоод, гадаад гэж шалтаг байна.

Гадаад нь болохоор мэдээж геополитикийн асуудал, дээрээс нь дэлхийн зах зээлийн үнэ хани, гуравдугаарт нь тээвэр ложистик, манайх нөгөө далайд гарцгүй орон болохоор хүндрэлтэй байна.

Дотоодод болохоор угаасаа бусад хүнд аж үйлдвэрийн салбар муу хөгжсөн болохоор тэндээсээ тэрийгээ авчихъя гэх юм даанч алга.

Хоёрт нь дэд бүтэц нь хангалтгүй байна, мэдлэг туршилагатай экспертүүдийн хомсдолтой байна, техник, тоног төхөөрөмж дутуу байна, эрх зүйн орчин нь зарим юм ойлгомжгүй байна. Маш их юмыгаа ингээд боомилчихсон янз бүрийн дүрэм, журмаар, салбар хоорондын уялдаа дутмаг байна, барилгын улирал богино гэдэг бол бас маш дайсан. 4 сарын турш бид нар бол юу ч хийж чадахгүй ингээд байж байна. Эдгээр хүчин зүйлүүд нь төслийн хугацааг алдагдуулах, зардлыг өсгөх ийм хүчин зүйл болж байна.

Ингээд 2, 3 дугаар багц ажил бид нарт юу тохиолдсон бэ? Зовлон жаргалаа ярина гэж сая.../минут дуусав./

С.Ганбаатар: Алтанцэцэг даргад дахиад микрофоныг нь нээж өгье.

Д.Алтанцэцэг: Мааш хурдан ярина. Энэ бид нарт юу тохиолдсон бэ гэсэн чинь гэв гэнэтхэн 2, 3 дугаар тендер зарлах үе КОВИД таарсан. Тэгэхэд тендерт оролцох хүн байхгүй. Тендерийн хугацааг 5 удаа сунгаж байгаа ЕСР-2-ын тендерийг. ЕСР-3-ын тендер 7 удаа сунгасан. Яасан гэсэн чинь гэнэтхэн үнэ нь өсчихсөн. Дээрээс нь тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд, Монгол руу аваачихад хэцүү болсон. Тянжинь дээр ийм ийм асуудалтай. Тэгээд компаниуд оролцохгүй. Бид нар уриад л байдаг, уриад л байдаг. Оролцсончууд нь ингээд л тендерийн хугацаа дуусах болохоор л дахиад 3 сараар, дахиад 2 сараар. Бид нар бол тендер авахгүй байснаас сунгаад ч болсон авсан нь дээр гэдэг байр суурь дээр бүгд нэгдэж байсан.

Ингээд тендер авсан чинь асар өндөр үнийн дүнтэй тендер ирсэн. Ийм олон бүтэн 12, 15 сар хүлээлгэж байгаад. Ингээд аргаа барахдаа Ерөнхий сайдаа хандсан, манай Оюун-Эрдэнэ сайд Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модид бичээд танайхаас ирсэн зээлийн чинь шугам дагуу тендер зарлахад ийм айхтар үнийн дүнтэй юм ирлээ. Нэгэн дээр нь тэгэхэд бүхэл бүтэн зээлийн ерөнхий хэлэлцээрийн дүнтэй тэнцүү ингээд юм ирлээ. Яах вэ гээд ингээд. Нарендра Модид гээж хүн үтэр түргэн арга хэмжээ аваад, Энэтхэгийн Сангийн Яам, Гадаад хэргийн яам, манай төслийн менежментийн зөвлөхийн удирдлагуудыг явуулаад бид нар цоо шинээр Энэтхэгийн Засгийн газарт хүсэлт гаргасан. Юу вэ гэхээр энд эхний тендерээ цуцалъя. Тэгээд шинээр нөхцөл зааж өгөөч бид нарт. Өрсөлдөөнийг бий болгох. Зөвхөн Энэтхэг компани биш, гадаадын компанийг оруулдаг боломжийг бий болгож өгөөч.

Дээрээс нь Энэтхэгээс авах бараа, ажил, үйлчилгээний хэмжээг бууруулж өгөөч. Хятадаас, Оросоос, Монголоос авах боломжийг бий болгож өгөөч ээ. Ингээд хөнгөлөлттэй зээлийнхээ журамд техникийн зарим өөрчлөлт оруулж өгөөч. Бүгдийг нь Энэтхэг бол 7 хоногийн дотор хуралдаж зөвшөөрсөн. Ингээд бид нар дахин тендер зарлахад та бүхэн энэ улаанаар биччихсэн тоог хараад байгаарай, энэ ЕСР-2-ын тендерийг хар даа нэг компани тэрбум 264 сая долларын санал өгч байсан. Бид нарыг шокт оруулсан юм бол энэ.

Ингээд хамгийн багадаа л 736. Одоо бид нарын 598-аар хийчихсэн байгаа гэрээ шүү дээ. Ингээд түргэвчилсэн тендерийг бид нар зарлахад хамгийн багадаа 675, хамгийн ихдээ 900, 895 орчим. Тэгээд бид нар энэ үнийг нээсэн. Ямар ч байсан эхнийхийгээ бодвол бас доошилж ирсэн.

3 дугаар багц ажил буюу цахилгаан станц дээр нэг ч компани орохгүй. Тэгж тэгж байгаад төрийн өмчит энэ...электрекс компани нь 7 удаа хойшлуулж байгаад тендерт үнийн санал ирэхдээ 380 сая ирүүлж байгаа юм. Энийг нь дахиж дээд талынх шигээ цуцалж хаяж байгаад дахиж зарлахад ингээд 225, өрсөлдөөн шиг юм бий болж байгаа юм. 780 байснаа бол бид нар 225 сая гэдэг тоо бол авсан.

Ингээд тэр хоёул хоёр багц ажил дээр хоёуланд нь хамгийн бага үнийн санал авсан компани бол одоо энэ 2, 3 дугаар багц ажлыг хийгээд байгаа Megha Engineering and Infrastructure гэж Энэтхэгийн компани байгаа.

Энэ компанийн энэ тэр хамаг бизнесийнх нь дарга нар эзнийг нь хүртэл Монголд урьж авчраад бид нар үнэ бууруулах хэлэлцээ хийсэн. Танайх нэгэн дээр нь хамгийн бага буюу 675, нөгөөдөх дээр нь хамгийн бага буюу 215, нийт 900 сая долларын ажлыг манайд хийе гэжээ. Энийгээ хэлэлцье гээд. Бид нар бол мааш хүнд хэлэлцээрт орж, олон техник,

эрх зүй юу гэдэг юм Монголын төр засгийн анхаарлын төвд байдаг бүх талын дэмжлэгтэй ийм төсөл энэ тэр гэж байж бид нар 788 сая доллар болгож бууруулсан.

Өөрөөр хэлбэл, энэ 2, 3 дугаар багц ажлын тендерт ирсэн хүнийг бид нар нийтдээ 111.4 сая доллароор бууруулсан юм шүү. Ингээд нийт бид нар бүх лиценз эзэмшигч ЕСП-1 дүгээр гэрээ бүгд дээр бид нар өнөөг хүртэл үнийн дүн бууруулсан нь бид нар 164.5 сая доллароор бид нар бууруулсан байдаг юм. Яах вэ энийгээ бид нар бол энд, тэнд ярьдаггүй. Өнөөдөр бас та бүхэнтэйгээ ам нээвэл уушги нээ ингээд бүх зовлон, жаргалаа ярья гэж бодсон юм.

Тэгээд инженерчлэлийн үе шатанд хийсэн оновчлолуудыг би товчхон хэлчихье. Жишээ нь, хамгийн анхан энэ Монголын туслан гүйцэтгэгчээр ТЭЗҮ-ийн үед ажилласан компани манай энэ цэвэр усны нөөцийн савыг газар дээр төлөвлөчихсөн байгаа юм. Энэ газар дээр төлөвлөчихсөнийг нь бас хүлээгээд авчихсан. Тэгтэл яагаад ч байж болохгүй энэ стратегийн объектын усны савыг газар доор. Тэгээд газар доор оруулахад л эд нар ингээд л 8-10 сая долларын зөрүү гарсан гээд л ярих жишээтэй.

Дээрээс нь бид нар онгоцны түлшийг 40 мянга байснаа одоо манай шинэ онгоцны буудал бий болсонтой холбоотойгоор бид нар бас Монгол Улсын Азийн нислэгийн хаб болоосой гэж бодоод 80 мянган мянган тонн олон улсын стандартын JET A1 түлш үйлдвэрлэе гэж шийдсэн.

Шингэрүүлсэн шатдаг хийг мөн бид нар пропан, бутан нь ялгадаг байгууламж хийе гэсэн. Тэгэхгүй бол манай зах зээл дээр чинь процентоор хольдог учраас манайд ялгадаг газар байхгүй байгаа байхгүй юу. Цахилгаан станцын хүчин чадлыг нэмсэн. Хамгийн гол нь энэ агуулах сав, энэ 40-өөд агуулах сав байгаа юм. Энийг бүгдээрэнг нь анхнаас нь зөвхөн 1 хөвөгч дээвэртэй Монголд байдаг иймийг төлөвлөсөн байсныг бид нар Дорноговийн салхи, шуурга, говийн элс юунаас бид нар сүүлийн 80 жилийн дунджийг авч байгаад ер нь зайлшгүй дээрээс нь давхар дээвэр хийх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, бүх сав маань дотроо хөвөгч, гаднаа фикс буюу ийм хатуу хучилттай ийм хоёр хоёр дээвэртэй болгосон. Энэ бол эдэлгээнд нь маш их хэрэгтэй байсан юм.

Ингээд шингэрүүлсэн шатдаг бөмбөрцөг байсан. Тэгэхээр энэ аюулгүй ажиллагааг бид нар дээд зэргээр хангахын тулд бид нар орчин үеийн энэ хэвтээ, далд булагдсан ийм сав сонгосон. Жишээ нь, цахилгаан станц дээр гээд л тэгэхэд бид нар цахилгаан станцын үнс баригч гэдэг юмыг зайлшгүй хийхгүй бол болохоо байсан. Энэ бол тийм том тоноглол байж байгаа юм. Динокс гэж байгаа юм. Заавал ч үгүй байх ёстой. Аммиак хадгалах сав гээд. Тэгэхээр ингээд Монголын өөрийн цаг агаар, байгаль орчны шаардлага гэх мэтчилэн энэ олон юм, дээрээс нь элэгдэл, хорогдол гэх мэтчилэн бүгдийг тооцож бид нар сайжруулсан юм.

Дээрээс нь бензиний гарцыг бид нар 340 байсныг 399-өөр, 400 руу ойртуулсан. Манай бензиний хомсдол гарсан энэ хооронд. Тэгэхээр бид нар яаж Монголын газрын тосыг максимум бензин гаргадаг болгох вэ? Манай тос өөрөө бензин бага гардаг тийм шинж чанартай тос байхгүй юу. Сайн чанарын их дизель гардаг.

Тэгэхээр ингээд бензиний, бид нар бензин боловсруулдаг 3 байгууламж байдаг юм. Эн Эйч, Нафта хайдротридин, изомержулалт, реформерт, реформинг гээд яг 95 октантай евро 5 стандартын бензин үйлдвэрлэхэд бид нар заавал энэ юунуудыг тавих юм.

Тэгэхээр эдгээрийг тавихад бүгдээрийнх нь хүчин чадал нь өссөн. Бүгдийнх нь хүчин чадал. Ингээд яриад байвал яриад байна ийм маягаар ингээд бид нар инженерийн үе шатад ийм өөрчлөлтүүд хийсэн.

Дамжуулах хоолойн төсөл бол сайн явж байгаа. Манай дамжуулах хоолойн төслийг Хятадын компани ECP контрактораар нь ажилладаг. Хятадын Norinco гэж компани энэ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас шалгаруулсан. Өнөөдөр 519км, 530-ийг барина шүү дээ. 519-ийн цувиад, гагнуурын ажил нь 514 гээд. Тэгээд энэ 5 янзын давхар их яналттай явдаг.

Жишээ нь, зураг, төслийг нь Канадын “Worley Parsons” хийдэг. Зураг, төслийн хяналтыг нь манай өмнөөс Италийн “Prometheus” хийдэг. Хятадын талаас Sinopac хийдэг. Тэгээд манай компанийнхан өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлдэг. Одоо Барилгын хөгжлийн төв Тавантолгойд тусалж байгаа тийм үү? Барилгын хөгжлийн төв барилгын ажилтан гэх мэтчилэнгийн. Тэгэхдээ энэ техникийн хяналтын асуудлыг бид нар энд тэндгүй маш их ярьж байгаа.

Энэ үл эвдэх сорилын ажил гэдэг бол Германы ..., Монголын Армор гэж хоёр компани үл эвдэх сорилын 3 янзын тест, радиограф, магнитометр, ультра саундын ийм тестүүд хийдэг.

Манай энэ газрын тосны хайгуулын талбай энэ бол тусдаа бас. Энийг дэмжээд манай бас Их Хурал дэмжиж ирсэн, Засгийн газар. Манай компани цаашидаа бас өөрийн гэсэн газрын тосны түүхий эдийн түшиц газартай болохыг хүсдэг.

Ингээд ерөнхийдөө тос олоод яваад байгаа. Хөрөнгө оруулагчид манайд үнэхээр дургүй байна. Орж ирэх аймаар дургүй байна.

Газрын тосны үйлдвэрийн хотхон энэ хамгийн сүүлчийн слайд. Энэ хотхон бол уг нь нийгэм, эдийн засгийн аягүй өндөр ач холбогдолтой ийм сайхан төсөл. Харамсалтай нь нэг хэсгийг нь Барилга, батлан хамгаалах яамыг хариуц гээд өгчихсөн биш тэр та бүхэн харж байна энэ тэр баруун талд байгаа нь. Манай компанийн өөрсдөө шууд гэрээлсэн энэ юунууд баригдаад бид нар энэ гэрээ хэлэлцээ хийхдээ тэр гүйцэтгэгч компаниудыг та нар инженерүүд манай энд ийм үнээр байлга, ингэснийхээ хүчинд тэр зочид буудлынхаа мөнгийг бууруулаад энэ нийтэд хөрөнгө оруулалтын зардалд сайнаар нөлөөлдөг байхгүй юу.

Ингээд шийдвэрлэх шаардлагатай асуудал энэ тэрийг ярихаа больё доо.

Ер нь энэ үйлдвэрийн, энэ газрын тосны үйлдвэр гэдэг бол ер нь ямар ч улс хөгжсөө л гэж бодвол өөрийн тосгүй Сингапур, Япон, Солонгос бүгдээрээ хамгийн түрүүнд л газрын тосны үйлдвэрээ барьж авдаг юм байна лээ. Өнөөгийн аж үйлдвэрийн хөгжсөө гэвэл цөм нь газрын тос боловсруулах үйлдвэр. Ингээд энэ түлш шатахууныг төр засаг нь өөрөө захиран зарцуулах боломж байж байна. Энэ бол гадаадын бие даасан байдалд хэрэгтэй, улсын төсөвт дорвитой хувь нэмэр оруулна. Үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллахад борлуулалтын орлого нь бид нар зүгээр л дунджаас, дунджаас жоохон доогуур бодож байгаа шүү дээ 4.5 их наяд.

Хамгийн гол нь түүхий тосны үнэ бол зардалд хамгийн том жин дардаг. Энэ бол манай төр засагт бол улсын төсөвт асар өндөр хувь нэмрээ оруулна. Валютын урсгалыг бууруулна, ажлын байр бол өнөө хэр нь зөндөө олдсон байж байна.

Гэхдээ бид нар манай компанийнхан бас энэ ажлын төлөө олон жил зүтгэж явж байгаа залуучуудын урмыг нь хугалах юм бол энд, тэнд зөндөө сонсогдож байгаа. Бид нар энэ үйлдвэрээ барьчих юм бол Монголын ард түмэндээ, залуучууддаа, бас төр засагтаа итгэх итгэл, ирээдүйдээ итгэлийг өгөх нь хамгийн том ач холбогдол юм байна гэж харж байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Алтанцэцэг даргад баярлалаа. Би сая Улсын Их Хурлын гишүүний асуултад, яг асуултад нь хариулна гэж, тэгээд 5-аас илүүгийн хугацаанд албан тушаалтан хариулна гэсэн дүрмийн заалтыг Монголын ард түмэнд маш чухал санаа зовниж байгаа зүйл учраас хугацааг нь жоохон сунгамаар байна гэсэн 15 минут ярилаа.

Тэгээд сая яг асуултад хариулна гэхээсээ илүү төслөө л зүгээр танилцуулах ишг боллоо шүү миний ойлголтоор. Тэгэхлээр асуултаудад яг тодорхой хариулах байх. Тэгээд горимын нэг санал гарсан. Би бас та нараас заавал санал хураалгах ёстой юм байгаа юм шүү. Энэ их том мөнгөний тухай ярьж байгаа. Том, том ийм чухал асуудлууд байгаа. Энэ хэлэлцүүлгийн асуудлыг бас хаалттай хэлэлцүүлэх боломж байна уу гэсэн горимын санал гарсан учраас энийг бас би та бүхнээс асуух ёстой. Ингээд хаалттайгаар хэлэлцье гэсэн ийм горимын саналыг дэмжиж байгаа гишүүд нь киноо дарж айн? Горимын санал хураахын өмнө тайлбар, Мөнхбаясгалан гишүүнд.

Л.Мөнхбаясгалан: Энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад асуулт тавьсан гишүүний хувиар, мөн энэ үйлдвэр манай тойрогт баригдаж байгаа том төсөл, Оюу толгойн бараг дараа орох том төсөл учраас энд би тайлбар хэлье гэж бодож байна.

Нэгэнт энэ авсан зээлүүд нээлттэй байгаа мэдээлэл нь. Хаанаас яасан ийсэн, хэдэн төгрөг болсон гэдэг нь нээлттэй байгаа. Одоо 431 сая долларын зээл авахаар оруулж ирж байгаа. Тэгээд ийм энийг бид нар, бид нарын үр хүүхэд төлнө, Монгол Улс төлнө.

Тэгэхээр энийг бид нар улсын нууц биш юм чинь нууцаар хэлэлцэх ямар ч шаардлага байхгүй. Хаалттай хэлэлцэх шаардлага байхгүй гэж бодож байна. Тэгэхээр гишүүдийг нээлттэй хийлгэх тал дээр дэмжиж өгөөч гэж хүсэж байна.

С.Ганбаатар: Саяын горимын саналтай холбогдуулж Мөнхбаясгалан гишүүн байр сууриа илэрхийллээ.

Ингээд горимын саналаа нэгэнт гарсан учраас бас заавал санал хураах ёстой. Ингээд та бүхэн энэ газрын тосны асуудлыг хаалттайгаар хэлэлцэж асуулт асууж, хариулах гэсэн горимын саналыг дэмжиж байгаа хэсгүүд нь киноо дарна уу. Санал хураалт.

Ингээд санал дэмжигдсэнгүй 100 хувиар.

Энийг нээлттэй ард, иргэдэд нээлттэйгээр хэлэлцье гэдэг санал гарлаа.

Хэлэлцэх асуудал дээр, төслийн талаарх мэдээллийг “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралд Дашидаваагийн Алтанцэцэг танилцуулчихлаа. Мөн өнөөдөр энэ дээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жавхланбаатар ирсэн байгаа. Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга ирчихсэн байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Анхбаяр дарга ирсэн байгаа. Хишигдалай гэж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга ирсэн

байгаа. Үндсэндээ Монголын ард түмнийг төлөөлж, бас хяналт тавьж, энэ дээр мэргэжил арга зүйн зүгээс туслалцаж, дэмжиж, хамтарч ажиллаж байгаа яамдын төлөөллүүд бас ирсэн байгаа учраас бас би ингээд танилцуулах нь зөв байх. Алтаницэцэг захиралд баярлалаа.

Асуултын хариулттай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Бадамсүрэн, Жангабыл гишүүнээр тасаллаа. Мөнхтулга гишүүн асуулт асууж, үг хэлнэ үү.

П.Мөнхтулга: Одоо асуулт биз дээ? Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ төсөл маань, зээлийн тэр бусад санхүүжилтийн асуудлыг Мөнхбаясгалан гишүүн угаасаа сүүлд нь асуух байх. Миний хувьд энэ яг хэзээ ашиглалтад орох вэ, хэзээнээс яг бүтээгдэхүүнүүд нь үйлдвэрлэгдэж эхлэх вэ? Тэгээд энэ нөгөө шинэ технологийн горимууд нэвтрүүлж байгаа гээд тэгж байна. Энэ дээр яг одоо манай энэ тодорхой хэдэн манайд ийм нийт бид нар тэдэн тонн түлш 95, 92, 98, онгоцны бензин хэрэглэдэг юм. Энэний манай үйлдвэр ашиглалтад орсноор 92-ын тэдэн хувь, 95-ын тэдэн хувь, дизель түлшний тэдэн хувийг, онгоцны түлшний тэдэн хувийг манайх дотоодоосоо хангадаг болох юм гэдэг статистикийг хэлж өгөөч, тоог. Улсын төсөвт яг зарчмын хувьд энэ чинь ТӨХК гэж явж байгаа тийм? ТӨХХК гэж явж байгаа юм байна тээ? Тэгэхээр энэний 100 хувь манай төрийн өмчит байгаа юу? Бид нар ирээдүйд энэ төрийн ТӨҮГ-ууд ер нь их авлигажаад байна, менежмент их муу байна, ер нь төр менежментийг их сайн хийдэггүй гэдэг жишээг дэлхий даяараа харж байгаа.

Тэгэхээр энийг олон нийтийн нээлттэй компани болгох тал дээр бид нар илүү цаашидаа үр хүүхдүүддээ үлдээе гэх юм бол төрийн оролцоог илүү багасгах л ёстой. Тийм болохлоор энэ дээр яг ХХК хэлбэр нь хувьцаа эзэмшилд нь яаж явж байгаа вэ гэдэг ийм асуултууд байна.

С.Ганбаатар: 4 дүгээр микрофонд цаг өгье.

Д.Алтаницэцэг: Үйлдвэр хэзээ, Мөнхтулга гишүүний асуултад хариулъя. Үйлдвэр хэзээ ашиглалтад орох вэ гэж байна. Үйлдвэр хэзээ ашиглалтад орох вэ гэдэг нь бид нар ЕСР-4-ийн гэрээг хэзээ байгуулж чадах вэ гэдгээс л болж байгаа юм. Тэгэхээр гэрээ хийлээ түүнээс хойш 36 сар.

Тийм учраас энэ зээлийн дүнг нэмэгдүүлэх, энэ хөрөнгө оруулалтын асуудлыг шийдүүлэх гэдгийг бид нар төсөл хэрэгжүүлэгч компанийн бидний өдрийн бодол, шөнийн зүүд. Бид нарын хүслээр өчигдөр ч гэсэн оруулчихсан юмсан гэж бодож байгаа. Тэгэхээр энэ 2 улсын төр засгаас хамааралтай, Энэтхэгийн Засгийн газраас тун удахгүй хариу ирнэ гээд ингээд хүлээлгэж байгаа. Энэ жил бас Энэтхэг Монголд хоёуланд нь ингээд юу таарлаа. Улс төрийн сонгууль. Сонгуулийн жил таарлаа. Бид нар 12 сард гэрээгээ байгуулж чадвал ЕСР-4-ийнхөө. Тэгвэл 27 оны 12 сард ингэж л ойлгомоор байна.

Яг юм болгон өөр өөрийн гэсэн хугацаатай. Бид нарт хурдлуулж чадах юм бий. Тэгэхдээ яг чадахгүй бас юмнууд байгаа юм.

Дээрээс нь бүтээгдэхүүний талаар манай Хишигдалай Уул уурхайн яамнаас, Эрдэс баялаг, эрчим хүчний яамнаас хариулах байх.

Шинэ технологи гэж байна. Энэ үйлдвэр бол бүх шатдаа зураг, төслөөсөө эхлээд үйлдвэрийг бүүр барилга байгууламж, оперэйшн хүртэл state of the art буюу цоо шинэ бүх юм шинэ технологид суурилж хийж байгаа. Бүх юм нь автомат системийн, автомат удирдлагуудтай. Энийг бол нарийвчилж ямар системүүд явагдаж байгаа гэдэг дээр өөрт чинь жичид нь манай автоматжуулалт, тоноглолын инженерүүд бас юу өгч болно, танилцуулга хийж болно.

Манай компани 100 хувь ТӨК. Энэ үнэн. Би бол өөрөө бас эдийн засагч хүн, инженер хүн. Энэ төр муу менежер гэдгийг энэ бол бас зарим талаар тэгж ярьдаг боловч зарим талаар бас тийм ч үнэн биш. Дэлхий дээр сүүлийн үед ямар тенденс хандлага байв гэхээр харин ч энэ стратегийн чухал ач холбогдолтой газрын тос, байгалийн хийн ордоос өгсүүлээд үйлдвэрүүдээ нациалчлах. Энэ 1990-ээд оноос хойш хамгийн анхан 71 онд ОПЕК-аас эх автай, 90 оноос хойш та нар яг судлаад үзэх юм бол дэлхий дээр газрын тосны орд болоод үйлдвэрүүдийн 80 хувь нь ТӨК-уд байгаа. Төрийн өмчит.

Тэгэхээр төрд хэнийг ажиллуулах гэдэг бол Засгийн газар, төрийн томилгоо. Бид бол үнэнч шударгаар ажилладаг. Бид нар өөрсдийгөө муу менежер гэж бас хэлэхгүй ээ. Тэгэхээр ингээд үйлдвэрийн бүтээгдэхүүн манай газрын тосны бид нар зах зээлийн судалгаанд суурилж хийдэг. Тэгэхээр манай зах зээлийн хэрэглээгээ ярьж байгаа шүү дээ шатахууны зах зээлийн хэрэглээний 65 орчим хувь нь дизель байдаг.

Ер нь гол тэгэхээр манай, бид нарын үйлдвэрийн концепц юу гэж хэлдэг вэ гэхээр ийм физик, химийн шинж чанартай 1.5 сая тонн түүхий тосыг 65 хувь нь дизель, тэдэн хувь нь бензин, тэдэн хувь нь шингэрүүлэн шатдаг хий болгохын тулд ямар үйлдвэрийн концепц зохиох вэ? Үүгээр бол конфигурац явагдаж байгаа. Тэгэхдээ өнөөдөр хүмүүс манай үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нийт.../минут дуусав./

С.Ганбаатар: *Алтанцэцэг дарга маш их тодорхой асуулт уг нь асуусан. Их тодорхой хариулбал их сайн шүү. Ерөнхий л яриад байвал, Оюу толгойн гэрээ ярьж байхад их ерөнхий ярина, дандаа гадаад нэр томъёо хэлнэ. Маш том луйвар болсон. Манай энэ газрын тос дээр маш тодорхой, маш чухал зүйл ярьж байгаа учраас би бас улам тодорхой болговол сайн байна л гэсэн санаа хэлж байгаа юм шүү.*

Тодруулж, нэмж хариулах юм уу, яах юм?

Та нар товчхон яг асуултад нь хариулбал сайн байна шүү. Ерөнхий тойроод л яриад байвал яг асуудал дээрээ худлаа байна л гэсэн үг гэж. Энэ дээр хэлмээргүй байна. Оюу толгой дээр тэгж луйвар болсон. 5 номер.

Ч.Хишигдалай: *Газрын тос боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэх түүхий эдийг нэг бүрчлэн хувиар тодорхой танилцуулъя.*

Онгоцны түлшний хувьд бол газрын тос боловсруулах үйлдвэр маань 80 мянган тонн онгоцны түлш үйлдвэрлэнэ. Өнөөдрийн Монгол Улсын хэрэглээ бол 60 орчим мянган тонн байна.

2.Үйлдвэр ашиглалтад орох хугацаанд өсөн нэмэгдэхийг тооцоод 80 мянган тонн бол тухайн үеийн хэрэгцээг 100 хувь хангана, 92 авто бензин бол 390 мянган тонныг үйлдвэрлэнэ. 400 орчим мянган тонныг үйлдвэрлэнэ 95 бензин.

Өнөөдрийн Монгол Улсын хэрэглээ бол жилийн хэрэглээ 720 мянган тонн байна. Үүний 55 хувийг бол дотоодоосоо хангана.

Дизель түлшний хэрэглээ бол жилийн сая 300 мянган тонн байна. Үйлдвэр маань 825 мянга орчим тонныг үйлдвэрлэнэ. Дотоодын нийт хэрэгцээний 65 хувийг бол дотоодоосоо хангана. Шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээ бол.../минут дуусав./

С.Ганбаатар: 5 дугаар микрофон дээр хугацаа нэмж өгье. Яг чухал асуудлуудад тоонуудаа ярьж байна.

Ч.Хишигдалай: Шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээ бол 40 мянга орчим тонн байна өнөөдрийн хэрэглээ. Үүнийг бол үйлдвэр 40 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий Эл Пи Жи үйлдвэрлэнэ. Үүнийг бол 100 хувь хангана.

С.Ганбаатар: Түрүүн тодруулж асуух юм нь байна шүү дээ, гишүүн асуусан юм нь энэ саяын ярьсан үр дүнгүүдээ гаргахад хангалттай нөөц бэлэн байгаа гэж гэж ойлгож болох уу? 5 дугаар микрофон

Ч.Хишигдалай: Монгол Улс газрын тосны баталгаат нөөц бол 300 гаран сая тонн байдаг. Үүний ашиглалтын баталгаат нөөц бол 43.7 сая тонн. Үүнээс бид нар 10 сая орчим тонныг нь олборлоод экспортолчихсон байна. Үйлдвэр ашиглалтад орох хугацаанд бол тодорхой талбайнууд дээр нэмэлт газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулаад хайгуулын ажлууд хийгдэнэ. Мөн одоо олборлолт явуулж байгаа талбайнууд дээр олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх янз бүрийн технологийн аргуудыг хэрэглэнэ.

Үйлдвэрийг ашиглалтад ороход бол бид нар 100 хувь түүхий эд дээр хангахаар бас хүчин чармайлтаа гаргаад бодлогын хэмжээнд дэмжиж ажиллаж байгаа. Нөөц бол байна. гэсэн үг.

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн тодруулъя.

П.Мөнхтулга: Яах вэ зүгээр, одоо яг албан ёсны хүмүүсээс нь л асуугаад байгаа юм. Надад өгч байгаа мэдээллүүд болохлоор энэ үйлдвэрийг хүчин чадлаараа ажиллахад хангалттай түүхий эд байхгүй. л гээд байгаа юм ойр тойрных нь хүмүүс.

Тэгэхээр яг бид нар нөгөө протоколд үлдэж байгаа учраас яг одоо энэ үндэсний хэмжээнд энэ 50, 55, 65 хувийн дотоодын хэрэгцээг хангах ийм хэмжээний үйлдвэр баригдаж байгаа ч гэсэн хангах түүхий эд нь яг бодлогын түвшинд бэлэн болсон юм уу, гэрээ хэлэлцээрүүд нь хийгдсэн юм уу? Аль аль, ямар ямар уурхайгаас? Одоо тэр ЕСП-3 дээр чинь тэр мега компанийн юу байгаа юм байна шүү дээ хоолой татаж байгаа юм байна шүү дээ тээ? Энэ хоолой чинь Тамсаг-аас татаж байгаа гэж ойлгож байгаа тийм үү? Энэ хүрэлцээтэй юү? Нэг эх үүсвэртэй юү, хэдэн эх үүсвэртэй вэ? Энэ эх үүсвэрүүд резервтэй юү? Аль нэг.../минут дуусав./

С.Ганбаатар: Жавхланбаатар дарга 1 дүгээр микрофонд нээе.

С.Жавхланбаатар: Мөнхтулга гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр Монгол Улс 4 талбайгаас сая сүүлийнх нь 4 дэх нь монгол хөрөнгө оруулалттай газрын тосны цооног нээгдсэн, 4 талбайгаас олборлож байна яг өнөөдөр. Тэгэхдээ энэ 4 талбайн нөөц бол нийлээд 4 сая орчим байгаа. Петроцайнагийн асуудлуудаас болоод, нөгөө иргэний хөдөлгөөний асуудлуудаас болоод өнгөрсөн жилээс эхлээд бол нөгөө олборлолт нь түр багассан байгаа.

Ер нь жилийн дундаж олборлолт бол 4 сая гаруй баррель буюу 500 гаруй мянган тонныг олборлож экспортлодог байсан. Энэ жил бол одоогийн гүйцэтгэлээр 10 сарын 23-ны байдлаар 460 орчим мянган тонныг олборлосон байна. Экспортлосон гэсэн үг. Газрын тосны үйлдвэр маань сая 500 мянган тонн хэрэгцээ байгаа. Яг өнөөдрийн 4 олборлолтод, олборлож байгаа, ашиглаж байгаа 4 цооногоо нэмэгдүүлээд энийг бүрэн хангах боломжтой технологийн хувьд.

Гэхдээ бид нар нэмээд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын 14 хайгуулын гэрээ Засгийн газар байгуулсан байгаа юм. Хайгуул хийгдэж байгаа гэсэн үг бусад компаниуд дээр. Тэгэхээр энэ хайгуулаар тогтоогдсон нөөцүүдээр ирээдүйн жил бүр энэ газрын тосны үйлдвэрийн маань түүхий эдийг хангах ийм бодлого явагдаж байгаа.

С.Ганбаатар: *Би гишүүний асуултыг зүгээр тодруулаад асуугаадахъя даа. Хурал даргалагчийн хувиар. Түүрүн 5 номерын микрофон хэн билээ? Хишигдалай дарга хариулсан нөөц бол яг 100 хувь хангалттай биш гэж ойлгоод байна шүү дээ. Яагаад гэвэл хайгуул хийж байгаа, технологийн шийдэл хайж байгаа гэж ярилаа*

Жавхланбаатар дарга бол 4 сая тонн гарахаар болчихсон байна гэж байна. Энэ нь өөрөө яг болно гэж хэлсэн. Газрын тосны энэ Монгол газрын тосны үйлдвэрийг боловсруулах үйлдвэрт нийлүүлж болно гэсэн. Энэ болно гэдэг чинь бас болохгүй гэсэн утга агуулга байдаг л даа. Тэгэхлээр бүр яг таг гэрээ хийчихсэн юм уу, нийлүүлнэ гэж байгаа юм уу? Тэр дотор чинь бас хувийн компаниуд нь бас байгаа.

Тэгэхээр энэ болгон дээрээ гэрээгээ нарийвчилж хийсэн үү гэдэг дээр гишүүний асуултад их тодорхой хариулбал сайн байна. 5 номер.

Ч.Хишигдалай: *Газрын тосны тухай хууль дээр Монгол Улсад олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж дотоодын газрын тос боловсруулах үйлдвэр байгуулсан тохиолдолд нэн тэргүүнд бүтээгдэхүүнээ зах зээлийн үнээр нийлүүлнэ гэсэн хуулийн заалттай. 2012 онд батлагдсан хууль.*

Хоёрдугаарт, Петрочайна, Дайчин тамсаг компанийн олборлолтын орд, ашиглалтын төлөвлөгөө дээр тулгуурлаж боловсруулах үйлдвэрийг барих ажил маань эхэлсэн. Орд ашиглалтын төлөвлөгөөгөөр бол сая 500 мянган тонныг тогтвортой 8 жил олборлоно гэж орд ашиглалтын төлөвлөгөө оруулж ирсэн байгаа.

Гуравдугаарт, Монгол Улсын ашиглалтын баталгаат нөөц яг өнөөдрийн байдлаар 33.5 сая тонн байна.

33.5 сая тонн гэдэг маань боловсруулах үйлдвэрийг 20 орчим жил хангах боломжтой гэсэн үг. Өөрөөр хэлбэл, өнөөдөр ашиглалтад шилжээд буй ордууд 33.5 сая тонн ашиглалтын баталгаат нөөцтэй. Үүн дээр өшөө газрын тос илэрсэн тодорхой.../минут дуусав./

С.Ганбаатар: *Манай газрын тосны үйлдвэр түүхий эдээр ерөөсөө огт тасрахгүй гэдэг талаар манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жавхланбаатар, мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Хишигдалай хариуллаа.*

Ингээд Лувсанжамц гишүүн асуултаа асууна.

Г.Лувсанжамц: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Инженер хүний хувьд та бүхний зовлон, жаргалыг ойлгож байна. Энэ бол том төсөл. Хэрэгжүүлэхэд ялт ч үгүй ингээд сунаад байдаг. Ялангуяа ийм том үйлдвэрүүд болохлоороо багц багцаараа явахлаар хэцүү болдог. Тэрийг маш сайн ойлгож байгаа.

Нэгдүгээрт нь горимын санал байна. Engineers India limited-ийг ерөнхий зөвлөх үйлчилгээний компаниар шалгаруулаад хийгээд явж байгаа юм байна шүү дээ тээ? Тэднийхийг бас дуудмаар байна иймэрхүү юман дээр. Нэгэнт бид нар зөвлөх үйлчилгээнийхээ ажлыг хийлгэж байгаа юм чинь хамгийн нарийн юмыг нь мэдэж байгаа хүмүүс тэр хүмүүс байх ёстой болов уу гэж би бодож байна. Тэр хүмүүс заавал ийм сонсгол дээр байх ёстой. Угаасаа олон улсын ийм том төсөл, хөтөлбөрүүдийг гэрээ хийж байхад тэгээд ер нь ирдэг ёстой байдаг тээ? Та бүхэн мэдэж байгаа. Дараагийн удаа ирэхдээ заавал тэдний хүмүүсийг дуудаж авчраарай.

Хоёрдугаарт нь энэ аудитын дүгнэлтийг харсан чинь манай Батлан хамгаалахын яам ажлаа хийнэ гэж хэлчээд хийхгүй алга болчихсон тийм юм байгаад байгаа юм байна шүү дээ тээ үйлдвэрийн? Тэр асуудал бас нөгөө төрийн байгууллага юм чинь цугт нь дуудаж авчраад бас энэ асуултуудыг асууж, тодорхой болгоод цааш нь хийх юм уу? Хийхгүй гэдгийг бас тодорхой болгож асуулт асуумаар байна.

Асуултдаа оръё. Engineers India limited -тэй хийсэн гэрээний маягт нь бас FIDIC үү? Ямар гэрээний маягтаар хийсэн бэ? ECP-1,2, 3, 4 бол Silver Book-ээр хийсэн юм байна шүү дээ тээ? Тэрийг ойлголоо.

Хоёрдугаарт нь энэ танилцуулгаа хийхдээ үйл ажиллагааны, бүтээн байгуулалтын ажлын явц л танилцуулаа. Бизнес төлөвлөгөө хармаар байна. Хэзээнээс, 27 онд сая ярьсан тээ? ECP-4 гэрээ хийгдэх юм бол 27 оноос эхлээд үйл ажиллагаа эхэлнэ, боловсруулж эхэлнэ гэсэн. Сая жилдээ тэдэн тонн дизель, хийн, онгоцны түлш энэ тэр хийнэ гээд тэгж байна. Хэдийг үйлдвэрлээд, хэдээр борлуулаад, ямар хэмжээний ашигтай ажлаа хийх юм бэ? Тийм бизнес төлөвлөгөө бид нар мэдэхгүй бол энэ дээр юу ч хэлээд тодорхойгүй л байгаад байгаа юм. Тэгээд хэзээнээс ер нь ашигтай ажиллаж эхлэх юм бэ гэдэг? Нөөц нь тэдэн тонн байгаад тэдэн тонныг боловсруулах юм бол ашигтай ажиллаж эхэлнэ гэсэн тийм хугарлын цэг байх ёстой шүү дээ тээ? Тийм бизнес төлөвлөгөөний тийм тоо хармаар байна.

Гурав дахь асуулт нь болохлоор танай компани болон яам хоёулангаас нь асууж байгаа шүү. Хүний нөөц хэр байгаа юм бэ гэдэг дээр FIDIC-ийн гэрээний маягыг ашиглаж байсан туршилагатай хуульч танайд хэд байна? Нэгдүгээр нь.

Хоёрдугаарт нь Project Management Professional буюу олон улсад ийм төслүүдийн менежментийг авч явдаг зэрэг байдаг даа тээ? Тийм төслийн менежментийн зэрэг эзэмшсэн тэдэн жилийн туршилагатай хэдэн хүн байгаа? Хэрвээ байхгүй бол энийг нь хангах талаас нь, хүний нөөцийг нь хангах талаас нь хийгээд явах хэрэгтэй шүү дээ тээ? Хэрвээ тэр нь, тийм хүмүүс нь байгаа туршилагатай хүн байх юм бол яг FIDIC-ийнхээ гэрээний дагуу хэрвээ ямар нэгэн байдлаар доголдол үүсэх юм бол шууд notice гээд л явуулчихдаг шүү дээ 2 долоо хоногийн хугацаатай, 1 сарын хугацаатай гээд. Тэрийгээ хийгээд явах боломжтой болохлоор тэр зүйлүүд дээр нь асуулт байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Хариулт 4 номер, 5 номер юм уу?

4 номер гээд уг нь хэлсэн юм сан. 4 номерын микрофоныг нээе.

Д.Алтаниэцэг: *Ер нь төслийн менежментийн зөвлөхийг Засгийн газрын энэ Их Хурлын гишүүдийн асуулга энэ тэрд оролцуулж байх нь зүйтэй юм байна гэдгийг бид нар бас өнөөдөр бас өөрсдөө саналаа хэлсэн. Танд баярлалаа, бас бид нар тэгж бодож байна.*

Энэ Батлан хамгаалах яаманд бас Их Хурлын гишүүд ажлаа хийх юм уу, хийхгүй юм уу? Тэр туслан гүйцэтгэгчийнхээ аманд орчхоод л бид нар 21 оноос хойш ажлаа хийхгүй ингээд байж байгаа. Энэ дээр бас бид нар хэчнээн ч яриад бол бид нарын эрх мэдэл хүрэхгүй ийм байдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас манай Үйлдвэржилтийн байнгын хороо бас анхаарал хандуулж өгөөрэй.

Бизнес төлөвлөгөөгөө ингээд харуулах гэж байна. Манайд PMC гэрээ.

FIDIC биш, PMC гэрээ бол олон улсын төслийн менежментийн зөвлөх project management consultancy гэрээний загвараар хийгдсэн. Инженер Си Эн Ти өөрөө энэ өөрийнхөө 65 жилийн хугацаанд бол 100-гаад PMC хийж байсан юм байна лээ. 100-гаад төсөл дээр. Тэгээд тэдний гэрээний маягт дээр манайх энэ тэр ажиллаад, бид нар энэ үнэ гэрээг байгуулахдаа бас Монголдоо тендер зарлаж байж хуулийн зөвлөхүүд ажиллуулсан.

ЕСР гэрээ гэдэг бол Монголчуудад тун бас сайн мэддэггүй гэрээ байж. Одоогоос 7 жилийн өмнөхийг бодоход тийм үү? 5 жилийн өмнөх. Одоо бол харьцангуй хүмүүс зөндөө мэддэг болсон байна. Engineering, procurement, and construction гэж гэрээг ингээд энийг бол бид бүгдээрээ л анхнаас суралцсан. Манай гэрээ, эрх зүйн газар бол 9 хүнтэй. 9-үүлээ энэ FIDIC гэрээн дээр бол бас сургалт авсан, мэдээж бие биедээ заасан, нэгийн зэрэг сайн мэддэг хүн байсан.

Өнөөдөр бид нар ЕСР-1,2, 3, 4 болгон дээрээ 1, 1 хариуцсан гэрээний мэргэжилтэнтэй. Ингээд бас Улаанбаатар хотынхон, хотын бас тэр метро энэ тэрийн төсөл дээр хүртэл манай хүмүүсээс зөвлөгөө энэ тэр авна гээд. Бид нар яах вэ түрүүлж ийм юмтай харьцаж эхэлсэн л хүмүүс юм шиг байгаа юм. Алдаа, оноо зөндөө гарах байх мэдээж. Баярлалаа.

Одоо бид нар энэ cashflow үзүүлээдэхье тэгэх үү? Гарахгүй байна. Би танд хүргүүлчих үү? Тийм, ер нь үйлдвэрийн, би ингээд яг эдийн засгийн тэр тооцоо, cashflow, эргэн төлөлтийн талаар би бас гишүүдэд бас дахиж танилцуулга хийж өгч болно шүү.

С.Ганбаатар: *Тодруулъя Лувсанжамц гишүүн тодруулъя.*

Г.Лувсанжамц: *Баярлалаа нарийн мэдээллүүдээ хүлээж байя тээ? Аж үйлдвэрийн байнгын хорооноос бас асуугаад авахаар ажиллаарай. Тэгээд протокол дээр сая эднийхийг үлдээмээр байна.*

Дараагийн хурлаар Engineers india-аас хүмүүс заавал оролцоно. Барилгын яамнаас, тэр Батлан хамгаалахын яамнаас тэр хариуцаж байгаа хүмүүсийг нь заавал оролцуулах гэдэг тээ? Энэ хоёр дээр үлдээлгэхийн тулд хэлж байна.

Project Management Professional гэдэг хүн нь одоогоор тоог нь дараа нь ирүүлнэ үү гэсэн тээ? Та бүхэнд амжилт хүсье.

С.Ганбаатар: *ЕРС, PMC, cashflow эд нараа дараа явуулахаар болж байгаа юм байна. Монголчууд ойлгохгүй гэж бодож болохгүй бас энийг тайлбарлах ёстой байх шүү.*

Тэгээд Мөнхбаясгалан гишүүн энэ асуулт асуусан гишүүний давуу эрх, дүрэм нь би. Түүрүүн би бас өөрт нь очиж тайлбарлалаа. Хамгийн сүүлд нь асууж, үг хэлэх юм байна шүү. Хуралдаан зохион байгуулагч нэрийг нь хойшоо оруулна уу.

Ингээд Золжаргал гишүүний асуулт асууна уу гэж урьж байна.

Ж.Золжаргал: Жоохон тоо, техниктэй холбоотой тийм юм асуучихъя гэж бодлоо. Цахилгаан станц нэрлэгийн үлдэгдлээр түлш хийж ажиллана тиймээ? Хэрвээ хүчин чадал багатай, эсвэл түүхий эд нь өөрчлөгдөөд, эсвэл түүхий эд нь багасаад ингээд ирэхээр цахилгаан станцын түлшний асуудал босож ирэх үү, үгүй юу? Тэр тохиолдолд хүчин чадал нь нөгөө төсөлдөө яг тааруулаад тооцчихсон байгаа юу? Өөр түлш байхгүй гэж ойлгож байгаа.

Хоёрдугаарх асуулт нь, түүхий эд түрүүн яригдаад өнгөрлөө. Миний ойлгож байгаагаар Монголын газрын тосонд тулгуурлаж дизайн хийгдсэн. Гэхдээ ус төрөгчийн боловсруулалттай учраас түүхий эдтэй харьцангуй уян хатан гэж бодож байгаа. Тэгэхээр одоо тэр олборлож байгаа Петроचनाгаас өөр сая Петро Матад-ын гаргасан тосыг жишээ нь ашиглавал ямар байх вэ гэсэн тиймэрхүү түүхий эдийн хувилбарууд хэр тооцсон болоо? Цаашидаа дахиад өөр эх үүсвэр нэмэгдвэл тэрийг авч ашиглах тийм дизайны үндэслэлүүд байгаа юу? Хоёр дахь асуулт нь юм байна.

Гуравдугаарт нь ECP-2, ECP-3 дуусаагүй байгаа. Саяын энэ мэдээлэл дээрээс харлаа. Ер нь яагаа ч үгүй байгаа юм байна. ECP-4 бол сүүлийнх нь. ECP-2 дээр технологийн нэлээн хэдэн хэсгүүд байна. Агуулахаас бусад нь баригдаагүй гэж ойлгосон. 19 хувийн гүйцэтгэлтэй.

Тэгэхээр 4 байгуулагдахаас гадна энэ 2, 3 хэзээ дуусах юм бол? Би зүгээр энэ гүйцэтгэлийг нь харахаар дэд бүтэц, барилга байшин энэ тэр хийгдчихээд яг технологийн тоног төхөөрөмжүүд угсрагдахгүй байгаад байгаа юм. Тэгээд тэр нь хурдан тавигдаад эхлээсэй. Тэгвэл санаа зовохгүй явах юм байна гэж харах юм сан гэж бодоод байгаа юм. Тэгэхээр энэ ECP-2, 3 хэзээ хийгдэх бол? Төслийн талбай дээр ингээд тоног төхөөрөмжүүд буугаад, зарим ажил нь хийгээд ингээд харуул хамгаалалт шалгах, хэн өмчилж, эзэмших вэ гээд асуудлууд байгаа гэж түрүүн ярианаас ойлголоо. Газрын тос боловсруулах үйлдвэр компани өөрөө төсөл хэрэгжүүлэгч биш, ашиглалтын өмнөх захиргаагаа авч яваад, дараа нь үйл ажиллагаа хариуцах юм байна гэж бодсон. Тэгэхээр энэ ойлголт зөв үү, буруу юу?

Нэмээд нэг асуулт нь, Энэтхэг тал нь гүйцэтгэгчээ, дэд гүйцэтгэгчээ шалгаруулаад ингээд явж байгаа байх. Тэгэхээр манай талаас хяналтын ямар баг дэд гүйцэтгэгч дээр нь орж ажиллаж байгаа вэ? Баярлалаа.

С.Ганбаатар: Маш тодорхой чухал асуултаас асуулаа. Хэд 4 номерын микрофоныг нээе.

Д.Алтаницэг: Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Цахилгаан станцын түлшний тухайд манай үйлдвэрээс 47 мянган тонн fuel oil буюу манай зуухны түлш үйлдвэрлэнэ. Энэ зуухны түлшний 60-аад хувийг бид өөрийнхөө станцдаа ашиглах юм. Тэгэхээр цаана нь өөрөөр хэлбэл, reserve нөөц 30 хувь нь буюу 17 мянган тонн түлш байгаа.

Хоёрдугаарт нь түүхий эдийн уян хатан чанар гэж байна. Тэгэхээр үйлдвэр ерөнхийдөө манай Тамсагийн сав газрын тосны шинж чанарт зориулж Консефил дизайн бол хийгдсэн. Тэгэхээр энэ, тэгэхдээ бид нар байгууламж тус бүр дээрээ бид нар уян хатан чанарын тийм процент бол тавигдсан байдаг. 10-20 хувь ер нь устөрөгчийн үйлдвэртэй учраас уян хатан байх уу гэвэл яах вэ гидрокрекийн гэдэг тоног төхөөрөмж өөрөө уян хатан, илүү технологийн уян хатан нөхцөлийг бий болгодог учраас бид нар сонгосон байгаа. Гэхдээ хэт их хүхэр агуулсан манай үйлдвэрт хэцүү.

Яагаад гэвэл бид нарын хүхрийн үйлдвэр маань 10 хувийн хүчин чадлын нөөцтэй. Түүнээс биш өөр өөр шинж чанар өгөгдлүүд, нягт байдаг юм уу өшөө зууралдаг чанар иймэрхүү юман дээр бид нар бол хүлцэх түвшин өндөртэй гэсэн үг.

Тэгэхээр өөр төрлийн тос үйлдвэрлэж болно уу гэвэл болно. Гэхдээ зарим хэт их хүхрийн агуулгатай тосыг үйлдвэрлэхэд хүндрэлтэй, боловсруулахад хүндрэлтэй.

ЕСР-2, 3 дуусаагүй байна гэж байна. Золжаргал гишүүнээ энэ тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл гэдэг юм харилцан адилгүй хэр нь нэлээн их хугацаа шаарддаг хэсэг байна. Тэгэхээр ер нь хамгийн их урт хугацаа шаарддаг нь инженерчлэл байдаг юм байна.

Угсралт бол хамгийн хүнд тоног төхөөрөмжийг 3 сард л угсарна. Зарим нь ерөөсөө хэдэн хоног 3 долоо хоног, 2 долоо хоног гэгчихсэн байгаа юм.

Ялангуяа тэр ихэнх нь үйлдвэрт чинь цамхгууд, тэгээд компрессор, насос, шугам хоолойнууд байгаа юм.

Шугам хоолойнууд ингээд хойтонгоос баригдаад эхэлнэ. Тэгэхээр зарим насос, компрессор энэ тэр бол 18 сар хүртэл хугацаанд үйлдвэрлэл гэж байна. Авчраад суурилуулахдаа 2 долоо хоног. Тэгэхээр үйлдвэрлэл бол эхэлчихсэн. Тоног төхөөрөмж энд тэнд үйлдвэрлэгдээд явж байгаа.

Тэгэхээр тэр бол талбай дээр бол харагдахгүй. ЕСР-2-ын ажил бол 27 оны эхэнд дуусах ёстой. 3 буюу цахилгаан станцын ажил бол бидний төлөвлөгөөгөөр бол 26 оны сүүлээр бол дуусах ёстой. Гэхдээ манайх урьдчилгаа төлбөрийг Экзим банкнаас гэрээ байгуулснаас хойш жилийн дараа олгосон нэг ийм хүндрэлтэй юм гарсан. Тэр утгаараа яах вэ 4 сараар бид нар цаашаа сунах байх гэж бодож байгаа юм.

Тэгэхээр 26, 27-нд энэ хоёр ажил бол хоёулаа дуусна. График төлөвлөгөө, дээрээс нь бид нар хоцрогдлыг арилгах ийм төлөвлөгөө боловсруулаад ашиглалтад ажиллаад явж байгаа.

Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтын өмнөх захиргаа гэж байна. Шинээр бий болсон өмч хөрөнгө.../минут дуусав./

С.Ганбаатар: Нэмээд нэмээд микрофоныг нээе.

Д.Алтанцэцэг: Ашиглалтын өмнөх захиргаа гэдэг юм бол бид нар анхандаа ярихгүй. Энэ төрийн өмчийг Төрийн өмч, Сангийн яам Уул уурхайн яам энэ тэр ингээд Засгийн газар хариуцаад ингээд явах байх гэж бодож байсан.

Гэхдээ бид нар хэдэн сар хэлэлцэж засаг дээр хуралдсаны эцэст бид бас манай компани ашиглалтын өмнөх захиргааг өөрсдөө аваад явах нь зөв юм байна, бас тийм

боломж байна гээд ингээд явж байгаа. Гол ганцхан бидний чадахгүй байгаа юм юу гэвэл энэ үйлдвэрийн талбайгаас алслагдмал орших Бор хөөврийн говь гээд усны эх үүсвэр дээр байгаа 11 худаг байж байна. Түүнийг, түүн рүү татсан энэ усны шугам хоолой, дээрээс нь цахилгааны дулаан дамжуулах агаарын шугам энэ хэдийг л бид нар бас дотоодын цэрэг худаг, усыг бас өөрсдийнхөө хуулийн хүрээнд хараа хяналт тавьдгаараа тавьж өгөөч гэсэн хүсэлт тавиад, төсөвтөө суулгаж өгөөч гэсэн. Яагаад гэвэл эд нар зөвхөн төсөвт хамгаалалт хийнэ гэж байгаа юм.

Цахилгааны шугамыг болохоор Багануур, зүүн өмнөд бүсийн Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээг хариуцаж хийж өгөөч гэсэн одоогоор нэлээн хэт их.../минут дуусав./

С.Ганбаатар: Болно. Ганзориг гишүүн, Золжаргал гишүүн тодруулъя. Дуусаагүй юу? 4 номерт дахиад нэмж хугацаа өгье.

Д.Алтаниэцэг: Ингээд цаашид ер нь ингээд юмнууд баригдаад бий болоод байдаг. Энийг харж хамгаалах юм гарах нь. Энэ дээр бас төр засаг анхаараасай гэж бодож байна. Хулгай их гарч байна. Энэтхэгүүд Хятадуудын компаниудын ярьж байгаа юм л хулгай байна тийм ээ? Тэгэхээр бид нар катодын хамгаалалт гээд хэдэн метр дотор тавьдаг зэс утсыг хуртэл аваад явчхаж байна.

Хойтон жил дамжуулах хоолой бүгд баригдана. Дамжуулах хоолойг дагасан цахилгаан эрчим хүчний 500км шугам баригдаж байна. Энэ харуул, хамгаалалтын асуултыг манай улс өөрөө өмчтэй болж байгаа юм чинь энд анхаарал хандуулаасай гэж бодож байна.

Энэ хяналтын асуудал Золжаргал гишүүнээ хяналтын асуудлыг бид нар төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээгээрээ Универс инженер манай өмнөөс тэр хяналтын зураг, төсөл, худалдан авалт, барилга угсралт, хяналт тавих юуг төслийн менежментийн зөвлөлд, зөвлөхөд шилжүүлсэн. Гэхдээ цахилгаан станцыг Эрчим хүчний тухай хуулиар Эрчим хүчний хөгжлийн төв хяналт тавьж байгаа.

Дээрээс нь барилгын ажилтан нь бол Барилгын хөгжлийн төв хяналт тавьж ингэж ажилладаг. Мөн манай компани нь бол ямар зорилготой ажиллаж байгаа вэ гэвэл бид нар бүгд ээлж ээлжээр энэ ажилд хяналт тавьдаг л ийм ажил хийдэг. Баярлалаа.

С.Ганбаатар: Тодруулах уу? Золжаргал гишүүн тодруулъя.

Ж.Золжаргал: Нөгөө Петро матадын эсвэл өөр төрлийн юун дээр судалгаа хийсэн байгаа болов уу? Өөр төрлийн эх үүсвэрүүд дээр, түүхий эд дээр?

4 дүгээр микрофоныг нээе.

Д.Алтаниэцэг: Петро матадын тос болно. Бид нар Петро матадын тосны судалгааг авсан байгаа. Ерөнхийдөө 1 сав газрын Тамсаг-ийн сав газрын тос учраас 19, 20, энэ манай Давст 31, Хөх нуур эд нарын тосны шинж чанар бол туйлын ойролцоо байгаа.

Зүгээр Өмнөговийн Галбын говиос, Галбын, Галба баруун тийм үү талбайн тос бол харин манай энэ Тамсагийн сав газрын тосноос эрс ялгаатай юм байна лээ. Бүх тосыг шинжилж үзээгүй. Анхны үйлдвэрийн ТЭЗҮ, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Энтертек гээд Их Британийн лабораторид хийсэн тосны шинжилгээ дээр суурилж хийгдсэн. Дараа нь бид нар 2 газар дахиж шинжилгээ хийлгэсэн.

С.Ганбаатар: Ганзориг гишүүн асуулт асууя. Ганзориг гишүүний микрофоныг нээе.

П.Ганзориг: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. 3 асуулт байна

Нэгдүгээрт, яг энэ Энэтхэгийн Засгийн газартай байгуулж байгаа хөнгөлөлттэй зээлийн үнийн дүн Энэтхэгийн компаниудаар гүйцэтгэлд гүйцэтгэх гэж байгаа энэ хэсэг дээр, гэрээнүүд дээр дотоодын гэдэг юм уу Монголын талаас туслан гүйцэтгэгч авч байгаа тийм зүйлүүд юу байна? Хэдий хэмжээний байна байвал? Тэр нь тэгээд доллароор гэрээ нь хийгдээд яваад байна уу, эсвэл төгрөгөөр байгаад байгаа юм уу? Үнийн өсөлтийн асуудал яригдаж байгаа учраас бас энийг тодруулах ёстой.

Тухайлбал, яг энэ бүтээн байгуулалтын ажлууд явж байна. Үйлдвэрийн барилга, байшин, ажилчдын орон сууц гээд энэ яг барилга бүтээн байгуулалтын ажлын гол түүхий эдүүд байж байгаа шүү дээ. Арматур, ган хийц, бетон гээд тэгээд энийгээ энэ дотоодоос аваад байгаа юм уу? Яаж аваад байгаа юм? Энэ үндсэн гэрээ дотроос үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн бас тодорхой хэсэг нэлээн том хэсэг болоод явж байгаа.

Хоёрт, энэ газрын тосны үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын зардал хэд болох вэ? Энэтхэгийн Засгийн газартай байгуулсан гэрээний хүрээнд бол ингээд сүүлд тэрбум 236 сая доллар болоод одоо ингээд 400 гаруй сая доллар нэмэгдэх гээд асуудал явж байгаа юм байна. Хөгжлийн банкнаас 250 тэрбум төгрөг аваад энэ дэд бүтцийн асуудлууд руу оруулчихсан явж байгаа. Мөн дамжуулах хоолой дээр Норинк-тэй нүүрсний урьдчилсан нөгөө төлбөрөөр 400 орчим тэрбум төгрөгийн ажил хийгдээд явж байгаа. Тэгэхээр нийт өртөг нь хэд болох вэ?

Дараагийнх нь ингээд үйлдвэр маань бариад ашиглалтад орчихлоо. Эцсийн бүтээгдэхүүн гарлаа. Тээвэр ложистик нь яаж явах юм бэ? Энэ зүгээр энгийн ийм авто замаар явах боломжгүй шүү дээ. Асар өндөр даацын ачаа тээврүүд явна. Тэр тээвэр ложистик, тэрийг гүйцэтгэх машин, техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын энэ чинь галын маш өндөр эрсдэлтэй тээ? Энэ зүйлүүдээ яаж төлөвлөж байгаа юм? Авто зам юм уу, төмөр зам юм уу? Тэр дээр өртөг яаж бас өөрчлөгдөх вэ? Ямархуу өртгийн тооцооллууд байгаа вэ? Энэ нефтийн бүтээгдэхүүн маань гараад дотооддоо үйлдвэрлээд ирэхээр хамгийн гол юм нь энийг барьсны ач холбогдол бас үнэ байх ёстой. Эдийн засаг үр ашигтай байх ёстой шүү дээ. Үндэсний аюулгүй байдал чухал.

Тэгэхдээ эдийн засгийн хувьд үр ашигтай байхгүй бол нөгөө л төрийн өмчийн компаниудтай адилхан асар өндөр алдагдал үүсдэг, татаас үүсдэг ийм нөхцөл байдал руу үнээ тогтвортой байлгахын тулд орно. Тэр үнэ яг баталгаатай өсөлтгүй байхад бас нөлөөлдөг юм нь үндсэн түүхий эд, түүхий тос. Энийгээ энэ төлөвлөгөө дээр аудитын дүгнэлт дээр бол 1300 орчим төгрөг гээд тавьчихсан байна лээ, 1300 хэдэн төгрөг гээд. Энэ урьдчилж тохирчихсон зүйл юм уу, цаашаа ер нь энийг тогтвортой байлгах дээр өртөг гарч ирэхэд нөлөөлөх үндсэн бүтээгдэхүүн дээр яаж үнээ тогтвортой байлгах юм бэ? Ийм асуултууд асууя.

Мөн энэ гэрээнүүдийг маш богино хугацаанд нэмэлт, өөрчлөлтүүд оруулаад яваад байсан байгаа. Энэ 992 сая долларын 6 гэрээ байж байгаа. 5 гэрээ, 6 гэрээ байж байгаа. ЕСР-1-гээд тэгэхэд чинь л бараг сар ч болоогүй нэмэлт, өөрчлөлт орж байсан байгаа юм. 2023 оны 8 сарын 23-нд хийсэн, 11 сард, 8 сарын 30-нд хийснийг 9 сарын 28 гээд. Энэ 28 хоноод энэ өөрчлөлт орчихсон. Энэ ямар шалтгаанаар ингээд заримд нь 3, 4 удаа ингээд өөрчлөлтүүд ороод байсан юм богино богино хугацаатай? Ийм асуултууд. Баярлалаа.

С.Ганбаатар: 4 дүгээр микрофоныг нээе.

Д.Алтанцэцэг: Би 1 дүгээр асуултыг их сайн ойлгосонгүй. Монголын талын туслан гүйцэтгэгчдэдээ хэр зэрэг оролцож байна гэж байна тийм үү? Сая тэр технологийн бус барилга байгууламжийн ажил буюу ЕСР-1-д Монголын талын 50-иад компани оролцсон. Энэ дээр бол бас Монголчуудын хийж чадах ажил их байсан. Ер нь бас хэл ам ихтэй, маш их тийм бас бас хүндрэлтэй зүйлүүд байсан. Тэгэхдээ яах вэ энэ ажил дуусаж байна.

Манай компани бол зөвхөн тэр ерөнхий гүйцэтгэгчтэй л гэрээ байгуулаад, ерөнхий гүйцэтгэгч нь өөрөө зөвлөх болоод, барилга угсралтын, ханган нийлүүлэлтийн ямар компани сонгохоо өөрсдөө шийддэг. Өөрсдөө тендер зарладаг юм уу, яадаг юм ингэж явдаг. Бид бол ЕСР гэрээнийхээ хүрээнд л эрх, үүргээ шаарддаг.

Энэ жилийн хувьд бол бид нар дөнгөж саяхан бас энэ тоог авсан. Энэ Мега инженеринг гэж компанийн энэ өдөр тутмын ажилд 36 монгол компани оролцож байгаа юм байна. Ихэнх л ханган нийлүүлэх юм шиг байна лээ. Бетон ган гэдэг бол бетон Монголынх мэдээж тэр чигээрээ. Ган гэдэг бол ган хийцүүд бүгдээрээ цаанаасаа нөгөө Эй Пи Ай стандарт гэдэг юмны дагуу хийгдэж байгаа.

Ер нь бүх төрлийн тоног төхөөрөмж, энэ шугам хоолой бүгдийнх нь материалын юу гэдэг бол бүгд стандартын дагуу явагдаж байгаа. Тэр Энэтхэгт ч байна уу, Хятадад ч байна уу, Орост ч хийгдэж байна уу яг тэр стандартын дагуу л материалын орц түүнийг бол очиж үйлдвэрлэхээс нь өмнө очиж шалгадаг хөндлөнгийн хяналтууд хүртэл хийгддэг. Энэ бол ган бол Энэтхэгээс, Хятадаас авч байна.

Нийт хөрөнгө оруулалтын зардал бол ТЭЗҮ-ээр бодсон тоо тэрбум 236. Ингээд сая ингээд түүнээс хойш 6 жилийн дараа л үйлдвэрийн инженерчлэлд, дээрээс нь дэлхийн дахин нүүрлэсэн энэ үнийн өсөлт, цар тахал, геополитикийн асуудал бид нарын инженер... шатанд хийсэн маш олон өөрчлөлтүүд, ингээд дээрээс нь лиценз эзэмшигч, технологийн лиценз эзэмшигчдээс тавигдах шаардлага эдгээрээс болоод үйлдвэрийн бүтээн байгуулалтын энэ нийт хөрөнгө оруулалтын зардал 34 хувиар өссөн байна.

Хөгжлийн банкнаас бол 2018 оны 4 сард манай компанийн дэд бүтэц бусад шаардагдах Монгол Улсын Засгийн газрын хариуцаж хийх ажилд зориулж 248 тэрбум төгрөгийн зээлийн шугам нээсэн байдаг. Түүнээс одоо хэрэглэсэн нь 176 тэрбум төгрөг. Түүний ихэнх нь буюу 138 нь дэд бүтцэд зарцуулагдсан. Өөрөөр хэлбэл, төмөр замд 67 тэрбум, авто замд 35 тэрбум, цахилгаан дамжуулах агаарын шугамд 7 тэрбум, хотхонд одоогийн байдлаар 30-аад тэрбум ингээд зарцуулчихсан байж байгаа. Манай компанийн урсгал зардал мөн зээлийн Хөгжлийн банкнаас санхүүжиж явж байгаад 23 оны 3 сарын 1-нээс Эрдэнэс Монголоос урсгал зардлаа, цалин хөлсөө тавьдаг болсон.

Тээвэр ложистикийн хувьд энэ бас Монголчуудын хаа хаанаа бодох л ёстой асуудал. Манай компани үйлдвэр барих тийм.../минут дуусав./

С.Ганбаатар: 4 дүгээр микрофоныг нээе.

Д.Алтанцэцэг: Бид үйлдвэрийнхээ бүтээгдэхүүнийг авто замаар ч, төмөр замаар ч тээвэрлэх юм бүгдийг нь тод төлөвлөөд, бүх төлөвлөгөөний дагуу ажлууд хийгдэж байгаа.

Гэхдээ юуны урд, манай үйлдвэрийн урдуур явдаг төмөр замыг 4 салаалуулаад 4 янзын бүтээгдэхүүнийг зэрэг ачих ийм ачих, буулгах байгууламж төлөвлөгдсөн вагон системд. Мөн авто цистерд ачих байгууламж байгаа. Гэхдээ одоо улс орны хэмжээний том энэ ложистикийн асуудал гэх юм бол Монголын төмөр зам ч юм уу, Улаанбаатар төмөр зам ч юм уу, эс үгүй бол энэ бүтээгдэхүүнийг жижиглэн худалдаалдаг энэ том компаниуд ч гэсэн энийг эртнээс бодож энийг бас энд тэнд яриад эхэлсэн. Ярьж та нар шийдлээ олох хэрэгтэй, бид бол үйлдвэрээсээ ингээд худалдах юм уу, эс үгүй бол манай үйлдвэрийг Засгийн газар ингэж бас бэхжүүлж бид нар тэр 300 вагон системийг авч байгаад тэр Толгойт өртөөн дээр аваачиж өгөх юм уу, тэр Тавантолгой дээр аваачиж өгөх юм уу? Энэ бол бас монголчуудын манай төр засгийн өөрсдөө одоогоос бодож, төлөвлөх ажил юм байгаа юм.

Үйлдвэрийн эдийн засгийн хувьд гэх юм бол үйлдвэр бол, үйлдвэрийн түрүүн хэлсэн тийм үү? Энэ газрын тосны үйлдвэрийн эдийн засгийн хамгийн онцлог нь гэх юм бол нийт зардлын 80-85 хувь нь түүхий тос л байдаг. Тэгэхээр түүхий тосоо бид нар ямар үнээр, хэнээс авч чадах вэ гэдэг үйлдвэрийн эдийн засагт хамгийн том жин дарж байгаа асуудал. Тэгээд түүхий эдийн 10 хувь нь бусад зардал болдог. Ингээд ер нь бол бид нарын саяын бас үйлдвэрийн оновчлол энэ тэр гээд байгаа юм чинь катализаторуудыг олон жил бүр солихгүй, хэдэн сар тутам солихгүй, аль зарим нь 3 жил, зарим нь 7 жилд сольдог ийм катализатор энэ тэр бол авахаар ингээд төлөвлөж байгаа. Энэ бол бас үйлдвэрийн эдийн засагт өндөр ач холбогдолтой. Ер нь бүх зээлээ төлөөд. Дамжуулах хоолой, Эрдэнэс Тавантолгойдоо санхүүгийнхээ графикайн дагуу зээлээ буцааж төлөх, гэрээнд заасан байгаа шүү дээ. Буцааж төлөөд, Хөгжлийн банкны зээлээ төлөөд, Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг бид нар төлөөд дээрээс нь 25 хувийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг улс төлсний дараа 300-аас.../минут дуусав./

С.Ганбаатар: Ганзориг гишүүн тодруулах уу? Их тодорхой хариулбал их сайн шүү. Үгүй. мөн онолын юм яриад явчих юм.

П.Ганзориг: Би бас дахиад тодруулаад асуугаадахъя. Маш тодорхой. Энэ төслийн нийт хөрөнгө оруулалт гээд байгаа. Одоогоор орчхоод байгаа тэр Энэтхэгийн гэрээний дүн тэрбум 600 боллоо гэж бодъё, тэгээд Хөгжлийн банкны 250 дамжуулах хоолой, бүүр цаашилаад явах юм бол тээвэр ложистикийн асуудал чинь бизнес план байгаа гээд байгаа боловч тэр дээр яг энэ төмөр замаар тээвэрлэвэл ямар өртөгтэй болох юм дахиад? Авто замаар тээвэрлэвэл ямар өртөгтэй болох юм? Тэрийгээ тооцсон юм уу? Та нар болохоор үр ашигтай гаргаад хямдхан зарчихна гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чинь бизнес план дээр чинь тооцогдсон байх ёстой шүү дээ. Тэгэхээр төрийн өмчийн их олон компаниуд дараа нь маш өндөр алдагдал, татааст ордог учраас энийг зайлиггүй асууж тодруулах ёстой.

Хоёрт, та өөрөө сая хэллээ. Өртөгт гол нөлөөлөх түүхий эд бол газрын түүхий тос гээд. 70, 80 орчим хувийн жин дарж байна гээд. Энэ үнэ тогтвортой байх юм уу? Яах вэ нийлүүлэлтийг нь түрүүн гишүүд асуулаа шүү дээ нөөц нь байгаа юм уу гээд. Тэгвэл үнэ нь тогтвортой байх юм уу? Үйлдвэр барингуут дахиад үнийн өсөлт энд явагдчихдаг. Давуу байдлаа бий болгож, тэнд нөөц байгаа бол ганцхан тэндээсээ авна. Өөр хаанаас авах вэ? Хойноос түүхий тос авах уу дахиад тээвэрлэж, тэнд үйлдвэр барьчхаад? Тэгэхээр энийгээ яаж тооцож байгаа юм бэ гэдэг асуудал байна.

Түрүүчийн тэр Энэтхэгийн Засгийн газартай байгуулсан гэрээний хүрээнд дотоодын компаниуд болон бусад түүхий эд хэд, яг үнийн дүнгээр асуугаад байгаа юм бэ? Тэрбум 236 сая доллароос одоогоор бол одоогоор 256 сая доллар нь ашиглачихсан байна гээд байна шүү дээ. Энэний чинь яг хэдэн хувь нь дотоодод үлдэж байгаа юм бэ? Энэ бас

үнийн өсөлтөд яаж нөлөөлж байгаа юм? Доллар чинь 2017, 2018 оны үед 2400 байсан тээ? Гэрээ байгуулж байх, энэ ТЭЗҮ-г хийж байхад. Өнөөдөр 3600 болоод төгрөгөөрөө тооцох юм бол дотоодоос авч байгаа юман дээр бол үнийн өсөлтийн нөлөөлөл гайгүй байх. Тэгээд валютаар хийгдчихсэн, доллароор хийгдчихсэн энэ ТЭЗҮ шүү дээ тээ? Тийм болохоор энийг бас тодруулж асуугаадахъя. Энэ 2 дээртодорхой хариулт өгөөч.

С.Ганбаатар: Тооцоо судалгаа байна уу л гэж асууж байх шиг байна 4 номер.

Д.Алтаниэцэг: Бас ерөнхий хариуцлага байх даа. ЕСР гэдэг гэрээнд бид нар ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчтэйгээ хэдэн төгрөг, ямар гэрээ хийснийг бид нар мэдэх боломж байхгүй. Тэгэхээр 256-г зарцуулснаас хэдийг нь монгол компаниудад зарцуулчихсан юм байгаа юм бэ гэдгийг бид нарт мэдэх боломж бол жалга байна.

Түүхий тосны тухайд түүхий тосны үнэ үргэлж хэлбэлзэнэ. Энэ дэлхийн зах зээлийн үнэ, түрүүний 1300 ярьж байгаа чинь дэлхийн зах зээлийн сүүлийн 5 жилийн дунджаар бодчихсон байгаа. Тэгэхээр түүхий тосны үнэ хэзээ ч тогтвортой байхгүй. Харин тухайн дэлхийн зах зээлийн үнээр худалдаж авъя гэсэн ийм гэрээтэй байгаа.

С.Ганбаатар: Бид хэнээс асууж болох вэ? Хэлэх боломжгүй байна гэлээ шүү дээ. Тэр дээр бас санаа оноо байгаа болов уу? Тэгвэл бид Энэтхэгүүдээс асуух уу? Алдаржавхлан дарга хариулах уу?

Ганзориг гишүүн тодруулчихъя.

П.Ганзориг: Энэ ЕСР-1, 2, 3 гээд 3-4 дахин өөрчлөгдсөн байна шүү дээ сарын хугацаатай. Тэрийг бас хариулсангүй та. Яагаад ингээд сар ч болоогүй гэрээнд нэмэлт, өөрчлөлт ороод байдаг юм шалтгаан нь юу юм бэ?

Тэгээд миний гол асуугаад байгаа юм бол энэ төслийн хөрөнгө оруулалтын нийт өртөг нийт дүнгээрээ хэд болоод байгаа юм бэ? Тэр чинь өөрөө эдийн засгийн хувьд ямар үр ашигтай гэдгийг чинь тодорхойлоход аягүй чухал байхгүй юу. Бүгд мэдэж байгаа шүү дээ энийг.

Хоёрт, тээвэр ложистикийн асуудлаа шийдэхгүйгээр манайх үйлдвэрлэл барих зориулалттай, ойлгож байна. Тэгэхдээ энэ чинь томоороо бид нар чинь Монгол Улсын бас стратегийн болоод эдийн засгийн ач холбогдолтой ийм үйлдвэрлэл явуулж байна шүү дээ. Тийм болохоор үйлдвэрлэл бариад хойших асуудал нь бид нарт хамаагүй. гээд явбал энийг энэ одоо яам хариулах юм уу? Яам тооцож байгаа юм уу? Яах вэ энэ газрын тосны үйлдвэр хамаагүй байж болно. Энэ дээр тодорхой хариулт байх ёстой шүү дээ. Тэгэхгүй бид нар ашиглалтад оруулаад үйлдвэрийн барилга байгууламжаа дуусаад л болоо, тэрнээс цааш юугаараа тээвэрлэх юм, тэр нь өртөг үнэ нь ямар байх юм, тэрийг нь мэдэхгүй гээд байж болохгүй байх. Төмөр зам барих гээд байгаа гэж байна шүү дээ. Түрүүн.../минут дуусав./

С.Ганбаатар: Ганзориг гишүүн ард иргэд, сонгогчдын өмнөөс л асууж байгаа шүү.

Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

С.Жавхланбаатар: Ганзориг гишүүний асуултад хариулъя.

Нийт өртгийн асуудал ярьж байна. Тэрбум 600 гээд доллар гээд Энэтхэгээс авч байгаа зээл. Өглөөхөн Засгийн газар дээр яригдсан та бол нөгөө энийг, энэ яг төслийн

нийт өртөг мөн үү л гэж асуугаад байна шүү дээ? Тийм., тэгэхээр энэ дүндээ бид нар багтаана гэдэг ийм Засгийн газраас чиглэл барьж байгаа. Тэгэхээр энэ дүнг хэтрүүлэхгүй, энэ дүндээ төслийг багтаана л гэдэг л ийм. Гэнэт КОВИД гээд дахиад гараад, төслийн үйл ажиллагаа зогсохгүй л бол энэ дүн хэтрэхгүй гэдэг ийм шугамаар явж байгаа.

Мөнгөн урсгалын тооцоог бол анх, энэ чинь ТЭЗҮ нь анх 2018 онд батлагдаад, сая 23 онд шинэчлэгдсэн байгаа. Тэгэхээр ТЭЗҮ-ийнхээ дагуу л явна. Тэр үед 1 баррель түүхий тосны үнийг тооцож авахдаа.../минут дуусав./

С.Ганбаатар: 1 номерт хугацааг нь сунгая.

С.Жавхланбаатар: Одоогийн, өнөөдрийн ханишаар, өчигдрийн ханиш байсан байх 76 доллар байгаа. Ерөнхийдөө бол дотоод өгөөжөөрөө бол 16 хувьтай гарч байгаа ийм л төсөл. Зээлээ эргэн төлөх хугацаа 16 хувьтай, эргэн төлөх хугацаа нь бол 7.5.

Зээлийн тодорхой нарийн нөхцөлүүдийг бол нөгөө Сангийн яам хийдэг учраас Алтанцэцэг дарга мэддэг байж магадгүй. Бид нар бас Аж үйлдвэрийн яам бол энд анхнаас нь технологи болон ТЭЗҮ талаас нь энэ өөрөө Монгол Улсад хэрэгтэй төсөл гэдэг агуулгаар л бодлогыг л барьж байгаа. Тэгээд ТӨК байгуулаад “Эрдэнэс Монгол” компанид харьяалуулсан. Бид нар дотоод менежментэд огт оролцдоггүй. ТУЗ-д ганцхан хүн байдаг Хишигдалай дарга байгаа өнөөдөр.

Бид нар ТЭЗҮ-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөрөө бас батлуулдаг. Өөрөөр хэлбэл бас дан төрийн албан хаагч нар биш, мэргэжлийн хүмүүс сууж байгаад баталдаг ийм

С.Ганбаатар: Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ чинь бид бол 1.6 тэрбум доллар гээд, 5.5 их наяд өнөөдрийн ханишаар тийм ээ? 2018 оноос ТЭЗҮ батлагдчихсан байдаг. 2023 онд шинэчилчихсэн байдаг. Тэр анхны ТЭЗҮ хийсэн компани, зөвлөгөө өгч байсан компаниуд дээр ямар хариуцлага тооцож байгаа юм? Энийг сонсчихмоор байгаа юм.

Хоёрт гэх юм бол энэ 5.5 их наяд төгрөгөөр яг одоогийн энэ барих гэж байгаа боловсруулах үйлдвэрийг зүгээр ингээд юу гэдэг юм Зүүн Азийн зах зээл дээрээс яг энэ хэмжээний үйлдвэр хэдэн төгрөгөөр бүтдэг юм? Энийг судалсан юм байна уу яаман дээр, энэ манай энэ мэргэжлийн Алтанцэцэг захирал дээр байна уу? Асуучихъя.

Гуравдугаарт нь гэх юм бол одоо 431 сая доллар дахиад зээл авах гээд байгаа юм. Энэ зээл чинь хуучин 18 оны нөхцөлөөр явах юм уу, нэг бол өөр нөхцөлтэй явж байгаа юм уу? Та бол 1.75, жилийн 1.75 хувьтай гэж байна шүү дээ тээ? Тэгэхээр энэ дээр бас хариулт авчихъя.

Ерөнхийдөө хамгийн сүүлийнх нь асуулт бол энэ 2027 онд манай энэ боловсруулах үйлдвэр, газрын тосны боловсруулах үйлдвэр ороод өгөөж нь ямар байх юм? Та хэд ТЭЗҮ-ээр бас гаргасан л байх. ТЭЗҮ-ийнхээ тоог ядаж хэлчхээрэй.

Бид бол тэдий хугацааны дараа одоо хийсэн энэ 5.5 их наядын хөрөнгө оруулалтыг нөхнө, цаашдаа ингээж ажиллана гэдэг ийм зарчмын юмнуудыг эхлээд сонсчихъя.

Яагаад гэхээр ТӨК-уд одоо Засгийн газар дээр ч ярьж байгаа, Их Хурал дээр ч ярьж байгаа шүү дээ. ТӨК-уд бол алдагдалтай дандаа ажилладаг, төрөөс татаас авч байна гэсэн юм ярьж байгаа юм. Тэгээд та хэд маань ашигтай, улсад хэрэгтэй гээд яриад байдаг. Тэгэхээр яг энэ хэдий хугацаанд ямар ашигтай ажиллах юм? Энэ хөрөнгө оруулалтаа хэзээ нөхөх юм гэдэг талаар хариулт авчихъя. Асуулт, хариулт авчихъя. Тэгээд тодруулъя.

Төрийн нарийн бичгийн дарга хариулъя. 1 дүгээр микрофон.

С.Жавхланбаатар: Тэр ТЭЗҮ-тэй юуг манайхан өмнө нь нөгөө оролцож байсан хүмүүс маань дараа нь нөхөөд хариулчихна биз.

Түүрүүн би хэлсэн мөнгөн урсгалын тооцоо хэзээ нөхөх вэ гээд байгаа. Тэгэхээр дотоод өгөөж маань 16.6-гаар тооцогдож байгаа. Өнөөдрийн байдлаар энэ төслийн буюу нийт зээлээ саяын 1.6 тэрбум ам.доллароо 7.5 жилд нөхнө гэдэг ийм тооцоололтой тоо нь. Нөгөө талдаа бид нар яагаад ач холбогдолтой гэдэг анх энэ төслийг эхлүүлэхдээ л бодвол би яг эхэлж байх үед нь нөгөө шийдвэрт оролцоогүй учраас Монгол Улс маань 100 хувь хараат байгаа газрын тосны бүтээгдэхүүн. Импортоор одоогийн 10 сарын байдлаар 2 сая 200 мянган тонн дизель, АИ92, 95 гээд ингээд авсан байна. Миний санаж байгаагаар дунджаар энд бол бид нар 2 тэрбум ам.долларыг дунджаар жилдээ зарцуулж байгаа, гадагш нь урсгаж байгаа гэсэн үг. Орос руу өгч байгаа ер нь. 2 тэрбумыг жилдээ өгч байгаа гэсэн үг.

Тэгэхээр 1.6 тэрбумаар өөртөө, дотооддоо үйлдвэр бариад тэрнийхээ 55 хувийг одоо энэ гарч байгаа 2 тэрбум ам.долларынхоо бид нар 55 хувийг гадагшаа урсгахгүй л гэж байгаа л ийм л төсөл шүү дээ нэг талдаа.

Нөгөө талдаа стратеги, нөгөө аюулгүй байдал нөөцөө бодох юм бол өөр мөнгөн дүнгээр хэмжээлшгүй ийм ач холбогдолтой л төсөл гэж эхлүүлсэн байх гэж бодоод байна. Манайхан нөхөөд.

С.Ганбаатар: Очирбат гишүүн тодруулах юм уу. 2 номер.

Б.Анхбаяр: Очирбат гишүүний асуултад хариулъя.

Анх ер нь та бүхэн сайн мэдэж байгаа энэ төслийг Монгол Улсын Засгийн газар зээлийн эх үүсвэрийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулаад, тэгээд газрын тос боловсруулах үйлдвэрийг барья гэдэг шийдвэрийг гаргасан. Мэдээж энэ дээр Энэтхэг улсаас бид нар Эксим банкны өөрийнх нь яг тавьдаг шаардлагынх нь дагуу бид нар энэ зээлийг авсан.

Тэгэхлээр энэ дээр юу яригдаж байна вэ гэхлээр Эксим банк гэдэг банкны өөрийнх нь систем нь өөрөө яаж явдаг вэ гэхлээр мэдээж гаднын улсуудад төсөл хэрэгжүүлэхдээ өөрийнхөө улсын дотоодын бүтээгдэхүүнийг гадагшаа нийлүүлэх ийм бодлого баримталдаг ийм банкны эх үүсвэрээр бид нар энэ төслийг анх эхлүүлсэн.

Тэгэхлээр мэдээж та бүхний ингээд асуугаад байгаа асуултауд өртөг ингээд дээшээ өсөж байна, өөр ийм юунууд байж болох байсан уу энэ тэр гэдэг асуултауд асууж байна.

С.Ганбаатар: Нэмэлт, нэмж хариулъя.

Б.Анхбаяр: Байж болох байсан уу гэвэл байж болох байсан.

Гэхдээ мэдээж бид нар энэ дээр өөрсдийнхөө Монгол Улс өөрсдөө шийдвэрээ гаргаад ингээд явсан ийм төсөл. Тэгэхээр яах вэ энд хэлж байгаа санаа нь юу вэ гэхлээр төслийг анх эхлэх үед ТЭЗҮ-ийг боловсруулсан Engineers India limited гэдэг компани дээр хариуцлага тооцох уу гэдэг асуулт асууж байна л даа. Энэ дээр бид нар ямар хариуцлага тооцох вэ гэдгийг бас сайн мэдэхгүй байна. Ямар ч байсан 2018 онд ТЭЗҮ-ийг боловсруулсан. Сая Алтанцэцэг захирал хариулсан. КОВИД-ын цар тахлын үе мэдээж энэнээс нөлөөтэй, геополитикийн асуудлууд, дээрээс нь бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтүүдээс болоод ТЭЗҮ дээр мэдээж үнийн өсөлтүүд явагдсан. Тэгээд энийг манай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл үнэхээр ийм үндэслэлүүд байсан байна гэдгийг зөвлөлөөрөө гаргаж дүгнэлт гаргасан. Тэгээд энэний дагуу л ерөөсөө нэмэгдсэн асуудал явагдаж байгаа юм л даа.

С.Ганбаатар: 4 дүгээр микрофоныг нээе.

Д.Алтанцэцэг: Анхан 1 тэрбум 236 гэдгийг бүхэлд нь авч үзэж ингэж 1 гэрээ гэдэг байсан. Гэтэл Энэтхэгийн засгийн газрууд манайд бас энэ зээлийн эргэн төлөлт дээр бас нааштай өөрчлөлтүүд оруулсан юм. Юу гэхээр эхнийхээ тэрбум долларыг 3 хэсэгт хуваагаад өөрөөр хэлбэл, эргэн төлөгдөх хугацааг нь хойшлуулах зорилготойгоор. Уул нь анхан энэ 1 тэрбум 236 чинь шууд 23 оноос эхлээд төлөгдөх ёстой байсан байхгүй юу. Тэгтэл ингэж багцалж хувааснаараа, 4 хэсэгт хувааж хувааснаараа зээлийн эргэн төлөлтийг 7 болгоод, өөрөөр хэлбэл тухайн багцад мөнгө гарч эхэлсэн өдрөөс хойш 7 жилээр эргэн төлөлтийг нь сунгасан байхгүй юу. Тэгэхээр ЕСР-2, 3-ын анхны төлбөр 23 оноос эхэлж хийгдсэн юм.

Тэгэхээр 30 оноос эхэлж тэр зарцуулсан санхүүжилтийн эргэн төлөлтийг хийж эхэлнэ гэсэн үг. Ийм утгатайгаар 3, 4 хуваагаад ингээд Эксим банк манай Сангийн яам эд нар хоорондоо ийм одоо.../минут дуусав./

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: 5.5 их наяд, дээр нь дамжуулах хоолойн зардал нэмэгдэнэ, тэгээд дээр нь дахиад Засгийн газраас Хөгжлийн банкнаас авсан 250 тэрбум төгрөг нэмэгдэнэ. Тэгээд энэ чинь үндсэндээ ингээд 6 бараг 7 шахуу их наяд төгрөгөөр босгож байгаа тийм үү? Хөрөнгө нь байвал үйлдвэрийг барина л даа. Гол нь миний санаа зовоод байгаа юм нь цаашид энийг яг ашигтай, тогтвортой авч явж чадах уу л гэдэг асуудал байгаа юм.

Тэгэхээр би юу гэж хэлэх гээд байна гэхээр энэ төслийг хариуцаж байгаа яам, энэ газрын тосны боловсруулах үйлдвэр энийг цогцоор нь харах ёстой гэж үзэж байгаа. 2026-27 онд ингээд зээлээ эргэн төлнө, төлж эхэлнэ, хуваарь чинь тийм байгаа. Тэгэхээр одоо нэмэлт гэрээ байгуулагдаагүй байгаа 27 оны 12 сараас нааш ашиглалтад орохгүй гэдэг 36 сарын хугацаа гэрээ байгуулснаас хойш гэдэг зүйлийг тайлбарлаж байгаа.

Нэгдүгээрт, эргэн төлөлтөд ямар хүндрэл учрах вэ? Нэг.

Хоёрт нь дахиад энэ төслийн өртөг нэмэгдэхгүй гэдэг баталгаа байна уу? Давагдашгүй хүчин зүйлээс гадна. Үйлдвэр ажиллахад асуудал гарна. Жинхэнэ асуудал чинь яг үйлдвэр чинь ашиглалтад ороод ирэхээрээ л гарна. Энийг бид нар яг бодитой ойлгох ёстой. Яах вэ ингээд олон улсын нэр томъёо, гадаад, дотоод хэллэг их л гоё л яриад байгаа юм л даа. Цаашидаа яг энэ авч явна гэхэд үнэхээр хүнд шүү. Яагаад хүнд гээч? Сүүний үйлдвэр гээд бодъё. Энэ үйлдвэрийг харьцуулья. Тэгээд үнээ маань байна, газрын

доор тос маань байж байна. Магадгүй энэ тосыг бага олборлож байна, орон нутгийн эсэргүүцэл, ТББ, иргэний нийгмийн байгууллагуудын эсэргүүцлээс болсон гэдэг зүйлийг их хариуцлагагүй ийм тайлбар хэлж байна гэж би ойлгож байна. Би асуултаа асууж байгаа байхгүй юу. Тэгээд манай яам, мэргэжлийн байгууллагууд одоо болтол ийм дүгнэлттэй байгаа гэж үү? Бурууг бусдаас хайдгаа хэзээ болих вэ?

Тэгэхээр би гайхаад байгаа байхгүй юу. Одоо ингээд үндэсний олборлолтын компани байгуулна. Газрын тосны энэ үйлдвэр дээр явна гэж байгаа юм. Тэгээд энэ түүхий эдийн нөөцөө яг өөрөө дангаараа бүрдүүлж чадах юм уу? Эсвэл хөрш хоёр орон, Энэтхэг улстай үйлдвэрүүд цаашид ер нь авч явахад хамтарч ажиллах талаар ч гэдэг юм уу ийм зүйл байгаа юу?

С.Ганбаатар: Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга. Албан тушаалтнууд гишүүдэд хүндэтгэлтэй хандаарай. Бид аль болохоор хүндэтгэлтэй байгаа. Бид энэ газрын тос бидний мөрөөдөл. Оюу толгой бидний мөрөөдөл дээр тулгуурлаж том луйвар хийж биднийг өрөнд оруулсан. Ард түмний өмнөөс бид асуух ёстой. Та нар хариулах үүрэгтэй. Ингээд Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга 1 номер.

С.Жавхланбаатар: Уучлаарай Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Гишүүнтэй санал нэг байна хүний нөөцийн тал дээр. Энэ бол Монголчууд анх удаагаа газрын тостой, тосны үйлдвэртэй болж байгаа ийм кэйс. Тэгэхээр хүний нөөцөө бэлтгэх талаар асуусан уу? Эхнийх нь тийм байсан, дараа нь би нөөц рүү л орох гэж байна л даа. Тийм

С.Ганбаатар: Төрийн нарийн бичгийн дарга хариулаарай.

С.Жавхланбаатар: Яах вэ би гүйцээчихье. Хүний нөөцийн асуудал дээр бол яам, Ашигт малтмалын газрын тосны газар, төсөл хэрэгжүүлж байгаа компани бид нар бол төлөвлөгөө гаргаад явж байна. Хамгийн чухал, мэдээж энэ эхний үедээ энэ гадаадын тоног төхөөрөмж орж ирж байгаа. Бид нар угсралтын үед зарим хүмүүсээ бэлдэнэ. Түлхүүр инженерүүдийг. Ашиглалтын явцад эхний 3-4 жил дадлагажуулах, сургах, нөгөө тоног төхөөрөмжүүдээ хэрхэн яаж ажиллуулах вэ, эвдлэхгүй байх вэ гэдэг тал дээр ийм төлөвлөгөө гаргаж ажиллуулах үүргийг ерөнхийдөө төсөл хэрэгжүүлэгч компанидаа өгөөд ингээд явж байгаа.

Тийм учраас энэ ашиглалтын өмнөх захиргаа буюу энэ үйлдвэрийг цаашид авч явах багийг яаж бэлдэх вэ гэдэг асуудал хөндөгдөж байгаа.

Нөөц тасрахгүй байх уу гэдэг асуудал яригдаж байна. Энэ бол өнөөдөр бас Засгийн газрын хуралдаанд өглөө яг адилхан асуудал хөндөгдсөн. Петрочайна компанитай Монгол Улсын Засгийн газар татварын маргаантай байгаа. Энэ газрын тосны боловсруулах төсөл маань ялт ч үгүй хоолой тавьсан нөгөө Матдын, тэр сав газрын газрын тосны үйлдвэрлэгч нартай холбоотой. Тэр дундаа Монгол Улсад анх удаа 92 онд орж ирээд өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулж байгаа Петрочайна компани буюу Хятадын 1 номер “Си Эн Пи Си” компанитай шууд холбоотой.

Ийм учраас Ерөнхий сайд 2 долоо хоногийн өмнө байх, очиж манай Туваан сайд хамт энэ компанийн удирдлагатай уулзаж, олборлолтоо нэмэгдүүлээч гэдэг хүсэлтийг тавиад явж байгаа. Нөгөө талаас мэдээж манайтай татварын маргааны асуудлаа эргээж тавьж байгаа.

Тэгэхээр нөөцийг гишүүний асуусан найдвартай нөөцөөр хангах чиглэлээр Засгийн газар ингээд чиглэл бүрээр ингээд ажиллаж байгаа гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн маш чухал. Энэ бас газрын нөөцтэй холбоотой асуудал дээр их олон жил бас ажилласан. Асуултад тодруулах уу? Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Би хангалттай хариулт авч чадсангүй. Ингээд асуулт асуухад өөр юм яриад байгаа байхгүй юу. Нөөцөө бүрдүүлнэ гэдэг асуудал чинь энэ үйлдвэр барихтайгаа зэрэгцээд явах ёстой байхгүй юу. Би бол шүүмжлэлтэй хандана. Энэ бол зөвхөн эхлэл шүү.

Яагаад гэвэл энэ улс орны хувь заяаны асуудал, олон иргэдийн хүлээлтийн асуудал, Монгол Улсын Засгийн газрын зорьж байгаа мөрөөдөж байгаа зүйл. Тэгээд ажил хариуцаж байгаа хүмүүс ийм маягаар хандах юм бол энэ үйлдвэр цаашид ажиллахад хүнд болно. Ерөөсөө энэ ажлын гүн рүү орохгүй байгаа байхгүй юу. Яаж олборлолтоо нэмэгдүүлэх юм, яаж энийг байгаль орчинд ээлтэй, шинэ технологиор, яаж өгөөжтэй байдлаар явах юм бэ гэдэг дээр та нар анхаарлаа хандуулах ёстой шүү дээ.

Тэгэхгүй зүгээр ингээд энд нэг асуултад хариулчхаад тэндээ очоод мартаад байвал энэ нөөц чинь хэзээ ч бүрдэхгүй. Би энийг баталгаатай хэлье. Энэ тэмдэглэлд үлдэж байгаа. Би энийг 27 оны 12 сарын 31-нд би дахиад асууна.

С.Ганбаатар: Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Газрын тосны үйлдвэрийг бид барьж байгуулна. Асуудалгүй, тэгж бодож байна. Монголчууд ч бас энийг барьж байгуулахад чадна гэж бодож байна. Та бүхэнд амжилт хүсье.

Энэ байгуулагдсанаар бол бас л дотоодын химийн үйлдвэрүүд, пропан, бутан сая Эл Пи Жи дотооддоо хангачихна гээд бас яриад байна. Бас зөв л асуудал.

Гэхдээ Бадамсүрэн гишүүнтэй санал нэг байна. Түүхий эд, түүхий тосоо бид яаж хангах юм бэ? Одоо 400 тонноос, 400 саяас 500 сая түүхий тос л үйлдвэрлэж байгаа юм байна. 500 мянга. Дээрээс нь үйлдвэрийг явуулахын тулд 1 сая түүхий тосны асуудал яригдана тийм биз? Өнөөдөр гэрээ байгууллаа гэхэд чинь 32 сарын дараа ашиглалтад орох юм байна. 1 сая энэ нефтийг бол 32 сарын дотор та нар олборлож чадахгүй. Энэ бол баталгаатай. Би тэгж бодож байна. Хэчнээн ч их 100 хувь саяын газрын тос олборлох, дэмжиж ажиллаад, хөрөнгө оруулалт хийгээд энийг амжихгүй.

Тэгэхээр энэ эх үүсвэрийг өөр эх үүсвэрээс бол нөхөх хэрэгтэй Нэгдүгээрт, ОХУ. Дахиад ОХУ-тай хараат.

Хоёрдугаарт бол Хятад улс. Хятад Орос улсын нутаг дэвсгэрээр дамжуулж авах, Казакстан улсаас авах. Энэ авсан газрын тос бол үйлдвэрийн энэ технологит тохирох уу, үгүй юу? Ийм төлөвлөгөө хийж байгаа ажлууд байна уу ер нь? Энэ бол их чухал шүү. Энэ асуудлыг шийдэхгүйгээр бол цаашаа явахгүй. Хийж байгаа дээрээ маш зөв, технологи нь зөв, хийх нь зөв. Гэхдээ энэ үйлдвэрийг тогтвортой цаашаа авч явах асуудал хүнд байгаа. Би энэ дээр санаа зовж байгаа.

Энэ дээр тодорхой төлөвлөгөө байна уу? Энэ бодлогын яамнаас хариулт авмаар байна.

С.Ганбаатар: 2 номерын микрофоныг нээж өгье.

С.Ганбаатар: 2 номер нэмж хариулъя.

Б.Анхбаяр: Хууль, эрх зүйн орчныг бид нар нэн яаралтай шинэчлэх шаардлагатай болсон. Орон нутгийн эсэргүүцэл, энэ татварын асуудал мэдээж. Аль дээр бас Бадамсүрэн гишүүн хэлж байсан орон нутагт ямар ч өгөөжгүй байна гэдэг асуудлыг ярьсан. Орон нутагт өгөөжтэй болгох асуудлыг ард иргэдийг энэ яг салбарыг ойлгодог ийм түвшинд аваачих ийм шаардлагууд гараад байна л даа.

С.Ганбаатар: Жангабыл гишүүн маш товчхон та тодруулаарай.

Х.Жангабыл: Үгүй тэгэхээр бид нар яах юм бэ? Түүхий эд нь байхгүй байна түүхий эд болсон нь. Тэгээд энэ үйлдвэрийг бариад хэрэг байна уу тэгээд?

С.Ганбаатар: Асуултад хариулъя 2 номер.

Б.Анхбаяр: Энэ асуудал дээр гишүүн бидний зүгээс болох бүх л шийдлүүдийг гаргаж ажиллаж байна. Сая өнгөрсөн Засгийн газрын хуралдаан дээр бид нар шинээр 3 бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулахаар Засгийн газраар оруулсан. Дэмжигдсэн. Дахиад бид нар 3-ыг оруулна. Түүрүү манай Хишигдалай дарга бас хэлсэн газрын тосны илэрч бүхий талбайнууд байна. Энэ дээр үйл ажиллагааг нь тогтвортой явуулах л арга хэмжээнүүд авмаар байна. Петрочайна компанитай бид нар энэ бүтээгдэхүүн хуваах гэрээ болон хуулийн маргаантай асуудлаа шийдчих юм бол хөрөнгө оруулалтынхаа асуудал нь бас тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ. Бид нар нэмэлт эрэл, хайгуулаа хийнэ.

Ер нь 2027 он гэхэд бид нар газрын тос боловсруулах үйлдвэрээ түүхий эдээр 100 хувь хангахын төлөө хичээж ажиллаж байгаа гэдгийг л хэлье.

С.Ганбаатар: Асуултад хариулт авах шиг боллоо. Би 2 үг хэлчээд, дараа нь Мөнхбаясгалан гишүүн асуулт асуугаад, бас үг хэлэх юм байна.

Гишүүд асууж, тодруулж байгаа зүйл нь болохлоор газрын тосны үйлдвэрлэлийг бид бүгдээрээ дэмждэг, энэ Монгол орон даяараа дэмжиж байгаа. Тэгээд энэ дээр маш их олон зуун, тэрбум төгрөг зарцуулаад хугацаа нь дандаа хойшлоод байгаад, тодорхойгүй байгаад, үр дүн нь муу байвал Улсын Их Хурлын гишүүд бид бас асуугаагүй гэдэг асуудалд орно. Тодруулаагүй, хяналт тавиагүй. Энэ дээр албан тушаалтнууд маань битгий ундууцаж уурлаач дээ. Та нарын хувийн мөнгийг асуугаагүй шүү дээ биднүүс. Энэ зээл байж болно. Бэлгийн морины шүдийг үзэхгүй гэдэг шиг та нар зээл дээр юун сүртэй юм бэ гэдэг хандлага битгий гаргаарай. Энийг дараа нь Монголын ард түмэн хүүтэй төлдөг. Энэ бол өр болно шүү дээ. Хэрвээ дампуурах юм бол. Сайн байвал та нарын л ажил.

Тэгэхлээр Монголын ард түмэн энийг мэдэх ёстой юм байна. Тэгээд тодруулж асуусан зүйлүүд бол үе үе үнэ өсгөөд л оруулж ирээд байгаа. Гарцаагүй юм байгаа байх. Тэрийгээ тодорхой мэргэжлийн түвшинд, шинжээчийн дүгнэлттэйгээр тодруулж ард түмэнд тайлагнаач л гэдгийг би гишүүд асуугаад байна.

Тэгээд үнэ өсөж байгаа дээр ихэвчлэн эрх зүйн орчин муу. Сая манай зарим дарга нар бүүр ард иргэдийн эсэргүүцлээс болоод л үнэ өсөж байгаа юм шиг яриад байна, гацаа үүсээд байна гэдэг юм ярьж байна шүү. Тэр үнэ өссөн дээр эрх зүйн орчин муу, гадаад зах зээл, экспертүүд муу, дэд бүтэц байхгүй гэдэг энэ асуудлууд ярьсан. Энийгээ урьдчилж ТЭЗҮ болон эдийн засгийн тодорхой үндэслэлүүд дээрээ тооцоолоогүй юм уу? Эрх зүйн

орчин гэвэл сүүлдээ Улсын Их Хурлын гишүүд буруутай болж байна шүү дээ. Гишүүдээс болоод энэ чинь ерөөсөө гацаад байгаа гэдэг асуудал үүсэх гэж байгаа байхгүй юу.

Тэгэхлээр тоо баримт, үндэслэлээр энэ их олон сая доллар нэмж авах болж байна. Өмнөх ЕСР гээд яриад байгаа 1, 2, Монгол хэл баялаг шүү дээ. Энийг бас хэдүүлээ монголчууддаа ойлгомжтой ярих ёстой, монголчууд ойлгох эрхтэй та нар ойлгуулах үүрэгтэй. Бид ч гэсэн. Тэгэхлээр түрүүн асуугаад байна үйлдвэрлэл рүүгээ яг өнөөдөр хэд орсон юм бэ гэдэг тодруулж асуугаад байсан ерөөсөө хариулаагүй. Сүүлдээ бүүр болох бүх асуудлыг л бидний зүгээс шийдвэрлэх гэж оролдож байгаа л гэж ярьж байна. Ямар ч баталгаа байхгүй шүү л гэдэг асуудал яриад байна шүү дээ. Би бол энэ төсөл газрын тос бий болоосой гэж үнэхээр мөрөөддөг, дэмждэг фен.

Гэхдээ энэ нь монголчууд үр дүнтэй байгаасай л гэдэг ийм байр суурьтай байгаа шүү. Тэгээд Мөнхбаясгалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Л.Мөнхбаясгалан: Асуултаа эхэлж асуучхаад дараа нь үгээ хэлье. ЕРС-3 буюу багц 3 дээр 35мвт-ыг-ын ДЦС 189.7 сая долларт хийнэ гэсэн байна.

Энэ яг 1мвт-ыг нь хэдээр тооцож гаргаж энд барьж байгаа вэ? Энэ дээр бас нэг ойлгомжгүй юм байна л даа. ЕРС-3 дээр чинь Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 219 дүгээр тогтоолоор үйлдвэрийн ДЦС угсралтын ажлын захиалагчийн техникийн хяналтын ажилд шаардлагатай санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” компаниас гаргана, шийдвэрлэхээр болсон гэж байна. Энэ ямар учиртай юм? Энэ тэгээд гаргасан уу? Тэгээд зээлийг жил болгоны, жилд 13 сая доллароор төлнө тийм үү? Үйлдвэр ашиглалтад орсон цагаас эхлэн. Энийг төлөөд дээрээс нь та бүхний сая амлаж байгаа тэр гоё газрын тосоо нэрээд, үйлдвэрлээд ашгаа олох уу?

Дараагийн асуулт гэрээ монгол хэл дээр байгаа юу? Миний асуултад ирүүлсэн гэрээ Англи хэл дээр ирсэн. Болсон.

С.Ганбаатар: Тодорхой хариулъя 4 номерын микрофоныг нээж өгье.

Д.Алтаниэцэг: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Түрүүн ЕСР 1, 2, 3 дугаар багц ажил, 4 хараахан байгуулаагүй. Багц ажлуудын ер нь нийт үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зардал энэ тендерт ирүүлж байгаа үнээр тодорхойлогдож байгаа гэж хэлж байгаа.

Тэгэхээр бид нар бол энэ хэлэлцээ хийхдээ 1мвт ийм түлштэй цахилгаан станц ийм, тийм түлштэй бол ийм энэ тэр гээд бид нарын ямар л хийж байгаа ажил тэр тооцоолол л байгаа юм. Тэгээд яах энэ тендерийн үнийг бид нар ингээд бууруулсан. Тэрнээс өөрөөр чадахгүй, цуцалсан, дахин зарласан. Эцэст нь ямар риск байсан бэ гэхээр огт тендер хүлээж авахгүй байх тиймээ, төсөл зогсох ийм эрсдэлтэй.

Тэгэхээр бас 389 сая долларын санал аваад сууж байсныгаа бид нар бас Энэтхэгийн төр засгийнхны тусламжтайгаар ингэж тендерийн бичиг баримтад өөрчлөлт оруулж өрсөлдөөн бий болгож байгаад ингээд 189 сая долларын санал авсан.

2024 оны 219 дүгээр тогтоол гаргасан. Тэр техникийн хяналтын зардал гэдэг нь Мөнхбаясгалан гишүүнээ хар аа 2 хуулиар манай чиг, төрийн өмчтэй чиг үүргийн байгууллагууд хяналт тавих ёстой байдаг юм байна.

Жишээ нь, 5мвт-ын-аас дээш хүчин чадалтай цахилгааны эрчим хүчний эх үүсвэрийн барилга, байгууламжид Эрчим хүчний хөгжлийн төв зайлиггүй хяналт тавина гээд заачихсан байгаа юм.

Дээрээс нь Барилгын хөгжлийн төв бол дамжуулах хоолой, үйлдвэр хоёр хоёулаа Барилгын тухай хуулиараа онцгой төвөгшилтэй барилга, байгууламжийн төрөлд багтаж байна. Тэгэхээр онцгой төвөгшилтэй барилга, байгууламжийг заавал ч үгүй хөндлөнгийн зөвлөх барилгын экспертийг хянуулна гэхихсэн байгаа юм.

Тэгэхээр хэдийгээр гадаадын энэ байгууллагуудаар хяналт тавиулж байгаа ч гэсэн өөрийнхөө Монголын дотоодын барилгын тухай хуулийг дагаж мөрдөхийн тулд энэ 2 байгууллагаар Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төвөөр хяналт тавиулах шаардлага гарсан. Тэгэхээр энэ 219 дүгээр тогтоолоор энэ хяналтын зардлыг бол шийдвэрлэсэн юм.

Жил бүр 13 сая төгрөг, түрүүний тэр манай Төрийн нарийн бичгийн даргын ярьж байгаа cashflow дээр ЕСР-2, 3, 4 дүгээр багц ажлыг бол эхний 7 жил зээлийн эргэн төлөлтөөс чөлөөлнө гэхихсэн байгаа. Тэгэхээр 2, 3-ыг 2030 оноос, 4 дүгээр багц ажлын төлбөр энэ оны сүүлчээс гарвал 30 он, 25 оноос эхэлбэл 31 оноос эхэлж төлөгдөх юм.

Одоогийн 13 сая доллар төлөөд явж байгаа бол тэр 2, 3, 4 дүгээр багц ажлаас бусад ТЭЗҮ, лиценз эзэмшигчдийн төлбөр, төслийн менежментийн зөвлөх ЕСР-1-ийн энэ 4 нийлээд 203 сая ам.доллар-ын эргэн төлөлтийг хийж байгаа нь хүүтэйгээ 13 сая доллар байгаа.

С.Ганбаатар: *Мөнхбаясгалан гишүүн тодруулах уу? Шууд үг хэлэх үү? Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ.*

Мөнхбаясгалан гишүүний хугацааг дахиж өгье. Шинээр өгье.

Л.Мөнхбаясгалан: *Эрхэм гишүүд ээ,*

Монгол Улсын Их Хурлын гишүүний хувиар, мөн өөрийн сонгогдсон 7 дугаар тойргийн Алтанбулагийн газрын тос боловсруулах үйлдвэрийн явцын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад асуулт тавьж, хангалттай хариултыг авсан.

Сая миний асуусан асуулт бол багц 3 дээр 35мвт-ын ДЦС гэж байгаа юм. Энэ 189 сая, 189.7 сая доллароор хийгдэнэ. Энд дэлхийн зах зээл дээр 1мвт нь 2 сая доллар байгаа. Манай энэ үнийг харах юм 5.4 сая ам доллар болж байгаа. Үүгээр би юу хэлэх гэж байна, юу хэлэх гэж байгаа вэ гэвэл угаасаа энэ газрын тос боловсруулах үйлдвэрийг барих энэ тендер зарлаж байгаа, ямар сонгон шалгаруулалт хийж байгаа, хэдэн төгрөгийг хааш нь хааш нь хуваарилж байгааг манай энэ газрын тосны үйлдвэрийнхэн буюу манай яамдууд мэдэхгүй.

Яагаад гэвэл энийг Энэтхэгийн тал давуу эрхтэйгээр хийж байгаа. Жишээ нь бид нар ингээд багц 1 дүгээр төсөл гээд л тендер зарлахад Энэтхэгийн Эксим банкнаас хураангуй жагсаалтыг ирүүлдэг. Энэ 7 компаниас сонго гэдэг. Тэр 7 компаниас сонгохоор 2 нь таардаг. 2 нь маш өндөр үнэтэй үнийн дүн хэлдэг. Энэ Алтанцэцэг дарга би таны зовлонг маш сайн ойлгож байна. Энэ 3, 4 багц дээр ирүүлсэн саналуудыг шувт нөгөө бүүр гэрээнийх нь 1.2, 1.4 их наяд тэрбум долларын санал хүртэл ирүүлсэн компани байгаа. Энийгээ буулгаач гээд л захидал бичдэг тийм үү? Тэгээд л ингээд л холбогдох яамдыг ажиллуулдаг, Засгийн газраас үнийг нь буулгаад өгөөч л гэдэг. Тэгээд тэд нар үнийг нь

буулгадаг. Тэрний дараа ажил эхэлдэг. Тэр нь ерөнхийдөө тооцоолж ч чадахгүй манай улс. Бид нар багц 1-ийг тэдэн сая доллароор хийнэ, багц 2-ыг тэдэн сая доллароор хийнэ гэж ямар ч юу байхгүй, тийм харах боломж байхгүй байхгүй юу.

Яагаад гэвэл гэрээ буюу тэр мөнгийг захиран зарцуулах тендерийн хураангуй жагсаалт ирж байгаа бүх юм Энэтхэг улсын мэдэлд байгаа.

Түрүүн Жавхланбаатар дарга ярьж байна л даа та 1.6 саяар энэ өртөг нийт өртөг тооцогдоно гэж Засгийн газар үзсэн. Үгүй. Энийг Монголын Засгийн газар мэдэхгүй. Жилийн дараа дахиад энэ Байнгын хороон дээр дахиад зээл авъя гэж орж ирэхийг Энэтхэг улс мэднэ. Энэ нарийвчилсан ТЭЗҮ боловсруулсан буюу техник, эдийн засгийн зөвлөгөө өгч байгаа нь ганцхан компани л байгаа юм Engineers India limited гэж. Энэ компанид манайхан саналаа тавина. Үнийг нь бууруулаад өгөөч яана, ийнэ, маш хурдтай шийдвэрлэнэ. Шийдвэрлэхдээ өм цөм буулгана.

Жишээ нь би түрүүн нөгөө эргэн төлөлтийг жилийн 13 сая доллароор төлнө гэж байгаа шүү дээ? 68 сая доллароор төлөх байсныг манайхыг гуйнгуут л 13 сая доллар болгож байгаа байхгүй юу. Үгүй, энэ чинь ямар тооцоолол байгаа юм бэ? Энэ дотор асар их мөнгөний наашаа цаашаа ийм луйвар явагдаж байна гэж би бодож байгаа. Энийг бид нар 20 жил төлнө. Сангийн сайд эртээд орж ирээд л 10 жил төлнө гэж байна лээ. Үйлдвэр худалдааны, Хүнд үйлдвэрийн сайд орж ирээд л 25 жил төлнө гэж. Мэдэхгүй байхгүй юу.

Энэ Монгол Улсын, би Монгол Улсын Их Хурлын гишүүн гэрээг Англи хэл дээр явуулж байгаа юм. Монгол хэл дээр байгаа юу? Гэрээ чинь, ерөнхий гэрээ? Тэгээд яагаад явуулаагүй юм?

Тэгээд манай энэ газрын тосны үйлдвэрийнхэн болохоор ажил хариуцчихсан энэ үйлдвэрээ л барихын төлөө зүтгээд байгаа юм. Бид нар ойлгож байна. Би ч гэсэн газрын тосны үйлдвэр барих шийдвэр гарахад хамгийн түрүүнд Алтанцэцэг даргыг томилогдсоны дараа очиж уулзаж байсан. Би энэ талаар нэвтрүүлэг хийж байсан. Энэ Монгол Улсад стратегийн маш чухал ач холбогдолтой. Тэр хэн дарга бас л худлаа ярьж байгаа байхгүй юу. 5 номерын юун дээр та чинь хэн билээ? 14 компани дээр бид нар талбай зарласан шүү дээ 18 оноос хойшоо. Компани ирээгүй байхгүй юу. Хайгуулынх. Та хийж байгаа гэж ярьж байгаа байхгүй юу. Тэр хийгдээгүй удсан шүү дээ. Бид нар Петрочайна Дачин Тамсаг-аас өнөөдөр бүтээгдэхүүн хуваагаа...хамгийн эхнийхээр эрэлт, нийлүүлэлтийг авна гээд байгаа. 3.6 их наядын татварын.../минут дуусав./

С.Ганбаатар: Нэмэлт хугацаа өгье.

Л.Мөнхбаясгалан: Зөрчилтэй компани. 320 тэрбумын акт тавьчихаад бид нар өнөөдөр авч чадахгүй манай татварын маргаан таслах зөвлөл энийг нь хүчингүй болгочихдог байхгүй юу. Тэгэхээр энэ яг Оюу толгойн гэрээний араас явж байгаа 5-7 их наядад тооцогдож хийгдэх үйлдвэр шүү. Бид нарт өнөөдөр түүхий эд нь баталгаагүй байгаа. Тэгэхээр бид нар энийг гэрээнд өөрчлөлт оруулах тал руу явуулмаар санагдаад байгаа юм надаа.

Тийм учраас Монгол Улсын эрхэм гишүүд та бүгдээс юу хүсэж байна вэ гэхээр ажлын хэсэг байгуулж өгөх саналыг маань дэмжиж өгөөч. Энийг нухацтай шийдвэрлэе, маш олон экспертүүдийг оруулъя. Дээрээс нь тэр Энэтхэгийн Элчин сайдын яам, Энэтхэгийн тэр зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа, нарийвчилсан ТЭЗҮ хийж байгаа тэр

компаниудыг бүгдийг нь татан оруулж асуудлыг нягтлах ёстой. Ийм саналтай байна. Миний энэ саналыг дэмжиж өгөөч гэж хүсье.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн асуулт асуугаад, үг хэллээ.

Тэгээд ажлын хэсэг байгуулна гэхлээр л мөнгө мэдэж байгаа улсууд зүгээр царай нь хувьс хийгээд л явчихвал битгий уурлаарай. Та нартаа тусалж, та нарыгаа дэмжиж, хайрлах гэж байгаа зүйл шүү. Энэ дээр газрын тосны асуудал амжилттай сайн болоод, Монголчууд өөрсдийн гэсэн нефттэй, газрын тостой бол та нарын минь л ач буян.

Энэ асуудал Оюу толгой шиг бүүр түүнээс 7долоон дор аюултай байдал руу олон их наядыг зарчхаад дараа нь Монголчууд хоосон гуяа ганзагалбал хянаагүй, ард иргэдийг төлөөлөөд энэ цалин аваад сууж байгаа бид өнөөдөр энэ асуудлыг зөв чигт нь оруулах үүргээ биелүүлээгүй гэдэг асуудал үүсдэг.

Ингээд Мөнхбаясгалан гишүүний гаргасан саналын дагуу ажлын хэсэг байгуулах болно.

Ажлын хэсгийн бэлтгэл ажлыг ирэх долоо хоногт хангаж, мэдээллүүдийг аван. Дараагийн хурлаар энэ асуудлыг шийдэх болно. Ингээд газрын тосны асуудал хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн компани, албан тушаалтнуудыг оруулъя. Ингээд, болно шууд тэр манай ажлын албаныхан дээр авна шүү.

Би чинь энийг асар их дэмждэг. Тэгсэн хувьс хувьс хийгээд л байх юм. Одоо энэ дээр ёстой чанга чанга хянаана шүү. Хариуцлагаа дараа нь бид үүргэнэ шүү. Би бүүр маш их дэмждэг байхгүй юу. Ёстой энэ дээр бид дараа нь хар толгойгоороо хариуцлагаа үүрнэ шүү дээ. Дараа нь хянаагүй гэдгээр.

Тэгээд л алдагдалтай. Өнөөдөр байна шүү дээ 600 сая доллароор үйлдвэр бариад, түлхүүр хүлээлгэж өгье гээд тэр Нинжсин гуайн тэр Дарханы нефтийн үйлдвэр олон жил ярьсан шүү дээ. Тэгэхэд чинь тэгээд энийг дараа нь ажлын хэсэг дээр ярина.

17.35 цаг

“Тавантолгой түли компани”-ийн үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсоно.

Та бүхэнд албан тушаалтнуудыг танилцуулъя. Түвшинжаргал “Эрдэнэс Тавантолгой” компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал. Түвшинжаргал ирсэн байна. Гантулга “Эрдэнэс Тавантолгой” компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Гантулга? Тийм өө тийм шүү. Ойлгосон. Анх-Од “Эрдэнэс Тавантолгой” компанийн Стратеги төлөвлөлтийн, төслийн газрын дарга байна уу Анход? Байна. Лхагвасүрэн “Тавантолгой түли” компанийн гүйцэтгэх захирал? Ирсэн байна. Алтансүх “Тавантолгой түли” компанийн ерөнхий инженер? Ирсэн байна. Өлзийбат “Тавантолгой компанийн” Ерөнхий технологич? Ирсэн байна. Батзориг “Тавантолгой түли” компанийн санхүүгийн газрын дарга? Ирсэн байна. Даваадалай Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч? Даваадалай даргыг дуудаарай.

Ингээд мэдээллээ та бүхэн асуултын дагуу мэдээллээ хийнэ.

1 дүгээр микрофоныг өгөх юм уу? Аль хэн нь ярих юм? 2 дугаар микрофоныг нээе.

Ц.Алтансүх: Сайн байцаана уу? Та бүгдэд энэ оройн мэнд хүргэе. “Тавантолгой түли” компанийн Ерөнхий инженер Алтансүх.

“Тавантолгой түли” компани, “Тавантолгой түли” компанийн үйлдвэр, техник технологи болоод санхүүгийн мэдээллийг танилцуулъя.

“Тавантолгой түли” компани ер нь бол бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд 5 шат дамжлага дамжиж бүтээгдэхүүн шахмал түлшийг үйлдвэрлэж байгаа.

Нэгдүгээрт, бутлах, холих, хэвлэх, хатаах, савлах гэсэн дамжлагаар дамжиж бүтээгдэхүүн үйлдвэрлэл явж байгаа.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд 95-96 хувь нь Энержи Ресурс-ийн угаах үйлдвэрийн дундын бүтээгдэхүүн буюу мидлинг 4-5 хувь нь барьцалдуулагч, холбогч материал ашиглан 2 төрлийн хольцтойгоор шахмал түлшийг үйлдвэрлэж хэрэглэгчид жилд дунджаар 500, өвлийн ачаалалд 9 сарын 15-наас 5 сарын 15 хүртэл 540 орчим мянган тонн шахмал түли үйлдвэрлэн хэрэглэгчид нийлүүлж байгаа.

Бүтээгдэхүүний стандарт, чанар шаардлагын хувьд MNS 5679:2022 стандартыг мөрдөж ажиллаж байна. Ер нь бид нар мөрдөж байгаа стандартын хяналтыг Ашигт малтмал, газрын тосны лаборатори, Хими, химийн технологийн хүрээлэнгийн лаборатори, хувийн “Эс Жи Эс” олон улсын итгэмжлэгдсэн лаборатори зэрэг лабораториудад, хөндлөнгийн лабораториудад, мөн өөрийн үйлдвэрийн 23 онд ашиглалтад орсон лабораториор жилдээ өнгөрсөн жилийн хувьд нийтдээ 3760 орчим дээжид хяналт шинжилгээ хийж, MNS 5679:2022 стандартад хэрэгжүүлж ажиллаж байна.

Бид нар техник технологийн хувьд бол түүхий эдээ цаашидаа бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ, бүтээгдэхүүнээ хэрхэн сайжруулах талаар ер нь Эрчим хүчний яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Монгол Улсын ШУТИС, МУИС-ийн багш нартай хамтарсан судалгаануудыг хийж байгаа. Эндээс гол 2 үр дүнд хүрч байгаа 2 судалгаа, туршилтын ажил бол нэгдүгээрт ер нь түүхий эдээ, мидлингээ хагас коксоор солих туршилт энэ Эрчим хүчний яамнаас ахалсан ажлын хэсэг гараад.../минут дуусав./

С.Ганбаатар: Асуулга, сонсголыг 5 минут дотор багтааж хэлэх ёстой.

Одоо асуулт асуух гишүүд асуултаа асууна. Нэрээ өгнө үү. Асуудалд харин тодорхой хариулаарай. Нэрсээ өгсөн үү? Ингээд Золжаргал гишүүнээр тасаллаа.

Жангабыл гишүүн асуулт асууна.

Х.Жангабыл: Энэ “Эрдэнэс Тавантолгой” компани Тавантолгой түлшний 51 хувийг эзэмшдэг гээд сонсож байсан. Сая бол Улсын Их Хурлын тогтоолоор нийслэл рүү шилжүүлсэн, шилжүүлчихсэн байгаа. Энэ Тавантолгой түли асар их яригдсан алдагдалтай ажилладаг. Өнөөдрийн байдлаар 1.2 их наяд төгрөгийн өр, зээлтэй гээд. 8 сарын 15-ны өдөр ээлжит бус чуулган эхлэхэд яригдсан. Өчигдөр юм уу, уржигдар, өнгөрсөн долоо хоногт эцсийн найруулгаар нийслэл рүү шилжүүлээ. Энэ өр, төлбөрийг

аль компани авчхаж байгаа юм бэ? нийслэл рүү шилжсэн үү? Аль эсвэл Эрдэнэс Тавантолгойд үлдсэн юм уу? Энгийг яаж барагдуулах юм? Нэг.

Ер нь “Эрдэнэс Тавантолгой” компанийн 26.4 хувийг ард иргэдийн хувьцаа, 72 хувьцаа шүү дээ. Би ч гэсэн 1072 хувьцааны эзэн. Хууль ёсны хувьцаа эзэмшигч. Бид нараас асуухгүйгээр ингээд янз бүрийн мөнгө төгрөг наана цаана болгоод байдаг “Эрдэнэс Тавантолгой”, шийдвэр гаргаад байдаг. Тэгэхээр энэ дээр бас хариулт авмаар байна.

Өвөлжилт, өвөлжилтийн бэлтгэл ямар байна? Өвөл хаяанд ирлээ. Үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа ямар байна? Эзэнгүй болчихоод байгаа юм биш үү? Энэ утаанаас салахын тулд түлж байгаа энэ нүүрс маань чанартай байх ёстой. Тэгэхээр энэ чанарын хувьд ямар байна? Нөөц бүрдүүлсэн юм уу? Ер нь менежмент нь яаж явж байна Тавантолгой түлшний? Нийслэл рүү очихоор тэгээд менежментээ сайжруулаад, ядах нь балансаа барьдаг ийм компани болгож явуулах хэрэгтэй байна. Эд нар дээр тодорхой хариулт авмаар байна.

С.Ганбаатар: Мааш тодорхой асуултууд асуулаа. Тодорхой хариулна уу. Хэн хариулах юм? 2 номерын микрофоныг нээж өгье.

Ц.Алтансүх: “Эрдэнэс Тавантолгой” компанид байгуулагдсан цагаасаа Эрдэнэс Тавантолгойгоос санхүүжиж ирж байгаа. Энэ 24 оны хагас жилийн байдлаар 1 Гаравны, 1.25 их наядын өртэй байгаа. Энэ өрийн асуудлыг одоо нийслэл рүү шилжихэд 23 оны, 24 оны 1 сард гарсан байх нийслэл, ер нь урьдчилсан байдлаар мэдээлэл, нийслэл нөгөө “Эрдэнэс Тавантолгой” компанийн төрд ноогдох хувьцааны ноогдлоор энэ өрийг барагдуулна гэсэн мэдээлэлтэй байгаа. Яг түүнээс яг энэ өрийг барагдуулчихсан, шийдчихсэн асуудал бол байхгүй байгаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хувьд бол бид нар өнөөдрийн байдлаар 85 мянган тонн шахмал түлшний нөөцтэйн Нийслэлийн агуулахуудад эх урсгал засварын ажил 100 хувь хийгдэж дууссан. Түүхий эд бараа материалын нөөц 2-3 сарын нөөцтэй. Өвөлжилт бол бэлэн байгаа.

Ер нь бид нарын үйлдвэрлэлд хэрэглэж байгаа мидлинг буюу үндсэн түүхий эд маань И Ар-аас авч байгаа, ер нь тогтмол. Энэ өнөөгийн нөхцөл байдлаар энэ яг энэ мидлингээ хэрэглэж үйлдвэрлэл явуулж байгаа үед бүүр тийм эрс өөрчлөлт гарахгүй. Яг энэ өмнөх жилүүдтэй ижил түвшинд байна л гэж бодож байгаа, харж байгаа.

С.Ганбаатар: Хариултуудыг ер нь бүүр их тодорхой өгнө шүү. Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Та бүхний энэ танилцуулсан, явуулсан материалуудтай танилцлаа. Энэ дээр одоогийн нөхцөл байдлын талаар л ямар байгаа гэдгийг л танилцуулсан байна. Танай компанийн стратеги төлөвлөгөөг хармаар байна л даа. Одоогоос 3-5 жилийн ч юм уу. Ер нь хувийн компаниуд бүгд тийм байгаа шүү дээ. Хөрөнгийн өгөөж хэд байх юм бэ? Ямар хэмжээ, үнээр борлуулаад явах юм бол ашигтай ажиллах боломжтой юм уу? Эсвэл одоогийн энэ татаасаа өгч байгаа 400 тэрбумын алдагдалтай байгаа шүү дээ тээ? 1 тонн түли дээр 300 мянга гаруй төгрөгийн татаас олгож байгаа. Тэгээд энэ “Тавантолгой түли” компанийн гол зорилго бол Монгол Улс утаагүй болъё, Улаанбаатар хот утаагүй болъё л гэсэн гол зорилготой. Энэ их татаасыг өгөөд утаа нь хэдэн хувиар буураад байгаа юм бэ? Улаанбаатар хотод та нар хэдэн цэг дээр хэмжилт хийгээд, эсвэл хийж байгаа байгууллагаас нь мэдээлэл аваад, энэ их

татаасыг татвар төлөгчдийн мөнгөөр олгоод ямар үр дүнд хүрч байгаа юм бэ гэдгийгээ бизнесийн төлөвлөгөө дээрээ 3-5 жилийн төлөвлөгөө ч юм уу боловсруулаад харуулах хэрэгтэй байгаа юм. Энэ зөвхөн танай компани дээр хэлж байгаа юм биш.

Ер нь манай ТӨК-уд бүгдээрээ бизнес төлөвлөгөө байхгүй, хөрөнгийн өгөөж буюу *return of equity* ч юм уу ямар ч тийм том гарч ирэхгүй байгаа юм. Та хэд маань манлайлаад үнэхээр ингээд утааг бууруулахаар зорьж байгаа бараг цорын ганц ТӨК байгаа шүү дээ. Тэгэхлээр ямар үр дүнд хэдий хугацаанд хүрэх юм бэ гэдэг энийгээ зөвхөн Улаанбаатар дангаараа биш аймгийн төвүүд, Дархан, Эрдэнэт хот дээр ч гэсэн бас тооцож үзмээр байгаа юм. Зөвхөн Улаанбаатар хотдоо ингээд 200 гаруй мянган айл өрхөд ингээд 2.5 сая тонн түши борлуулаад явах юм уу? Эсвэл цаашидаа энэ Улаанбаатарт байгаа үйлдвэрүүд байгаа шүү дээ түүхий нүүрс гээд шатааж байгаа тэндээс ч гэсэн агаарын бохирдлын тодорхой хувь нь гарч байгаа. Уг нь энэ үйлдвэрүүдийг ч гэсэн адилхан сайжруулсан түшигээ түлдэг болгоно гэсэн стандарт, цаашидаа энэ аймгийн төвүүд, Дархан, Эрдэнэт ч гэсэн адилхан энэ сайжруулсан түшиг, утаагүй зуух гэсэн ийшээ үндэстнээрээ шилжих ёстой гэсэн тийм стратеги төлөвлөгөөг та хэд маань боловсруулаад хамгийн их асуудлыг нь мэдэж байгаа хүмүүс байгаа болохлоор тэрийг нь үзүүлмээр байгаа юм.

Тэгээд агаарын бохирдлоо хэмжих дээрээ бас адилхан. *PM2.5*, *PM10* гэсэн хоёрхон л үзүүлэлт байгаад байна л даа. Хүхэр, азот энэ тэр гээд тэд нарыг бас хэмжээд хэдий хэмжээнд бууруулж байгаа юм бэ гээд хүмүүс хэлээд байгаа шүү дээ. Сайжруулсан түшиг түлэхлээр өмхий үнэртдэг болчихлоо гээд. Тэр нь хаанаа юм бэ гэдгийг нь бас тайлбарлавал зүгээр байна.

Дараагийн асуудал нь болохлоор та хэд маань ингээд утаанаас болоод хүүхдүүд, гэр бүлүүд ингээд угаартаад гэр бүлээрээ нас барж байгаа асуудлууд байгаа шүү дээ тээ? Тэр дээр нь юу гэдэг юм түлэх арга барил нь болохгүй байгаа юм уу? Явал зөв түлэх юм бэ? Энэ чинь хүний амь яригдаж байгаа болохлоор дэлхийн жишгээр та хэд маань зөв зохистой галлагааны гарын авлага ч байдаг юм уу, борлуулдаг цэг дээрээ 600 гаруй борлуулдаг цэг байна шүү дээ тэр дээрээ бас тийм зүйлүүдээ ингээд сургалт зохион байгуулдаг ч юм уу тийм байдлаар ийм про актив буюу ингээд илүү идэвхтэй байдлаар энэ агаарын бохирдлыг бууруулах тал дээр ийм төлөвлөгөө гаргаад, арга хэмжээ аваад яваач. гэсэн тэрийгээ хийх үү гэсэн тийм асуулт байна.

С.Ганбаатар: 5 дугаар микрофон дээр. Нэр усаа бас хэлээд яваарай. Монголын ард түмэн бас харж байгаа. Баярлалаа.

А.Батзориг: Сайн байцаана уу? “Тавантолгой түшиг” компанийн Санхүү, эдийн засгийн газрын дарга Батзориг.

Гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн 6 жилд бид нар ямар үр дүнд хүрчхэв гэхээр одоо утааны гол үзүүлэлт болох *PM2.5*, *PM10* хоёрын үзүүлэлт байдаг. Энэ нь бол хоёулаа нэг нь 43 хувь, нэг нь 50 хувиар буурсан ийм үзүүлэлт байдаг. Энийг бол Цаг уурын орчин шинжилгээний газраас ингээд байнга мэдээлээд явж байдаг. Тэгэхээр энэ бол нэг үр дүн.

Хоёр дахь үр дүн юу юм бэ гэхээр хэрэглэгчид иргэдэд зах зээлийн үнээс хямд үнээр шахмал түшиг борлуулж байгаа ийм хоёр үндсэн үр дүнд хүрчхээд байгаа юм.

Бид бүхэн энэ 6 жил үйл ажиллагаа явуулахдаа 1.2 их наядын санхүүжилтийг Эрдэнэс Тавантолгойгоос авч ажилласан байгаа. Энийгээ задлаад үзэхэд 468 тэрбум

төгрөгийн хөрөнгийг бий болгочихсон байна. Энэний 1 260 орчим нь үндсэн хөрөнгө, барилга байгууламж, тоног төхөөрөмж байж байгаа. Үлдсэн нь эргэлтийн хөрөнгө байж байгаа. Нийтдээ давхардсан тоогоор 18 мянга орчим ажлын байрыг 6 жилийн хугацаанд байлгасан. Энд бол нийтдээ 314 тэрбум төгрөгийн цалингийн зардлыг гаргаад явж байна. Мөн бид бүхэн мидлингээ Энержи Ресурс буюу Тавантолгойн ордоос үндсэн түүхий эдээ тээвэрлэж авчирч ирж байгаа. Хэчнээн бид нар Энержи-тэй үнэгүй худалдаж авч байгаа боловч авто тээврээр 22 оны 12 сар хүртэл авто тээврээр тээвэрлэж байсан. Тэрнээс хойш 22 оны 12 сараас төмөр зам руу 100 хувь шилжээд явчихсан.

Авто тээврээр тээвэрлэж байхад трассын хэмжээ нийтдээ 650 км-ийг шороон авто тээврээр зөөж ирж байсан. Харин төмөр замаар трассын километр маань яг мянган км-ээр бид нар тээвэрлэж байгаа. Энэний өртөг, зардал тэгээд нийтдээ 250 тэрбум төгрөгийн мидлингийг тээвэрлээд ирчихсэн байна гэх мэт ийм үндсэн түүхий эд, материал ийм гол гол зардлууддаа, энэ зардлуудыг гаргасан. Бид нарын яг өнөөдрийн өртөг маань 500 мянга орчим байгаа. Тэгэхээр бид нар 150-аар борлуулж байхаар дунджаар 350 төгрөгийн, мянган төгрөгийн алдагдлыг хүлээсээр явж байгаа.

Ер нь стратеги төлөвлөгөө бас бид нар боловсруулж байгаа. Ер нь дунд хугацааны төлөвлөгөө эхний 5 жил манайх яг энэ мидлингээ ашиглаж үйлдвэрлэлээ явуулна агаарын бохирдлыг тодорхой хэмжээгээр 50 хувиа бууруулна. Энэ зорилтдоо хүрчихсэн явж байна. Дараагийн зорилт.../минут дуусав./

С.Ганбаатар: Ганзориг даргаа энэ гүйцээгээд хариулчихъя. Товчхон хариулчхаарай. 5 номерын микрофоныг нээе.

А.Батзориг: Тийм хагас кокс байгаа. Бас бусад судалгааны ажлуудыг бид нар бас хийсэн хийчихсэн байгаа. Энэ Эрчим хүчний яамтай хамтраад ер нь хагас кокс руу шилжвэл өнөөгийн агаарын бохирдлыг дахиад 50 хувь бууруулах бололцоотой гэсэн судалгаа тооцоо нь гарсан байгаа.

Түрүүн бас гишүүн асуусан. Одоо энэ агаарын бохирдол яг өнөөгийн нөхцөлд 2 асуудал бас их нөлөөлж байна. Энэ бол түүхий нүүрс 140 мянга, манай үйлдвэрлэл болохоор 540 мянгыг жилдээ үйлдвэрлэж байна. Түүхий нүүрс 140 мянга буюу Багануурын нүүрс 140 мянга бас түлэгдэж байгаа. Нэг.

Хоёр дахь асуудал нь болохоор нийслэлийн хэмжээнд 8 мянга орчим айл өрх манай түлшийг худалдан авах чадваргүй байгаа. Энэтэй холбоотой 8 мянга орчим айл ямар түлш түлэгдэж байгаа нь бас тодорхойгүй байгаа. Тэгэхээр энэ бол агаарын бохирдол бас нэлээн нөлөөлж.../минут дуусав./

С.Ганбаатар: Тодруулъя, тодруулаад та сая гүйцээж хариулах юмнуудаа сая тодруулахдаа хэлчээрэй.

Ингээд Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Стратеги төлөвлөгөө боловсруулж байгаа гэдгийг ойлголоо. Дараагийн удаагийн сонсгол дээр тэрийг танилцуулахыг хүсэж байна. Тэгээд зөвхөн Улаанбаатараа ингээд явах юм уу, эсвэл бусад аймгийн төвүүд чинь бас бүгдээрээ агаарын бохирдол болчихсон байгаа шүү дээ. Тэд нарыг нь бас оролцуулаарай Дархан Эрдэнэтийгээ бас. Тээврийн зардал энэ тэр нь илүү өндөр үнэ гараад татаасны үнэ бас нэмэгдэх гэсэн тийм зүйлүүд гарч ирнэ байх. Тэгээд яаж явах юм бэ гэдэг зүйлийг нь гаргамаар байна.

Хоёр зүйл та сая гээчихлээ. Хүхэр, азотыг хэмждэг болох юм уу? Зөвхөн PM2.5-ыг нь PM10-аа хэмжээд байхлаар энэ чинь үнэргүй болохлоор өмхий үнэртээд байна гээд байгаа чинь хүхэр, азот дээр л байгаад байгаа шүү дээ. Энийг яах юм бэ гэдэг нэг зүйл.

Нэг дахь нь сая хэлсэн айл өрхүүд угаартаж нас бараад байгаа шүү дээ. Энэ яг юундаа байгаа юм бэ? Буруу галлагаа юм уу? Эсвэл энэ барьцалдуулагчийн эд ч юм уу тэрэндээ байгаа юм уу? Буруу галлагаандаа байгаа юм бол тэрийг нь яаж зөв галлагаанд иилжүүлэх. Тэрийг бас та бүхэн ингээд бүтээгдэхүүн нийлүүлж, зах зээлд нийлүүлж байгаа комп.../минут дуусав./

С.Ганбаатар: *Лувсанжамц гишүүн маш тодорхой 3 асуулт асуулаа. 6 номер хариулна. Дараа нь 2 номер хариулах юм уу? 6 номер хариулах юм байна. 6 номер.*

Д.Өлзийбат: *Гишүүний асуултад хариулъя. “Тавантолгой түли компанийн” Ерөнхий технологич Өлзийбат байна.*

Бид нар тэр мэдээлэл дээр зөвхөн PM2.5 болон PM10 гэдгийг өгсөн байх. Ер нь Нокс окс-ыг бас тодорхойлж байгаа. Энэ нүүрснээс, шахмал түлиний шаталтаас ялгарч байгаа хорт хийн агууламжийг Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газрын лаборатори тодорхойлдог. Энэ шинжилгээг бид нар дээр байнгын тогтмол хийж байгаа. Нокс оксын хувьд стандарт одоо яг үндсэн төлж байгаа түлинээс бол 10-15 хувь орчим буурсан үзүүлэлттэй байгаа.

Ер нь Засгийн газраас бид нарыг хүхэрлэг хийг бууруулах арга хэмжээг шат дараатай ав гэдэг арга хэмжээний дагуу 22 оноос эхлээд манай компани бас өөрсдийн инженерүүдийн гаргаж авсан 7 метрийн орцтой барьцалдуулагч гэдгийг шахмал түлиндээ ашиглаж байгаа. Энэ барьцалдуулагч маань шаталтаас ялгарч байгаа хүхэрлэг хийгээс 20-30 хувь бууруулж байгаа гэсэн судалгаа байгаа. Энэ судалгааг бол Цаг уур, орчны шинжилгээний хүрээлэн болон энэ Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын лабораторийн шинжилгээний дүнгээс харагдаж байгаа.

Тэгэхээр зэрэг энэ бид нар бол агаарт дэгдэж байгаа Нокс оксыг дэмжээд, тодорхойлоод явж байгаа гэж ойлгож болно.

Дараагийн асуудал нь бид нар угаарталтын эсрэг дээр байгаа, манай дээр Хэрэглэгчдэд үйлчлэх төв гээд байж байгаад нийслэл рүү иилжсэн. Энэ төвөөрөө дамжуулаад нийслэлийн гэр хорооллын иргэдэд галлагааны зааварчилгааг бүрэн бүтэн, байнгын өгч байгаа. Мөн бид нар бас хэвлэл мэдээллийнхээ хэрэгсэлтэй хамтарч явж байгаа. Манай хэвлэл мэдээлэл бүх хэвлэл мэдээллийн хэрэгслээр угаарын эсрэг арга хэмжээ, яаж зөв галлах уу энэ бүх мэдээлүүдийг мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулаад явж байгаа.

С.Ганбаатар: *Зарим зүйлүүдийг асуусан зүйл хариулсангүй тэрийгээ тодруулж Лувсанжамц гишүүнд бас бичгээр өгнө. Тэгээд шаардлагатай бол дахиж хариулах ёстой шүү.*

Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: *Энэ утаанаас салахын тулд авч байгаа нь завсрын арга хэмжээ гэж ойлгож байгаа. Тэгэхээр утаанаас салах цорын ганц гэж хэлж болох арга бол орон сууцжуулах л байгаа шүү дээ. Эсвэл гэр хорооллыг дэд бүтцэд бүрэн холбох.*

Тэгэхээр энэ шилжилтийн үеийн энэ арга хэмжээг бас хариуцлагатай ажиллах талаар та бүхнийг хичээж ажиллаж байгаа гэж миний хувьд ойлгож байгаа.

Гэхдээ энэ ийм зорилтот арга хэмжээ учраас бусад ТӨК-тай адил ингээд ашигтай ажиллахад жоохон хүндрэлтэй байгаа байх л даа. Гэхдээ бас та бүхэнд бодох ёстой зүйлүүд бас нэлээд байгаа. Энд бол нэгдүгээрт, мэдээж алдагдлыг хамгийн бага минимум мөн түвшинд л хүргэх.

Тийм учраас энэ дээр урсгал зардал бусад зардлыг аль болох хэмнэх, бууруулах. Тэгж байж энэ чинь тодорхой үр дүн тоогоор бас харагдана. Хоёрт энэ технологийн шинэчлэлийг байнга хийх ёстой. Тэгээд энэ хүрээндээ яг үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа инженер, техникийн ажилтнууд, бусад эрдэм шинжилгээний байгууллага, лабораториуд, цаг уур, орчны шинжилгээний байгууллага гээд энэ байгууллагуудтай хамтарч байнгын ийм шинэчлэн сайжруулалт хийж байх ёстой гэж үзэж байгаа юм. Яах вэ, Засгийн газар бол өдөр болгон анхаарч чадахгүй шүү дээ. Улсын Их Хурал өдөр болгон анхаарч чадахгүй. Тийм учраас та бүхэн маань энэ тал дээр тийм дунд хугацаандаа, урт хугацаандаа их анхаарч ажиллахгүй бол энэ их том асуудал алсдаа бас үүснэ шүү. Угаарталттай холбоотой, утааны хэмжээ, хүхэрлэг агууламж, хортой бодистой холбоотой, тэгээд энэ дээр их сайн, онцгой анхаарч явах ёстой гэж үзэж байгаа.

Тэгээд бусад улс орнуудад ийм шилжилтийн үед ийм түлш сайжруулж ямар арга хэмжээ авдаг байсан юм? Энэ талаар ер нь судалсан судалгаа байдаг уу? Харьцуулсан тийм зүйл танай компанийн хувьд байдаг уу? Нэгдүгээр асуулт.

Хоёр дахь нь ер нь цаашидын зорилтоо юу гэж үзэж байгаа юм бэ? Энэ үйлдвэр ингээд ер нь байгаад байна гэж үздэг юм уу? Яг нөгөө амьдрал дээр ингээд хариуцаж ажиллаж байгаа хүмүүсийн хувьд өөр шийдлийн талаар та бүхэнд ер нь бодсон зүйл толгой компанидаа, Засгийн газар санал болгож байгаад ийм зүйл байдаг уу? Тэгвэл энийг нь дэмжихгүй байгаа тохиолдол байна уу? Яг Улсын Их Хурлын Байнгын хорооны түвшинд, Улсын Их Хурлын гишүүдийн хувьд бид ер нь юунд анхаарах ёстой вэ? Энэ зүйл дээр.

Тэгээд энэ дээр яг бэрхшээлийг дундуур нь явж байгаа хүмүүсийн хувьд ч та бүхнийг би хамгийн сайн ойлгож байгаа гэж бодож байгаа. Ер нь яг амьдрал дээр тулгамдаж байгаа асуудлуудыг илүү гаргаж ирж, амьдралын гүнд байгаа зүйлийг бодлого болгож гаргах нь л хамгийн чухал. Тэгвэл бидний өнөөдрийн энэ та бүхний танилцуулгыг сонссоны үр дүн гарна гэж бодож байна.

Тэгэхээр тодорхой энэ зүйлүүд дээр та бүхнийг бас саналаа хэлээч, Байнгын хороо энэ дээр сонсох гэж сонсоогүй, тодорхой бас сайжруулалтыг.../минут дуусав./

С.Ганбаатар: *Гишүүд бол ард иргэдийг төлөөлж асууж байгаа. Энэ дээр бас шийдэл гарц гаргалгаатай асуудалд бас хандана шүү.*

Ингээд асуултад тодруулж хариулъя. 1 номерын микрофоныг нээж өгье. Өөрийнхөө нэрийг хэлээд, албан тушаалаа хэлээрэй.

Ц.Лхагвасүрэн: *Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Лхагвасүрэн “Тавантолгой түлш” компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч.*

Шахмал түлштэй холбогдолтой асуудлаар манай үйлдвэрийн гаргаж байгаа бүтээгдэхүүнтэй холбогдолтой асуудлаар их олон л хэл ам дагалддаг л даа. Сая Бадамсүрэн гишүүний асуусан асуултад хариулъя.

Компанийн хувьд аль болохоор алдагдлаа бууруулах, үр ашигтай ажиллах, бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх, алдагдлыг багасгах энэ тал дээр нэлээдгүй арга хэмжээ авч, ялангуяа энэ 24-25 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах энэ ажлын хүрээнд шийдвэрлэж ажилласан. Өнгөрсөн хугацаанд бид нар нийтдээ компанийн хэмжээнд 20 шугамаар үйлдвэрлэл явуулж нийслэлийн энэ 200 мянган хэрэглэгчдэд 500 мянган тонн бүтээгдэхүүн хүргэдэг байсан. Ингээд технологийн шугамаа хүчин чадлыг нь сайжруулж нэмэгдүүлснээр энэ жил бид нар 5 шугамаар үйлдвэрлэлээ явуулж байгаа юм. 5 шугамаар. Төвийн үйлдвэр, зүүн бүсийн үйлдвэр дээр нийтдээ 5 шугамаар. Ингэснээр зардал багасах, мөн ажиллах хүчний хүний нөөцийн хувьд ч гэсэн бас багасгах ийм боломжит нөхцөл бий болсон.

Дээр нь тэр өвөлжилтийн бэлтгэл ажлын хувьд 24-25 оны өвөлжилтийн бэлтгэл ажил “Тавантолгой түли” компанийн хувьд бүрэн хангагдсан. Өнөөдөр 230 мянган тонн мидлинг, 85 мянган тонн бүтээгдэхүүн бэлэн бүтээгдэхүүн байна. Хоногтоо бид нар энэ үйлдвэрлэлийн 5 шугамаар 1700-2500 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хэрэглэгчдэд мөн хоногт 2500 орчим дунджаар бүтээгдэхүүн нийлүүлж байгаа юм. Тэгэхлээр энэ нийлүүлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ тооцоод үзэхлээр бид энэ өвлийг ямар нэгэн хүндрэл, бэрхшээлгүйгээр энд давах бүрэн боломж бүрдсэн.

Судалгаа харьцуулалтын хувьд мэдээж хамгийн том чухал зүйлийн маань нэг энэ. Азийн болоод Европын, хөрш зэргэлдээ Хятад, Орос зэрэг улс орнуудад энэ Солонгос гэдэг юм уу, Япон, Солонгос гэдэг юм уу энэ улсуудад хэрхэн энэ шахмал түлшийг үйлдвэрлэж ирсэн, дараагийн энэ хөгжил нь, хөгжүүлэлт нь яаж явсан талаар бүрэн судалгаа хийгдсэн, харьцуулалт хийгдсэн ийм судалгаанууд бол бүрэн байгаа.

Ер нь дараагийн шатны, дунд хугацааны сайжруулалт ялт байхгүй энэ хагас коксын бүтээгдэхүүн юм гэдэг ийм байр суурьтай байгаа. Засгийн газар, Улсын Их Хурал болоод бусад энэ холбогдох чиг үүргийн яам, Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэс Монгол энэ компаниудын зүгээс Тавантолгой түли компанийн үйл ажиллагаа бол/минут дуусав./

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн тодруулъя. Тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Тийм, тэгэхээр бүрэн судалгаа бусад орнуудтай харьцуулсан байгаа гэж байна. Тэгэхээр миний гол асуугаад байгаа зүйл нь хоёр л зүйл дээр асууж байгаа байхгүй юу.

Нэгдүгээрт, энэ туршилагаа яаж нэвтрүүлж байгаа юм бэ?

Хоёрт нь цаашид энэ аль болох алдагдлыг бууруулж, аль болох дараагийн түвшинд хөгжүүлэлт хийж энэ утаа хамгийн бага гаргадаг, болбол гаргадаггүй байх энэ чиглэлээр юу хийвэл төр засгаас анхаарах юм, төр анхаарах юм? Төр гэдэг нь Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Байнгын хороо шүү дээ. Тэгээд бид нар чинь бодлого гаргаж, шийдэл гаргаж, дэмжлэг үзүүлэх гээд сонсож байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чиглэлээр тодорхой яг энд л хариулах хэрэгтэй. Яг тодорхой.

С.Ганбаатар: 2 номерын микрофонд. Үүссэн нөхцөл байдал дээр ямар гарц, гаргалгаа та нарт бас байгаа вэ гэж асууж байна.

Ц.Алтансүх: Ер нь энэ сая гүйцэтгэх захирал хэлсэн, бас дээр нь ер нь энэ олон улсын туршилагыг харахад түүхий нүүрснээс хагас кокс руу шилжиж л энэ дунд хугацаандаа энэ утааны асуудлыг шийдсэн юм билээ томоохон хотууд. Агаарын бохирдол өндөртэй том хотууд.

Цаашидаа бол, ер нь яндангүй болж байж л утаагүй болно. Түүнээс ямарваа нэгэн түлш түлж байгаа л тохиолдолд тодорхой хэмжээнд утаа байсаар байх болно. Тэгээд цаашидаа урт хугацаандаа ер нь бүрэн орон сууцжуулж байж эрчим хүчээр, дэд бүтцээр гэр хорооллоо бүрэн хангаж байж л энэ асуудал ер нь 100 хувь шийдэгдэнэ гэж харж байгаа.

Энэ манай компанийн хувьд энэ манай эрчим хүчний систем байгаа, одоогийн нөхцөл байдал харахад бол ойрын 10 жилдээ ажиллана гэж төсөөлж байгаа энэ шахмал түлшийг үйлдвэрлэж. Эндээ харин дунд хугацаандаа энэ түүхий эдээ ер нь бүрэн сольж байж л дараагийн өөрчлөлт гарч ирнэ гэж тооцоолж байгаа.

С.Ганбаатар: Хариулт үнэхээр хангалтгүй байна шүү. Бадамсүрэн гишүүнд энэ дээр бичгээр өгөөрэй. Энэ дээр. 5 номер Ганзориг захирал хариулъя.

А.Батзориг: Энэ дээр бас төр засгаас бас хавах арга хэмжээнүүд бас байна л даа. Яг өнөөдөр яг тулгаж байгаа, тулгамдаж байгаа бас асуудал би түрүүний яриан дээр хэлсэн 8 мянга орчим айлууд манай түлшийг түлэхгүйгээр юу түлж байгаа нь мэдэгдэхгүйгээр ингээд явж байна.

2019, 2020, 2022 онд бага хэмжээгээр энэ хүмүүст 3-4 долоо хоногийн нүүрсийг бол Нийслэлийн халамжийн газраас бас өгч байсан юм байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Хоёрдугаар асуудал нь болохоор нийтдээ 140 мянган тонн түүхий нүүрс түлж байна гэдэг чинь манайхтай харьцуулбал бараг 300-гаад мянган тонны нөлөөлөл энэ юунд үзүүлээд байна уу. Тэгэхээр аль аль талдаа их олон энэ агаарын бохирдлыг үүсгээд байгаа олон нөхцөл байдлыг зэрэгцээ хамтдаа ингээд шийдээд явах нь их чухал байх. Нэг, ганц түлш биш эргээд тэр асаагч ч юм уу гэх мэтийн юм руугаа бас ороод явах нь зөв байх.

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн бас нарийн, нэлээн нарийн технологийн нэлээн нарийн шийдлүүдийг бас асуусан байх. Дараагийн ээлжид бас дэлгэрэнгүй та бүхэн гишүүнд бас хариулт өгвөл их сайн байна.

Ингээд Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Энд санхүүгийн эрхэлсэн захирал байгаа юу? Хэн гэж хүн байна Батзориг уу? Энэ сая таны хэлсэн Эрдэнэс Тавантолгойгоос 1.2 их наядын хөрөнгө аваад 468 тэрбумын хөрөнгийг бий болголоо гэж та сая хэлсэн тээ? Энд 2024 оны 3 сарын 25-ны аудитын дүгнэлт байна л даа Эрдэнэс Тавантолгойд би бас хувьцаа эзэмшдэг юм. Энд сууж байгаа бараг бүх хүмүүс хувьцаа эзэмшиж байгаа байх л даа.

Тэгэхээр бидний мөнгөнөөс та нар 1.2 их наядыг аваад, тэгээд энэ утааг 50 хувиар бууруулсан гээд ярьчихав уу? Сая чанар 50 хувиар буурсан гээд? 50, дахиад 50 хувиар бууруулчихна гэж ярьж байна шүү дээ. Тэгсэн хэр нь яндан байгаа тохиолдол байна, бид нар 10 жил наслах, ер нь 10 жил ингээд сууж байх баталгаатай л гэж сая ярьж байна

шүү дээ. Яг үнэндээ утаа чинь 50 хувиар буурсан гэдгийг та нар өөрсдөө л хэлээд байгаа болохоос биш энэ Улаанбаатар хотынхон хэлэхгүй байгаа шүү. Энэ бол худлаа.

Бид нарын авсан мөнгөнөөс та нар 68 тэрбум 789 саяыг аудитын дүгнэлтээр зөрчил хийсэн байна. Энэ дээрээ хариуцлага, ямар хариуцлага үүрцгээсэн бэ? Асуултаа асуучхаад тодруулга авъя. Хэн хэн гэдэг албан тушаалтанд ямар хариуцлага үүрсэн бэ?

С.Ганбаатар: Асуултыг маш тодорхой хариулъя. Хэн хариулах вэ? 5 номер Батзориг.

А.Батзориг: Энийг манай компани бас 50 хувь бууруулсан гэдгийг хэлэхгүй байгаа. Их олон судалгаа, шинжилгээний байгууллага, дээрээс нь манай Монголын Цаг уур, орчны шинжилгээний газраас энэ үзүүлэлтүүдийг гаргаад олон нийтэд бас нээлттэй байж байгаа, ийм байгаа юм.

Нийтдээ 1.2 их наяд төгрөгийн санхүүжилтийг авсан. Түүрүүн би хэлсэн ийм ийм юманд зарцуулаад ингээд явж байна гэж байгаа юм. 2024 оны, 23 онд аудитын, үндэсний аудит манайд аудитын аудит хийсэн. Энэ дээр бол нийтдээ 13 зөрчил гаргасан, гарсан. 13 зөрчлөөс 4 нь бол зөвлөмжөөр бид нарт ажил сайжруулах үүрэг өгсөн байгаа. 9 нь болохоор албан шаардлага өгсөн байгаа. Энэ албан шаардлагын дагуу бид нар арга хэмжээ аваад, холбогдох зөвлөмжийн дагуу ажиллаад явж байгаа.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Яг ажлаа хийж байгаа нь та нар шүү дээ. Тэгэхээр та нар өөрсдөө яг 50 хувиар утааг бууруулсан гэж үзэж байна уу? Та нар өөрсдөө юм мэдэхгүй сууж байтал ер нь эрдэм шинжилгээний байгууллага, ус, цаг уурынхан л 50 хувиар бууруулсан гээд байгаа юм байна шүү дээ. Тэгж ойлгож болох уу? Тэгээд 24 оны 3 сарын 25-ны Үндэсний аудитын газар гэсэн тайлан байгаад байна л даа. Энэ дээр хариуцлага хүлээсэн үү л гэж би асуугаад байгаа юм. Улсын Их Хурал бол хууль мөрдүүлдэг, хянан шалгах эрх мэдэлтэй, дээрээс нь хариуцлага тооцно л доо. Тэгээд бид нарын хувьцаа эзэмшигчдийн мөнгийг авчхаад 68 тэрбумаар нь зөрчил хийчхээд байхад хариуцлага хүлээгээгүй байгаад байгаа байхгүй юу. Хариуцлага хүлээсэн үү?

Дээрээс нь наад та нар өөрсдөө яг наад юугаа ажлаа хийж байгаа 50 хувиар буурсан юм уу утаа? Эсвэл зүгээр хөндлөнгийн байгууллагууд 50 хувиар буурсан гээд гүтгээд байгаа юм уу? Эсвэл магтаад байгаа юм уу? Хувьцаа эз.../минут дуусав./

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн 68 тэрбум төгрөгийн зөрчилтэй байна гээд Аудит хөндлөнгөөс дүгнэхээд байхад энэ дээр хариуцлага тооцно уу? Хэрвээ тооцоогүй бол дахиад олон тэрбум төгрөгийн зөрчил гарах үүд хаалга нь байна, хэвээрээ байна. Энэ дээр Их Хурлын гишүүдэд буюу ард иргэдэд хариулт өгөөч л гэж байна.

1 номер. 1 номерын Ерөнхий захирал хариулах юм уу? 5 номерын микрофоныг нээж өгье. Батзориг.

А.Батзориг: Ер нь нийтдээ 68 тэрбумын биет бус ер нь зөрчил илэрсэн байгаа. Энэ дотор бол 5 тэрбум орчим нь болохоороо шилэн дансаа дутуу хөтөлсөн гэх мэтийн ийм зөрчлүүд байгаа. Тэгэхээр яг энийг бол яг бодитой зөрчил гэж бас үзээгүй. Энэ засаж залруулах, цаашидаа ийм алдаа гаргахгүй байх гэсэн тийм албан шаардлагууд энэ дотор байж байгаа.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн дутуу хариуллаа. Та алив нэг тодруулчих даа. Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Шилэн дансны хөтлөлт дутуу гэдэг юм энд алга даргаа. Дээрээс нь 50 хувиар утаа буурсан гээд байгаа шүү дээ. Та нар өөрсдөө тэгж үзэж байгаа юм уу? Дахиад 50 хувиар ирэх жил буурчихна гээд байна шүү дээ. Утаагүй болох юм байна шүү дээ. Тэгэхээр хөндлөнгийн байгууллагууд гээд байгаа шүү дээ та, хөндлөнгийн байгууллага гүтгээд байгаа юм уу, магтаад байгаа юм уу? Тэгээд наад дээр чинь хариуцлага хүлээгээгүй юм байна тээ? Энэ бол шаль бус, шилэн дансны л асуудал байгаа юм байна гэж үзээд байгаа юм уу?

С.Ганбаатар: Тодруулъя 6 номер.

Д.Өлзийбат: Тэр утаа буурсан

С.Ганбаатар: Хэн билээ?

Д.Өлзийбат: Ерөнхий технологич Өлзийбат.

Утаа буурсан эсэх дээр хариулт өгье. Бид нар өмнө нь түүхий нүүрс түлж байхад Багануурын нүүрс буюу бид нарын хэлж заншсанаар түүхий нүүрс ашиглаж байсан. Энийг түлж байхад бид нарт агаарт дэгдэж байгаа дэгдэмхий бодис бол, бид нарын нөгөө стандарт гэж ярьдаг. Стандарт дээрээ Багануурын нүүрс 44 хувийн дэгдэмхий бодистой.

Бидний өнөөдрийн хэрэглэж байгаа Энержи Ресурс-ийн Ухаа-гийн баяжуулсан нүүрсний дэгдэмхий бодис буюу бид нарын яг өнөөдрийн түлж байгаа шахмал түлшний дэгдэмхий бодис 22 хувьтай байгаа. Стандарт дээр тэгж батлагдсан. Бид нар энэ стандарт шаардлагыг хангаад явж байгаа юм. Тэгэхээр зэрэг бид нараас шаталтаас ялгарч байгаа дэгдэмхий бодис буюу утааны, утаан дотор агуулагдах тоосонцрын хэмжээ 50 орчим хувиар буурсан гэдэг нь одоо эндээс нэгд шууд харж болох юм.

Хоёрт, мэргэжлийн байгууллагын тэр явуулын станц Ус, цаг уур, орчны хүрээлэнгийн нийтдээ 19 цэг байдаг юм байна лээ. Тэр 19 цэгийн мэдээлэл нь болохоор зэрэг.../минут дуусав./

С.Ганбаатар: 6 номерын гүйцээж хариулъя.

Д.Өлзийбат: Тэгээд энэ дэгдэмхий бодисын агууламж бол бид нар 2 дахин буурсан. Энэ нь өөрөө бид нарын утаа тодорхой хэмжээгээр 50 хувь буурсан гэдэг нь эндээс харагдах юм байгаа юм. Бид нар болохоор зэрэг энийг шинжлэх ухааны юугаар л хэлж байна шүү дээ. Шууд бид нар буурчихсан гээд амаар хэлж байгаа юм биш. Хэрэглэж байгаа үндсэн түүхий эд маань өөрөө 2 дахин дэгдэмхий бодисын агууламж багатай түүхий эд хэрэглэж байна гэж хэлж байгаа. Түүхий нүүрстэй харьцуулахад 2 дахин бага.

С.Ганбаатар: 5 номерт гүйцээж хариулъя.

А.Батзориг: Нийтдээ 13 зөрчил илэрсэн гэж байгаа юм. Хэрвээ манай дээр акт, албан шаардлага, зөрчил гэсэн ийм 3 л юмаар Үндэсний Аудит бид нарт юу яаж байгаа? Тэгэхээр манай дээр акт гараагүй. Акт гараагүй учраас хариуцлага тооцоогүй гэсэн үг. 13 юу чинь, албан шаардлага болон зөвлөмжүүд байгаа учраас бид нар энэнийхээ дагуу арга хэмжээ аваад явчихсан.

С.Ганбаатар: Ер нь аудит бараг буруу дүгнэгдсэн юм уу л гэж би ойлгочихлоо шүү. Тэгээд аудитаас тодруулъя. Энэ асуудлаараа дэлгэрэнгүй материалуудаа Мөнхбаясгалан гишүүнд явуулаарай. Бид ард иргэдийн өмнөөс асууж байгаа гэдгийг дахин илэрхийлье. Ингээд Очирбат гишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Оройн мэнд хүргэе.

Тавантолгой төвөөс ч хэцүү л дээ. Тэгээд очоод уулзахаар анхнаасаа буруу ишийдвэр гарчихсан юм гэж ярьдаг мэргэжилтнүүд, инженерүүдээ, дарга нар. Ер нь энэ түрүүн хэлж байна шүү дээ бас юм шатааж л байвал угаар, хорт хий үйлдвэрлэж л байна гэж байгаа

Бүгдээрээ мэдэж байгаа. Бид нар урьд нь Багануурын нүүр хэрэглэдэг байсан чийглэг 37.5, үнслэг 17.5, стандарт нь шүү, дэгдэмхий бодис түрүүний хэлдэг 44.8 тээ? Хүхэр 3.38 байсан тийм үү? 0.38, 0.38 шүү. Одоо Тавантолгойн түлш чийглэг 5, үнслэг 22 болчихсон шүү. Дэгдэмхий бодис яах вэ, 20 гээд бууруулчихсан гээд байгаа юм. 22 гээд байгаа юм. Хүхэр чинь 1 бүхэл, 1.

Тэгэхээр энийгээ та хэд зөв хариулна шүү. Үнэхээр түрүүний Лувсанжамц гишүүний асуудаг асуулт зөв байхгүй юу. Ялт ч үгүй үнэртээд байгаа, хордоод байгаа. Энэ бол хүхэр. Багануурын нүүрсийг ашигладаг байхад 0.38 байсан бол одоо Тавантолгой түлш бол 1 бүхэл байгаа. Нэг.

Энэ дээр яг ийм бодитой юу, үгүй юу та хэд? Би стандарт ярьж байгаа болохоор хариулчхаарай. Бодитой бол бодитой юм гэдгээ л хэлчих. Тэгээд л болоо.

Хоёр. Та хэд бас би 1 сард очиж байсан. Сонгинохайрхан дүүргийнхэн нүүгээд ийшээ явчихсан тээ? Багануур руу явчихсан уу, нүүчихсэн үү? Нүүчихсэн байгаа тээ? Оччихсон, нүүчихсэн байгаа. Нүүгээд очиход технологийн шинэчлэлт гайгүй болоод энэ стандарт өшөө бас жоохон доошлох юм гэж ярьж байсан тухайн үед. Тэгэхээр яг тэр үр дүн ямар байгаа вэ? Энэ дээр хэлээд өгчихье. Хариултад хариулт өгчхөөрэй.

Дахиад 1.2 их наяд төгрөг шүү 2018 оноос хойш тээ? 2018 онд “Тавантолгой түлш” компани үүсгэн байгуулагдаж байсан. 1.2 их наяд төгрөг. Энэ 1.2 их наяд төгрөгөөр бид нар юу гэдэг юм, сэргээгдэх эрчим хүч рүү хөрөнгө оруулалт хийсэн бол өнөөдрийн энэ нөхцөл байдал ямар байх ёстой байсан бэ гээд ийм 3 асуулт дээр эхлээд асуулт авчихъя. Та хэд мэргэжлийн хүмүүс байгаа болохоор. Хариулт авчихъя тэгээд тодруулъя тэгэх үү?

С.Ганбаатар: Хэн хариулах вэ? 6 номер технологич. 6 номерын микрофоныг нээж өгье.

Д.Өлзийбат: Очирбат гишүүний асуултад хариулъя. Сая Багануурын нүүрсний стандарт болон Тавантолгой түлшний MNS 5679:2022 гэсэн стандартыг харьцуулсан байдлаар асуулаа. Стандарт дээр бол чийглэг 6 хувиас ихгүй, үнслэг 27 хувиас ихгүй, дэгдэмхий бодис 22 хувиас ихгүй, хүхэр 1 хувиас ихгүй гэж заасан байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ стандартыг гаргахад эд нарын үндсэн түүхий эд гэж би түрүүн ярьсан. Үндсэн түүхий эд буюу Энержи Ресурс-ийн Ухаа худаг-ийн мидлинг маань өөрөө үндэслэх нь 28 хувьтай байдаг. Дэгдэмхий бодис нь 26 хувиас ихгүй гэж заасан. Хүхэр нь 1.3 хувиас ихгүй гэж заасан байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ Энержи Ресурс-ээс авч байгаа мидлинг маань манай шахмал түлшний 95 хувийг бүрдүүлдэг учраас яг энэ стандартыг бид нар мөрдөөд явж байна. Яг өнөөдрийн байдлаар бид нарын хүхэр бол бодит байдал дээр 0.8-0.9 хувьтай байгаа. 7 метрийн орцтой барьцалдуулагчийг бид нар хэрэглээд хүхэрлэг хийг 30 хувь орчим бууруулсан гэж би түрүүн хариулсан. Би стандарттай холбоотой асуултыг нь хариулчихлаа.

С.Ганбаатар: Дараагийнх нь гүйцээж хариулъя. 2 номер гүйцээж хариулъя.

Ц.Алтансүх: Гишүүний асуултад хариулъя. Ерөнхий инженер Алтансүх.

Яг 1.2 их наядаар сэргээгдэх эрчим хүч ч юм уу, нэг бол энэ ДЦС-д хөрөнгө оруулсан бол хэр хэмжээний цахилгаан чадал, дулааны ачаалал нэмэгдэх байсныг бид нар нарийн хэлж мэдэхгүй байна. Энийг эрчим хүчний мэргэжлийн юунаас тодруулга авсан нь дээр байх. Бид нар энэ 1.2 их наяд дээр ямар цахилгаан ачаалал буюу дулааны ачаалал ямар хэмжээгээр нэмэгдэх байсныг хариулах боломж байхгүй байна.

Ер нь богино хугацааны бодлогын хувьд түүхий нүүрснээс мидлингээр хийсэн шахмал түли рүү шилжсэн нь бодлогын хувьд зөв байсан гэдэгт итгэлтэй байгаа.

С.Ганбаатар: Золжаргал гишүүн асуулт асуугаад тэр дээрээс саяын, Очирбат гишүүн тодруулчихъя.

Г.Очирбат: Энэ тэгээд их сонин байхгүй юу. MNS 5679:2022 стандартыг манай “Тавантолгой түли” компани өөрсдөө батлуулж байсан тээ, тийм биз? Яагаад гэхээр манайд стандарт байхгүй байсан байхгүй юу. Тэгээд яагаад энэ стандартыг “Тавантолгой түли” компани батлуулсан юм бэ гэхээр цаанаас ирж байгаа үндсэн түүхий эд тэртээ тэргүй энд гарч байгаа үр дүнг авчирч ирээд батлуулчихсан. Олон улсын стандарт ялангуяа энэ бид нар энэ хойд хөршөө харахаар энэнээс дандаа бага байдаг. 1 дахин бага нь стандарт.

Тэгэхээр өөрөө өөртөө зориулж ийм стандарт гаргаж байна гэдэг бол бодлогын асар том алдаа шүү. Нэгд.

Хоёрт гэх юм бол яндан гал түлж байх тохиолдолд утаа, угаар байж л байна, хүхэр үйлдвэрлэгдэж л байна. Тэгэхээр энэ дээр манай та хэд нөгөө мэргэжлийн хүмүүс болохоор хойшдоо энэ рүү хөрөнгө оруулалт хийх биш, илүү тийм ухаалаг технологи, инженер, эрчим хүчний салбар руу хөрөнгө оруулалт юмаа дэмжиж бас дуу хоолой болж өгөөрэй л гэж хүсэх гэсэн юм.

С.Ганбаатар: Үг хэллээ. Золжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Золжаргал: Саяын Очирбат гишүүний асуудаг асуулт бас үндэслэлтэй. Ер нь энэ хэд бол ажил хийж байгаа хүмүүс шүү дээ. Үйлдвэрээ ажиллуулж байгаа. Түлшний шийдэл бол бүүр анхнаасаа улс төрийн шийдэл байсан юм. Цэвэр техникийн биш. Олон жил бас ярьж байгаа. Тэгэхээр яах вэ цаашидаа гэдгээ бас бодох хэрэгтэй байх. Би өөрөө энэ түлшний хий, шингэн, хатуу түлшний чиглэлээр ажиллаж байсан инженер хүний хувьд бас хэлэх юм байна. Нүүрс төрөгч гээд ийм хатуу хар юм нь ихсэх тусмаа утаа бага гардаг юм. Дэгдэмхий гээд байгаа юм. Тэр нь бага байх юм бол, юу ихсэх тусмаа утаа гарна, их бага гарна. Дэгдэмхий бодис гээд ийм тортог шиг ийм дотроо шингэн хий ихтэй бол утаа их гардаг юм. Тэгэхдээ утаа багатай түлшийг шатаахын тулд илүү их

агаар хэрэгтэй болдог. Тэр агаар нь гэрийн зуух өгч чаддаггүй юм. Дутуу агаар өгөхөөр шатааж CO2 ялгарахын оронд угаарын хий гардаг. Ялгарсан угаарын хийг нь яндангаар гаргахгүй амсраар гаргах юм бол хүн үхдэг, хорддог. Ер нь ийм л зүйл.

Тэгэхээр бид нар утаа багатай сайн түлш хэрэглэх юм бол шаталт нь муу гэсэн үг. Тэгээд тэр мидлинг, одоо хэрэглэж байгаа энэ түлшний ойролцоогоор 30 хувь нь, 25-30 хувь нь чулуу. Өөрөөр хэлбэл, үнслэг өндөртэй. Тэгэхээр шаталт нь тийм идэвхтэй биш байхгүй юу. Тийм болохоор угаарын ялгардаг.

Одоо би нэг санаа зовоод байгаа юм нь хагас коксод шилжинэ. Хагас кокс бол бүүр илүү их нүүрстөрөгчтэй бүүр бага утаа гарна. Гэхдээ бүүр их агаар өгч байж шатна. Тэр дутуу шатах юм бол угаарын хий гарна. Угаарын хийгээ яндангаар гарахгүй бол хордоно.

Баяжуулсан эрчим хүчний нүүрсийг түлшиндээ хольж ашиглах талаар бас санаа оноо явж байсан. Тэгээд би та бүхнийг энэ хувилбарыг туршилт судалгаа хийж үзсэн болов уу, ер нь энэ тал дээр юу бодож байгаа вэ гэж асуух гэсэн юм. Баяжуулсан эрчим хүчний нүүрс бол дэгдэмхий ихтэй буюу тортогтой, утаа ихтэй, гэхдээ шаталт нь бүрэн байх. Тэгээд энэ олон улсын стандарт гээд түрүүн бас яриад байсан л даа. Тэр ер нь баяжуулсан, жигдхэн ширхэгтэй эрчим хүчний нүүрсийг түлшинд хэрэглэдэг л дээ. Тэгээд энэ тал дээр хаачихсан байгаа юу, нээлттэй байгаа юу? Туршилт, дүгнэлт хийсэн юм байгаа юу гэж асуумаар байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Маш технологийн мэргэжлийн асуулт асуулаа. 6 номер хариулах уу? 6 номер.

Д.Өлзийбат: Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө баяжуулсан эрчим хүчний нүүрсийг өнгөрсөн 2023 оны Эрчим хүчний яамтай хамтарсан ажлын хэсэг дээр кокс болон баяжуулсан эрчим хүчний нүүрсийг шахмал түлшинд ашиглах гэсэн туршилтын ажлыг хамт хийсэн. Энэ дээр маш өндөр үр дүнтэй байсан туршилтын үр дүнгээр. Тухайлбал, дэгдэмхий бодис нь бид нарын ашиглаж байгаа 22 хувиас даруй 4-5 нэгж буурсан, 18 хувь хүртэл буурч, буурсан үзүүлэлттэй гарсан. Үнслэг мөн тодорхой хэмжээгээр буюу бид нар яг өнөөдрийн бид нарын хэрэглэж байгаа шахмал түлш хэдийн стандарт дээр 27 гээд заачихсан боловч яг өнөөдрийн бид нарын шинжилгээний үр дүнгээр бол 22 хувиас бага байгаа юм.

Баяжуулсан нүүрсийг ашигласан үед бид нарын шахмал түлш дээр 17 хувийн үнслэгтэй, хүхэр нь 0.5 хувь хүртэл буурсан тийм үзүүлэлттэй байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар цаашидаа баяжуулсан эрчим, баяжуулсан нүүрсийг шахмал түлшинд ашиглах нь бол зохимжтой гэдэг бас дүгнэлт гарсан. Хагас кокс болон баяжуулсан нүүрсийг хоёуланг нь ашигласан. Энэ хоёр нүүрс, баяжуулсан нүүрсээ ЕТТ-ээс авч ашигласан. Хагас коксоо бид нар дотоодын болон импортын хагас коксоор түлш үйлдвэрлэж, энэ туршилтын ажлыг хийж гүйцэтгэсэн байгаа.

С.Ганбаатар: Золжаргал гишүүн тодруулъя.

С Ж.Золжаргал: Энэ утаа эхлэхээр ер нь яриа эхэлнэ гэж бодоод ярихгүй байсан. Тэгэхдээ эхэлчихлээ яах аргагүй. Ер нь түлш дээр би Байнгын хорооны даргад л санал болгох гээд байна л даа. Технологийн, стандартын чиглэлээр бид нар тусдаа бас ярих цаг гарах байх. Тийм шаардлага бол ирэх байх.

С.Ганбаатар: Үндсэндээ гишүүд асуулт асууж, хариултуудаа авлаа.

Миний хувьд яах вэ, яг өмнөх орсон асуудлууд дээр олон зуун сая доллар яригдаж, олон асуудлууд байгаа. Гишүүд маань нэлээн идэвхтэй, нэлээн бас агресс тийм нэлээн асуулт асуусан. Энэ дээр аль болохоор бас ард иргэдийн бэрхиээлийг шийдээж байгаа, тэгээд олон дамжчихсан, урд хөл бүдрэхэд хойд хөлийг ташуурдана гэлтэй нь биш дээ энэ дээр бол энэ цогцоороо том бэрхиээлүүд байгаа. Анхнаасаа улс төрийн шийдэл байсан. Энэ дээр бас энэ асуудлыг ойлгож гишүүд бас нэлээн хүлээцтэй хандаж байгаа гэдгийг илэрхийлээд, ард иргэдэд мэдээлэл өгөх, өнөөдөр өвөлжилтийн байдал яаж байна. Ерөөсөө энэ ингээд 1.2 их наяд өр нэмэгдээд л байдаг, ард түмний татварын мөнгөөр л өр нэмэгдээд байдаг үр дүн байна уу? Байгаа бол цаашид яах вэ гэдэг дээр шийдэл гаргая гэсэн уулзалт, яриа, сонсгол, тэгээд гишүүдийн заримаас санал гарч байна. Бас тодорхой гишүүд ярьсан. Ажлын хэсэг байгуулах шаардлагатай бол гишүүдтэйгээ ярилцаж дараа нь шийдэх юм байна. Технологийн шийдлүүд болон Золжаргал сая гишүүн хэлсэн.

Ингээд 1.2 их наядыг авсан байна гэдэг чинь цаад утгаараа 100 сая төгрөгөөр энэ чинь 12 мянган байр гэсэн үг шүү дээ. 12 мянган байр бариад хэд, мянган байраар энэ чинь 12 хороолол барьчихсан бол Улаанбаатарын асуудлууд яаж шийдэгдэх бол оо гэдэг асуудлыг л бид харьцуулж ярьж байгаа.

50 сая төгрөгөөр ингээд орон сууцын хөнгөлөлт үзүүлнэ гээд тооцох юм бол энэ бол 24 мянган байр. 24 мянган айлын орон сууц гэсэн санаа юм уу даа, 24 хороолол. Ийм ийм шийдлүүдийг гаргаж асуудлуудыг ярина. Дараагийн ээлжид гишүүдэд та бүхэн бас мэргэжлийн түвшинд яг улаан шугам дээр нь ингээд халуун хоёр гараараа ингээд тулаад явж байгаагийн хувьд гарц шийдэл, гарц гаргалгаа гаргаж ард иргэдийнхээ төлөө биднүүс бас хамтдаа шийдэл гаргана гэж ойлгож байна.

Та бүхнээс мэдээлэл авлаа. Өнөөдрийн сонсголыг өндөрлүүлье.

Гишүүд түр байгаад 2-хон минут би зөвлөлдөх юм байгаа шүү. Тийм, зөвлөлдөх юм байгаа шүү. Байнгын хорооныхон бол байгаарай. Байгаад 2-хон минут.

Өнөөдрийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хурлыг хаасныг мэдэгдье.

18.35 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

